

МОНГОЛ УЛС ДАХЬ ХУУРАМЧ МЭДЭЭЛЛИЙН ЗУРАГЛАЛЫН СУДАЛГАА

Судалгааны тайлан



Товчилсон үгийн жагсаалт

АНУ	Америкийн Нэгдсэн Улс
АТГ	Авлигатай тэмцэх газар
БНХАУ	Бүгд Найрамдах Хятад Ард Улс
МСНЭ	Монголын Сэтгүүлчдийн нэгдсэн эвлэл
НҮБ	Нэгдсэн Үндэстний Байгууллага
ОНЦМА	Олон нийтийн цахим мэдээллийн ажилтан
ОХУ	Оросын Холбооны Улс
СЕХ	Сонгуулийн ерөнхий хороо
ТББ	Төрийн бус байгууллага
ХАА	Хөдөө аж ахуй
ХЭҮК	Хүний эрхийн үндэсний комисс
ХХЗХ	Харилцаа холбооны зохицуулах хороо
МХХТ	Мэдээлэл, харилцаа холбооны технологи
УИХ	Улсын Их Хурал
ҮСХ	Үндэсний статистикийн хороо
ЦХИХХЯ	Цахим хөгжил, инновац, харилцаа холбооны яам
ЮНЕСКО	Нэгдсэн Үндэстний Байгууллагын Боловсрол, шинжлэх ухаан, соёлын байгууллага
ЭЗХАХБ	Эдийн засгийн хамтын ажиллагаа, хөгжлийн байгууллага (OECD)
COVID-19	Коронавирусын халдварт өвчин
MFCC	Монголын баримт шалгах төв
NEST	Сэтгүүл зүйн Инновац, Хөгжлийн Үүр төв НҮТББ
TED	Европын Холбооны ардчилал, хүний эрх, хууль дээдлэх ёсыг дэмжих санаачилга
INCITEGov	International Center for Innovation, Transformation and Excellence in Governance
IRIM	Хараат бус судалгааны хүрээлэн
V-Dem	<i>Varieties of Democracy Institute</i> ; ардчиллын чанар, институц, эрх чөлөөний үзүүлэлтүүдийг хэмжих олон улсын судалгааны хүрээлэн

Агуулга

Товчилсон үгийн жагсаалт	1
Хураангуй	3
Удиртгал	7
Арга зүй	9
Зорилго, зорилт	9
Судалгааны хамрах хүрээ	9
Шинжилгээний хүрээ	9
Мэдээлэл цуглуулсан аргууд	10
1.Хуурамч мэдээллийн нөхцөл байдлын тойм	11
1.1 Хуурамч мэдээллийг бүтээж, түгээж буй талууд, тэдний эрх ашиг, мэдээллийн төрлүүд	12
1.1.1 Засгийн газар, төрийн байгууллагууд	12
1.1.2 Дотоодын улс төрчид, улс төрийн намууд	13
1.1.3 Гадаад оролцогчид	14
1.1.4 Пи-ар болон медиа багууд	15
1.1.5 Хэвлэл мэдээллийн байгууллага, сэтгүүлчид	15
1.1.6 Сошиал медиа инфлюенсерүүд, олны танил	16
1.1.7 Тролл сүлжээ	17
1.1.8 Иргэд, олон нийт	18
1.2 Хуурамч мэдээлэл түгээж буй суваг, арга техникүүд	18
1.2.1 Сошиал медиа ба арга техникүүд	18
1.2.2 Хэвлэл мэдээллийн хэрэгслүүд ба арга техникүүд	21
1.3 Хуурамч мэдээллийн агуулга	21
2.Хуурамч мэдээллийн үр нөлөө	26
2.1 Хуурамч мэдээллийн нийгмийн түвшний үр нөлөө	27
2.2 Хуурамч мэдээллийн хувь хүнд үзүүлж буй нөлөө	34
3. Авч хэрэгжүүлж буй арга хэмжээнүүд	38
3.1 Хуурамч мэдээлэлтэй тэмцэж буй эрх зүй, бодлогын арга хэмжээнүүд	38
3.2 Олон нийтийн боловсрол, нийгмийн дархлаа	43
3.3 Институцийн чадавх, хамтын ажиллагаа	45
3.4 Хүний эрхийг хамгаалах, дэмжих	47
3.5 Хуурамч мэдээллийг зохицуулах бусад оролдогууд	48
4. Тулгамдсан асуудлууд	49
Дүгнэлт	54
Зөвлөмж	56
Ашигласан материалын жагсаалт	59

Хүснэгт, дүрсийн жагсаалт

Хүснэгт 1. Судалгааны хүрээ	9
Хүснэгт 2. Мэдээлэл цуглуулах аргууд	10
Хүснэгт 3. Хуурамч мэдээлэлд өртөх эмзэг байдлыг нэмэгдүүлэгч болон бууруулагч хүчин зүйлс	36
Хүснэгт 4.Хуурамч мэдээлэлд хамгийн эмзэг өртөмтгий бүлгийн тоо	37
Дүрс 1. Монгол дахь хуурамч мэдээллийн оролцогч талууд.....	12
Дүрс 2. Фейсбүүк дэх хуурамч мэдээллийн тархалтын урсгал	20
Дүрс 3. Хуурамч мэдээллийн сэдвүүд, (n=1618).....	22
Дүрс 4. Вакцины тухай сэдэвтэй мэдээллийн тоо, сараар	23
Дүрс 5. Нягтлагдсан хуурамч мэдээллийн тоо, сараар.....	23
Дүрс 6. Хуурамч мэдээлэлд ашиглаж буй аргууд (n=1618).....	24
Дүрс 7. Уран олборлох тухай сэдэвтэй мэдээллийн тоо, сараар.....	25
Дүрс 8. Монголд хуурамч мэдээлэл ардчиллыг сулруулахад хэрхэн нөлөөлж буй байдал	27
Дүрс 9. Монголчуудын бие биедээ итгэх итгэлцэлд гарч буй өөрчлөлт, 0-10 хүртэлх шкалын дундаж утга 2018, 2022	28
Дүрс 10. Ерөнхийд нь хэлбэл ихэнх хүмүүст итгэж болно гэж боддог уу?, 2018, 2022	28
Дүрс 11. Хуурамч мэдээллийг ноцтой асуудал гэж авч үзэж буй иргэдийн хэвлэл мэдээллийн байгууллагад хандах хандлага, 2021, 2024	29
Дүрс 12. Хуурамч мэдээллийг ноцтой асуудал гэж авч үзэж буй иргэдийн төрийн байгууллагуудыг авч үзэх сөрөг хандлага, 2021, 2024	30
Дүрс 13. Төрийн байгууллагуудад итгэх итгэлийн түвшин, 2014, 2018, 2022	31
Дүрс 14. Найзууд эсвэл хамт ажиллагсдын улс төрийн үзэл бодол өөр байвал, тэдэнтэй ойлголцож ярилцахад бэрхшээлтэй байдаг гэж хариулсан иргэдийн хувь	31
Дүрс 15. Монголчуудын улс төрийн хуваагдал, 1999-2024.....	32
Дүрс 16. Хуурамч мэдээлэлтэй тэмцэх хүрээнд санал болгож буй арга хэмжээний хүрээ.....	39
Дүрс 17. Монгол дахь хуурамч мэдээлэлтэй тэмцэж буй оролдлогууд	39
Дүрс 18. Цагдаагийн байгууллагад ирсэн болон шийдвэрлэсэн гомдлын тоо, мөн “хуурамч мэдээлэл”-ийн хэргүүдийг мөрдөн шалгасан статистик.....	40
Дүрс 19. И-Монгол Академийн дижитал ур чадварын сургалтад хамрагдсан оролцогчдын тоо	44
Дүрс 20. Монгол дахь Хуурамч мэдээллийн нөхцөл байдлын зураглал	49
Дүрс 21. Хуулийн засаглалын индекс, Монгол Улс	51
Дүрс 22. Дуу хоолой ба хариуцлагын индекс, Монгол Улс.....	51
Дүрс 23. Хэвлэлийн эрх чөлөөний индекс, Монгол Улс.....	52

Хураангуй

IRIM судалгааны хүрээлэн Филиппин дэх Засаглалын инновац, өөрчлөлт шинэчлэл, шилдэг туршлагын олон улсын төв (INCITEGov)-тэй хамтран **‘Хуурамч мэдээлэлтэй тэмцэх замаар ардчилал, шударга ёсыг бэхжүүлэх нь’** төслийг хэрэгжүүлж байна. Европын Холбооны ‘Team Europe Democracy (TED)’ санаачилгын тэтгэлгээр хэрэгжиж буй уг төсөл нь нотолгоонд суурилсан, олон нийт төвтэй аргачлалаар Монгол болон Филиппин улсад хуурамч мэдээлэлтэй тэмцэх, ардчилсан үнэт зүйлсийг бэхжүүлэх үр дүнтэй арга замуудыг тодорхойлох зорилготой.

Төслийн эхний үе шат болох түргэвчилсэн зураглалын судалгааг 2025 оны 7–11 сарын хугацаанд хэрэгжүүлэв. Судалгаагаар Монгол дахь хуурамч мэдээллийн нөхцөл байдлыг цогц байдлаар зураглаж, хуурамч мэдээллийг хэрхэн бүтээж, түгээж, хувь хүн болон нийгэмд ямар нөлөө үзүүлж, түүний эсрэг ямар арга хэмжээнүүд авч хэрэгжүүлж буй болон ямар дутагдал, бэрхшээл байгааг тодруулахыг зорилоо.

Судалгааны үр дүнгээр **Монгол дахь хуурамч мэдээллийг, ялангуяа тогтвортой үргэлжлэх, эрчимтэй давтагддаг эсвэл томоохон эрх ашигтай уялдсан өгүүлэмжүүдийг нэг хувь хүн бус олон талууд хамтарч бүтээж, түгээж байна.** Засгийн газар, төрийн байгууллагуудын албан тушаалтнууд, дотоодын улс төрчид, улс төрийн намууд олон нийтийн санаа бодлыг чиглүүлэх эсвэл өрсөлдөгчөө харлуулах зорилгоор хуурамч мэдээллийн гол захиалагч, бүтээгч тал болон оролцож байна. Түүнчлэн, гаднын оролцогч талууд, тэр дундаа бидний хөрш ОХУ болон БНХАУ нь Монгол Улсын мэдээллийн орон зайд хуурамч мэдээлэл бүтээж, түгээхэд оролцдог онцлог талуудаар нэрлэгдэж байна. Худал, төөрөгдүүлсэн мэдээллийг зохион байгуулж, түгээхэд олон талууд оролцож буй ба үүнд хуурамч мэдээллийн кампанит ажлууд зохион байгуулдаг мэргэжлийн пи-ар, медиа багууд, нэг талыг барьсан, санхүүгийн хувьд хараат хэвлэл мэдээлэл, нийгмийн сүлжээн дэх инфлюенсерүүд, хуурамч өгүүлэмжүүдийг өдөөдөг тролл сүлжээ зэрэг багтана. Энгийн иргэд ч мөн анхаарал татсан, худал түүх, мэдээллийг санаатай болон санаандгүй байдлаар цааш түгээж, өдөөгчийн үүрэгтэй оролцдог байна.

Хуурамч мэдээллийн гол талбар нь сошиал медиа, тэр дундаа монголчуудын хамгийн ихээр ашигладаг Фэйсбүүк байна. Хуурамч хаягууд, зохион байгуулалттай тролл сүлжээнүүд нь хуурамч мэдээллийг асар өргөн хүрээнд түгээж, сошиал медиа алгоритмууд болон “boost” буюу төлбөрт сурталчилгааны тусламжтайгаар анхаарал татахуйц худал агуулгууд олон тооны хэрэглэгчдэд хурдацтайгаар хүрч байна. Харин уламжлалт хэвлэл мэдээллийн байгууллагууд илт хуурамч мэдээлэл түгээх нь харьцангуй бага ч улс төр, бизнесийн ашиг сонирхлоос хараат байснаар мэдээллийг нэг талын өнцгөөс түгээх эсвэл мэдээллийн манипуляц хийхэд оролцож байна.

Монгол Улсад эрүүл мэнд, нийгэм, улс төр, санхүүгийн залилан шинжтэй хуурамч мэдээллийн агуулгууд хамгийн түгээмэл байна. Хуурамч өгүүлэмжүүд сонгууль, эрүүл мэндийн хөтөлбөр хэрэгжих үе зэрэг томоохон үйл явдлуудын үед идэвхжиж, олон нийтийн анхаарлыг татах төлөвтэй байна. Хуурамч мэдээллийг хүргэж буй хамгийн түгээмэл хэлбэрүүд нь худал өгүүлэмж, төөрөгдүүлсэн баримт, материал, cheerfake буюу эвлүүлэг ашигласан мэдээллүүд байв. Харин deerfake буюу хиймэл оюун ашигласан хуурамч мэдээллийн контент түгээх нь харьцангуй бага байгаа ч сүүлийн үед нэмэгдэж байна. **Монгол дахь улс төрийн агуулгатай хуурамч мэдээлэл нь ихэвчлэн гүтгэлгийн шинжтэй, баталгаажгаагүй сэрдлэг, хуйвалдааны онолын өнгө аястай өгүүлэмжүүд байна.** Ийм төрлийн мэдээллүүдийг олон нийтийн ойлголт, хандлагад нөлөөлөх зорилгоор төөрөгдүүлсэн дата мэдээлэл, сэтгэл хөдлөл өдөөсөн хэллэг, үндсэн агуулга, нөхцөл байдлыг нь мэдээлэхгүйгээр тасалж харуулсан зураг, дүрс зэргийг ашиглаж түгээдэг. Тухайлбал, 2025 оны ураны гэрээг тойрсон, үндэсний үзэл, гаднынхныг эсэргүүцэх өнгө аяс бүхий айдас төрүүлсэн шинжтэй хуурамч мэдээллүүдээс эдгээрийг харж болно.

Хуурамч мэдээллийн хувь хүний сайн сайхан байдал болон нийгэмд үзүүлэх нөлөө нь улам бүр нэмэгдэж байна. Нийгмийн түвшинд авч үзвэл, **хуурамч мэдээлэл нь олон нийтийн хэвлэл мэдээлэл, төр зэрэг гол институцүүдэд итгэх итгэлийг сулруулдаг**. Зөрчилтэй, төөрөгдүүлсэн хэт их мэдээлэл нь мэдээллийн бүх эх сурвалжид үл итгэх, эргэлзэх хандлагыг бий болгож, ардчилсан үйл явцад итгэх итгэл буурахад хүргэдэг. Ингэж итгэлцэл сулрах нь хуурамч мэдээллийн хамгийн ноцтой үр дагавар бөгөөд улс төрийн туйлшрал, нийгмийн хуваагдлыг гүнзгийрэхэд нөлөөлдөг. Түүнчлэн, хуурамч мэдээлэлтэй тэмцэх оролдлогуудыг бодлогогүй, зохисгүй хэрэгжүүлбэл үзэл бодлоо илэрхийлэх, хэвлэлийн эрх чөлөөнд халдаж, хүний эрхийн шинэ тутам асуудлуудыг бий болгох боломжтой. Эдгээр хүчин зүйлс нийлж ардчиллын тогтвортой байдал, ардчилсан тогтолцоонд итгэх олон нийтийн итгэлийг ганхуулж байна.

Хувь хүний түвшинд хуурамч мэдээлэл нь хүний сэтгэл зүй, сэтгэл хөдлөлд сөргөөр нөлөөлдөг. Зохиомол, бодит бус түүх, мэдээллийгн давтамж нэмэгдсэнээс монголчуудын стресс, түгшүүр, бухимдал нэмэгдэж, үйл явдлыг ойлгож, тайлбарлахад нөлөөлдөг танин мэдэхүйн гажуудал бий болж байна. Худал өгүүлэмжүүд нь сэтгэл хөдлөл дээр тоглож, айдас эсвэл уур бухимдлыг өдөөж, хүмүүсийн сэтгэл хөдлөлийг тогтворгүй болгохын зэрэгцээ нийгмийн тогтворгүй байдлыг өдөөн бий болгох боломжтой.

Хүн амын тодорхой бүлгүүд хуурамч мэдээлэлд илүү өртөмтгий байна. **Хэвлэл мэдээллийн болон цахим боловсрол муу, залуу эсвэл ахмад настай, хөдөө орон нутагт амьдардаг, боловсрол болон орлогын түвшин доогуур иргэд хуурамч мэдээлэлд итгэх, түүнийг дамжуулан түгээх хандлага харьцангуй өндөр байна.** Энэ мэт хувь хүний түвшний нөлөө нь зөвхөн хувь хүний сайн сайхан байдалд нөлөөлөөд зогсохгүй нийгмийн түвшний асуудлуудыг улам өдөөдөг. Учир нь хуурамч мэдээлэлд итгэсэн иргэд тэдгээрийг цааш түгээж, хамтын итгэлцлийг доройтуулдаг.

Энэхүү өсөн нэмэгдэж буй хуурамч мэдээлэлтэй тэмцэхийн тулд төр болон бусад талууд төрөл бүрийн арга хэмжээ авч хэрэгжүүлж байна. Гэвч **төрийн арга хэмжээнүүд уялдаагүй, хязгаарлагдмал бөгөөд илт худал мэдээллийг гэмт хэрэгт тооцсон Эрүүгийн хуулийн 13.14 дүгээр заалт зэрэг эрх зүйн арга хэрэгсэлд голчлон төвлөрч байна.** Энэхүү хуулийн заалт идэвхтэй хэрэглэгдэж буй (жилд дунджаар 500 орчим гомдол бүртгэгддэг ч ялах шатанд хүрдэг нь цөөн) ч хүчтэй шүүмжлэл дагуулсаар байна. Учир нь хэт өргөн хүрээтэй, тодорхой бус тодорхойлолт нь үг хэлэх эрх чөлөөг хэт эрүүжүүлэх, сэтгүүл зүйн үйл ажиллагааг сааруулах, хэвлэлийн эрх чөлөөг доройтуулах эрсдэлтэй¹. Төрөөс мөн зөрчилтэй контент, хаяг устгах байдлаар социал медиа платформуудтай хамтран ажилладаг. 2024 онд иргэд худал мэдээллийг танихад туслах цахим боловсролын хүрээ боловсруулан гаргасан байна. Хэдийгээр төрөөс болон бусад талуудаас хуурамч мэдээлэлтэй тэмцэх тодорхой бодлого, арга хэмжээг хэрэгжүүлж байгаа ч хуурамч мэдээллийн эсрэг цогц, уялдаатай бодлого байхгүй, нийгмийн сүлжээг хянах зорилготой эрх зүйн санаачлагууд нь үзэл бодлыг цэнзурдах эрсдэлтэй хэмээн олон нийтийн шүүмжлэл дагуулж байна. Тухайлбал ерөхийлөгчийн хориг тавьсан 2023 оны цахим орчинд хүний эрхийг хамгаалах тухай хуулийн төслийг дурдаж болно.

Хуурамч мэдээллийг сөрөн тэсвэрлэх чадавхыг бэхжүүлэхэд иргэний нийгэм, хэвлэл мэдээллийн байгууллагууд гол үүрэгтэй ажиллаж байна. Монголд Монголын баримт шалгах төв (MFCC) болон Fact Check Mongolia гэсэн хоёр хараат бус баримт шалгах төв 2020 оноос хойш үйл ажиллагаа явуулж байна. Тухайлбал, MFCC 2,000 орчим мэдээллийн баримт шалгаж, баримт шалгуулах боломжтой

¹ Үндсэн хуулийн цэцийн 2025 оны 11 дүгээр сарын 24, 25-ны өдрийн дунд суудлын хуралдаанаар Эрүүгийн хуулийн 13.14 дүгээр зүйл нь Үндсэн хууль зөрчсөн гэж дүгнэж, тус зүйлийг түдгэлзүүлэх шийдвэр гаргасан.

“АСУУ” нэртэй чатботыг 2024 онд нээсэн байна. Түүнчлэн төрийн бус байгууллагууд хэвлэл мэдээллийн боловсролыг дээшлүүлэх чиглэлд манлайлж, сургууль, олон нийтийн боловсролын хөтөлбөрт энэхүү сэдвийг нэвтрүүлж байна. Хэвлэл мэдээллийн хөгжлийн байгууллагууд хараат бус хэвлэл мэдээллийг бэхжүүлэх үүднээс сэтгүүлчдийг чадавхжуулах, хуулийн зөвлөгөө өгөх, өөрийн зохицуулалтаар дамжуулж ёс зүйн стандартыг сайжруулах, хэвлэлийн эрх чөлөөг дэмжих ажлууд хийж байна. Сэтгүүл зүйн Инновац, Хөгжлийн Үүр төв 2024 онд хэвлэл мэдээллийн болон төрийн бус байгууллагуудыг нэгтгэсэн “Баримт нэн тэргүүнд” сүлжээг сонгуулийн үеийн хуурамч мэдээлэлтэй тэмцэх зорилгоор байгуулжээ.

Хэдий энэ мэт ажлуудыг хэрэгжүүлж байгаа ч Монгол Улсын хариу арга хэмжээнд саад болж буй системийн чанартай олон сул тал, бэрхшээл оршсоор байна. **Цахимд холбогдох боломж нэмэгдэж, сошиал медиагийн хэрэглээ өндөр байгаа нь худал, ташаа мэдээлэл хариу арга хэмжээнээс илүү хурдтай, илүү өргөн хүрээнд тархах нөхцөлийг бүрдүүлж байна.** Шинэ технологиудын нөлөөгөөр өндөр түвшний хуурамч контент бүтээхэд илүү хялбар болж, одоогийн баримт шалгалтын чадавхаас түрүүлэн хөгжиж байна. Мэдээллийн салбарын эмзэг байдал энэ асуудлыг улам хүндрүүлж байна. Зах зээлийн хэмжээ бага атлаа хэдэн зуун хэвлэл мэдээллийн хэрэгсэл үйл ажиллагаа явуулж байгаа, олонх нь оршин тогтнохын тулд улс төрчдөөс хамааралтай эсвэл анхаарал татах “кликбэйт” агуулгад тулгуурлаж байна. Энэ нь сэтгүүл зүйн мэргэжлийн стандартыг сулруулж, сэтгүүл зүйн чанар суларсанаар худал мэдээлэл нэвтрэх боломжийг бий болгодог. **Хэвлэл мэдээллийн хараат бус байдал буурч, үүнийг сэтгүүлчдийн эсрэг гүтгэлэг болон “илт худал мэдээлэл”-тэй холбоотой хууль тогтоомж улам дордуулж байна.** Үүний улмаас өөрийн цензур нэмэгдэж, худал мэдээллийн сүлжээ, зохион байгуулалттай ажиллагааг илчлэх боломж хязгаарлагдаж байна. Нөгөөтээгүүр, төрийн зүгээс авч буй хариу арга хэмжээ ихэвчлэн цогц бус, реактив шинжтэй хэвээр байна. Эрх зүйн зохицуулалт, зөрчилтэй контент устгах зэрэг арга хэмжээнүүд нь зохион байгуулалттай кампанит ажил, түүний цаад эзэд, оролцогчдод чиглэхээс илүүтэйгээр нийтлэл, контент, хувь хүнд чиглэсэн шинжтэй хэвээр байна. Хуулийн хэрэгжилт зохистой биш, улс төрийн нөлөөнд автах боломжтой.

Эцэст нь иргэдийн дижитал боловсролын түвшин доогуур байгаа нь мэдээллийг шалгах, манипуляцыг сөрөн тэсвэрлэх чадварыг сулруулж байна. Хэвлэл мэдээллийн боловсрол болон шүүмжлэлт сэтгэлгээнд анхаарахгүйгээр зөвхөн техникийн болон хууль эрх зүйн арга хэмжээ хэрэгжүүлэх нь хязгаарлагдмал үр дүнтэй байх юм.

Удиртгал

IRIM судалгааны хүрээлэн нь Филиппин улсын Засаглалын инновац, өөрчлөлт шинэчлэл, шилдэг туршлагын олон улсын төв (INCITEGov)-тэй хамтран “Хуурамч мэдээлэлтэй тэмцэх замаар ардчилал, шударга ёсыг бэхжүүлэх нь” төслийг 2025 оны 6 сараас 2026 оны 6 сар хүртэлх хугацаанд хэрэгжүүлж байна. Европын Холбооны Team Europe Democracy (TED) санаачилгын санхүүжилттэй уг төсөл нь нотолгоонд суурилсан, олон нийтийн оролцоонд тулгуурласан аргачлалаар Монгол Улс болон Филиппин хоёр улсад хуурамч мэдээлэлтэй тэмцэх чадавхыг бэхжүүлэх, улмаар ардчилсан үнэт зүйлсийг хамгаалахад хувь нэмрээ оруулах зорилготой. Төслийг дараах дөрвөн үе шаттайгаар хэрэгжүүлэхээр төлөвлөсөн. Үүнд:

- (1) улс орон тус бүрд хуурамч мэдээллийн нөхцөл байдлын зураглалын судалгааг гүйцэтгэх;
- (2) иргэд, олон нийтийн мэдээлэлтэй харилцах зан үйлийн судалгаа хийх;
- (3) хуурамч мэдээлэлд хамгийн эмзэг өртөмтгий зорилтот бүлгүүдэд чиглэсэн нөлөөллийн загвар боловсруулж, турших;
- (4) төслийн үр дүн, сургамжийг бүс нутгийн бусад улс орнуудтай хуваалцах зэрэг ажлууд багтсан.

Энэхүү тайланд тусгагдсан Хуурамч мэдээллийн нөхцөл байдлын зураглалын судалгаа нь төслийн эхний шатны суурь судалгаа бөгөөд 2025 оны 7–11 сарын хооронд хийгдсэн. Судалгааны хүрээнд Монгол Улс дахь хуурамч мэдээллийн нөхцөл байдлыг цогцоор нь тодорхойлох, тухайлбал хуурамч мэдээлэлд оролцогч гол талууд, ашиглагдаж буй арга техник, түгээлтийн сувгууд, түгээмэл ажиглагдаж буй өгүүлэмж (нарратив), мөн хуурамч мэдээлэлтэй тэмцэх чиглэлээр хэрэгжүүлж буй бодлого, зохицуулалтын арга хэмжээнүүдийг системтэйгээр зураглахыг зорьсон. Үүнээс гадна хуурамч мэдээлэл нь хувь хүн болон нийгмийн түвшинд ямар нөлөө үзүүлж буйг түргэвчилсэн боловч нотолгоонд суурилсан байдлаар тодруулахыг зорьсон болно. Судалгаанд баримт бичгийн шинжилгээ, экспертүүдийн гүнзгийрүүлсэн ярилцлага, хоёрдогч эх сурвалжуудын өгөгдөл, мэдээллийг ашиглаж, харьцуулан баталгаажуулах аргаар тайланг боловсруулав.

Судалгааны хүрээ, арга зүйтэй холбоотой хэд хэдэн чухал онцлогийг уншигчдад тодорхой танилцуулах нь зүйтэй.

Нэгдүгээрт, төслийн үндсэн зорилго нь ардчиллын институц, үйл явцыг хуурамч мэдээллийн сөрөг нөлөөллөөс хамгаалах, бэхжүүлэх тул энэхүү судалгаа нь ардчилал, ардчилсан засаглалтай шууд хамааралтай хуурамч мэдээллийн өгүүлэмжүүдэд төвлөрсөн. Үүнд сонгуулийн үйл явц, улс төрийн институцүүд, улс төрийн намууд, нэр дэвшигчид, иргэний оролцоо, хүний эрх, засаглал, олон нийтийн итгэлцэл зэрэг өргөн хүрээний асуудлуудтай холбоотой хуурамч мэдээллийн хэлбэрүүд багтана. Харин эрүүл мэндийн хуурамч мэдээлэл, луйвар, залилангийн схемүүд, хувь хүнд чиглэсэн гүтгэлэг, доромжлол зэрэг бусад төрлийн хуурамч мэдээллүүдийг гүнзгийрүүлэн шинжлээгүй. Эдгээр нь нийгэм, эдийн засагт ноцтой сөрөг үр дагавартай хэдий ч өөрийн гэсэн онцлог, оролцогч талууд, зорилго, зохион байгуулалтын бүтэцтэй тул тусад нь нарийвчилсан судалгаа шаардлагатай гэж үзсэн болно. Иймээс уг судалгаанд эдгээр төрлийн хуурамч мэдээллийг санамсаргүйгээр орхигдуулаагүй, харин төслийн үндсэн зорилгод нийцүүлэн судалгааны хүрээг чиглүүлсэн болно.

Хоёрдугаарт, энэхүү судалгаанд “хуурамч мэдээлэл”-ийг дангаар нь авч үзэхээс илүүтэй, олон нийтийн санаа бодол, мэдээллийн орон зайг удирдан чиглүүлэх зорилготой мэдээллийн манипуляцийн өргөн хүрээний практикуудын нэг бүрэлдэхүүн хэсэг хэмээн авч үзсэн. Зохион байгуулалттай худал мэдээлэл, мэдээллийг сонгон гуйвуулж хүргэх, эсрэг дуу хоолойг дарах, сүрдүүлэх, бодит бус цахим сүлжээ (бот, хуурамч хаяг, зохион байгуулалттай аккаунтууд), өмчлөл, санхүүжилтийн бүтэц нь ил тод бус хэвлэл мэдээллийн хэрэгслийг стратегийн зорилгоор ашиглах зэрэг бусад манипуляцийн хэлбэрүүд нь хуурамч мэдээллийн кампанит ажлуудтай уялдан оршдог. Иймээс судалгаанд хуурамч мэдээллийг дан

ганц агуулгын түвшинд бус, харин мэдээллийн манипуляцийн илүү өргөн бүтэц, зан үйлийн стратегитэй хэрхэн огтлолцож буйг тодруулахыг зорьсон. Энэ нь ардчиллын талаарх олон нийтийн хэлэлцүүлэг хэрхэн гажуудуулж, олон нийтийн санаа бодолд системтэйгээр нөлөөлж байгааг ойлгоход чухал ач холбогдолтой.

Эцэст нь тэмдэглэхэд, энэхүү зураглалын судалгаа нь Монгол Улс дахь хуурамч мэдээллийн бүх хэлбэр, динамикийг бүрэн хамарсан эцсийн дүгнэлт бус, харин цаашдын гүнзгийрүүлсэн судалгаа, бодлого, олон нийтийн оролцоонд суурилсан арга хэмжээнүүдийг хөгжүүлэх суурь эхлэл юм. Иймээс тайланд тусгагдсан үр дүн, дүгнэлтийг хуурамч мэдээлэлтэй тэмцэх цаашдын судалгаа, интервенц, бодлогын хэлэлцүүлгийг өрнүүлэхэд суурь мэдээлэл болгон ашиглахад чиглэгдсэн.

Арга зүй

Зорилго, зорилт

Монгол Улс дахь хуурамч мэдээллийн орчин, түүний элементүүдийг цогцоор нь зураглаж, хэвлэн нийтлэх болон үзэл бодлоо илэрхийлэх эрх чөлөөг хамгаалах замаар одоогийн зохицуулалтуудыг сайжруулахад чигэлсэн санал, зөвлөмж боловсруулах зорилгоор тус судалгааг гүйцэтгэв.

Энэхүү зорилгодоо хүрэхийн тулд дараах зорилтуудыг дэвшүүлсэн. Үүнд:

- Хуурамч мэдээллийн хамгийн нийтлэг сэдэв, өгүүлэмж, түгээж буй суваг, оролцогч талуудыг тодорхойлох;
- Хуурамч мэдээллийн хувь хүн болон нийгэмд, тухайлбал олон нийтийн итгэлцэл, нийгмийн нягтрал, ардчилсан үйл явцад үзүүлж буй үр нөлөөг үнэлэх;
- Хуурамч мэдээллийн эсрэг авч хэрэгжүүлж буй эрх зүйн зохицуулалт, хэвлэл мэдээлэл, олон нийт зэрэгт чиглэсэн одоогийн арга хэмжээнүүдийг тодорхойлох;
- Цаашдын бодлого, хөтөлбөр, арга хэмжээнд нотолгоо, мэдээлэл бүрдүүлэх зорилгоор орхигдсон орон зай, эрсдэл, бэрхшээлүүдийг тодорхойлох зэрэг болно.

Судалгааны хамрах хүрээ

Энэхүү судалгааг бүрэн хэмжээний, бүх элементийг нарийвчлан шинжлэх гэхээс илүү одоогийн нөхцөл байдлыг тоймлох түргэвчилсэн үнэлгээний загвараар төлөвлөсөн. Судалгаагаар хуурамч мэдээллийн гол элементүүдийг үндэсний түвшинд авч үзэн, ардчилал, эрх чөлөө, засаглалтай холбоотой хуурамч мэдээллүүдэд илүү төвлөрөв.

Шинжилгээний хүрээ

Судалгаагаар тодруулахыг зорьсон үндсэн асуултуудыг тодорхой сэдэвчилсэн элементүүдийн дагуу нарийвчлан шинжилгээний хүрээг боловсруулсан. Судалгааны асуулт тус бүрийг шинжилгээний гол элементүүдтэй уялдуулснаар хуурамч мэдээллийн динамик, нийгэмд үзүүлж буй нөлөө, одоо хэрэгжиж буй хариу арга хэмжээ, цаашид хэрэгжүүлэх шаардлагатай ажлуудыг системтэйгээр, уялдаатай байдлаар шинжлэх боломжийг бүрдүүлнэ. Хүснэгт 1-т судалгааны асуулт, гол элементүүд болон элемент бүрийн хувьд судалсан дэд сэдвүүдийг нэгтгэн харуулав.

Хүснэгт 1. Судалгааны хүрээ

Судалгааны асуулт	Гол элементүүд	Тодруулах асуудлууд
CA1: Хуурамч мэдээлэл хэрхэн үүсэж, нийгэмд түгж байна вэ?	Нийтлэг өгүүлэмж, сэдвүүд	• Хуурамч мэдээллийн нийтлэг өгүүлэмж, гол сэдвүүд, үндсэн мессежүүд
	Түгээх тактик, платформууд	• Хуурамч мэдээлэл түгээх гол арга, стратегиуд: онлайн/офлайн сувгууд, уламжлалт хэвлэл мэдээлэл, цахим платформууд • Хуурамч мэдээлэл платформ дээр эсвэл иргэдийн дунд хэрхэн тарж буй
	Гол талууд, тэдний сонирхол, зорилго	• Хуурамч мэдээллийн ард байгаа байгаа талууд • Хуурамч мэдээллийг түгээж буй талууд (тролл сүлжээ, төрийн талууд, инфлюенсерүүд гэх мэт) • Тэдний үүрэг, ашиг сонирхол, зорилт
	Цаг хугацаа, нөхцөл байдлын хүчин зүйлс	• Хуурамч мэдээллийн идэвхжил нь тодорхой хүчин зүйлтэй (цаг хугацаа, улс төрийн мөчлөг, нийгмийн хөдөлгөөн, томоохон үйл явдал, геополитикийн нөхцөл байдал зэрэг) хэрхэн уялдаж байгааг

CA2: Хуурамч мэдээлэл нийгэмд ямар нөлөө үзүүлж байна вэ?	Нөлөөнд өртөж буй бүлэг, тэдгээрийн өртөмтгий байдал	- Хуурамч мэдээлэлд хамгийн их өртөж буй бүлэг - Тэдгээрийн өртөмтгий байдал - Иргэдэд үзүүлж буй нөлөө
	Үр нөлөө	- Нийгмийн нягтрал, олон нийтийн итгэлцэл, ардчилсан үйл явцад үзүүлэх нөлөө - Ардчилалд учруулж буй хор хөнөөл, бэрхшээл
CA3: Хуурамч мэдээлэлтэй тэмцэх ямар бодлого, арга хэмжээ хэрэгжиж байна вэ?	Хууль эрх зүй, бодлогын орчин	- Хуурамч мэдээлэлтэй холбоотой хууль, зохицуулалт, бодлого - Тэдгээрийн хамрах хүрээ, үр дүнтэй байдал - Хэвлэл мэдээлэл, мэдээллийн боловсролын санаачлагууд
	Ялгаатай талуудын хэрэгжүүлж буй үйл ажиллагаанууд	- Олон нийт манлайлсан үйл ажиллагаа, арга хэмжээнүүд - Иргэний нийгэм, хэвлэл мэдээлэл, төрийн үүрэг
CA4: Хуурамч мэдээлэлтэй тэмцэхэд ямар сул тал, эрсдэл, сорилтууд тулгамдаж байна вэ?	Бодлого, практик, иргэдэд хүрэхтэй холбоотой дутагдал, сул тал	Одоогийн бодлого, стратеги, үйл ажиллагаануудын, ялангуяа эмзэг бүлгийн иргэд, суурь шалтгаан рүү чиглэсэн ажлуудад тулгамдаж буй асуудлууд
	Хуурамч мэдээллийн тактик, технологи, эрсдэл	Хуурамч мэдээллийг түгээхэд ашиглагдаж буй шинэ технологи, тактик зэрэг шинэ тутам эрсдэлүүд болон тэдгээрт чиглэсэн хариу арга хэмжээний үр дүн
	Шинэ эсвэл сайжруулах шаардлагтай үйл ажиллагаанууд	Илэрсэн сул тал, сорилтуудыг шийдвэрлэж, нийгмийн тэсэрлэх байдлыг бэхжүүлэхэд чиглэсэн шинэ эсвэл сайжруулах шаардлагтай үйл ажиллагаанууд, тэргүүлэх чиглэлүүд

Мэдээлэл цуглуулсан аргууд

Судалгаанд баримт бичгийн шинжилгээ болон чанарын аргыг хослуулан ашиглав. Дараах хүснэгтэд мэдээлэл цуглуулсан аргуудыг дэлгэрүүлэн тайлбарлав.

Хүснэгт 2. Мэдээлэл цуглуулах аргууд

Арга	Зорилго	Мэдээллийн эх сурвалж/оролцогч
Баримт бичгийн шинжилгээ	Хуурамч мэдээллийн экосистем, бодлогын арга хэмжээ, талуудын талаарх суурь мэдээллийг бүрдүүлэх	Эрдэм шинжилгээний бүтээлүүд, баримт шалгах төвүүдийн дата мэдээлэл, бодлого, зохицуулалт, хэвлэлийн тайлан, судалгааны мэдээллүүд
Ганцаарчилсан ярилцлага	Хэвлэл мэдээлэл, бодлого, олон нийтийн түвшинд үйл ажиллагаа явуулдаг мэргэжилтнүүдээс гүнзгийрүүлсэн мэдээлэл олж авах	Сэтгүүлч, редактор, бодлого гаргагч, хууль батлагч, иргэний нийгмийн байгууллагын төлөөлөл, судлаач, цахим эрхийн идэвхтэн
Баримт шалгасан мэдээлэлд хийсэн тоон шинжилгээ	Баримт бичгийн шинжилгээ, ганцаарчилсан ярилцлагын үр дүнг баталгаажуулж, баяжуулах зорилгоор баримт шалгах төвүүдийн нягталсан мэдээлэлд дүн шинжилгээ хийх	Монголын баримт шалгах төв, Factcheck Mongolia-ийн нягталсан 1,618 хуурамч мэдээллийн үр дүн, контент
Үр дүнгийн хэлэлцүүлэг	Оролцогч талууд дунд хэлэлцүүлэг зохион байгуулах замаар бодит нөхцөл байдалд нийцүүлж, бодлогын ач холбогдлыг нэмэгдүүлэх зорилгоор судалгааны урьдчилсан үр дүнг танилцуулж, баталгаажуулах	Ганцаарчилсан ярилцлагад оролцсон төлөөллүүд, мэргэжилтнүүд, төр, иргэний нийгмийн байгууллага болон хэвлэл мэдээллийн төлөөллүүд

Оролцогчдын боломж, сэдвийн хамаарал зэргээс хамаарч нийт 15 ганцаарчилсан ярилцлагыг хагас бүтэцлэгдсэн хэлбэрээр, биечилсэн болон онлайн уулзалтаар зохион байгуулсан. Ярилцлагын үеэр оролцогчдын зөвшөөрөлтэй аудио рекорд бичиж, ярилцлагын үр дүнг сэдэвчлэн хураангуйлж, дүн шинжилгээнд ашиглав.

1.Хуурамч мэдээллийн нөхцөл байдлын тойм

Хуурамч мэдээлэл (Disinformation) гэх ойлголт шинэ тутам ойлголт биш боловч 2016 оны Америкийн Нэгдсэн Улс (АНУ)-ын Ерөнхийлөгчийн сонгууль болон Брекситийн асуудлаарх бүх нийтийн санал асуулга (референдум)-тай холбоотойгоор илүү эрчимжиж, судлаачдын анхаарлыг татаж эхэлсэн билээ (Broda & Strömbäck, 2024). Өмнөх үетэй харьцуулахад сүүлийн 10 гаруй жилийн хугацаанд дижитал, сошиал медиа хөгжиж, мэдээллийн сүлжээний төвлөрөл багасаж, хуурамч мэдээлэл түгэх хурд, хүрээ, хүлээн авагчийн тоо огцом нэмэгдэж, улам нарийн төвөгтэй болсон нь хуурамч мэдээлэл түгэх үндсэн нөхцлийг бүрдүүлж байна (Karantai et al., 2021). Ярилцлагад оролцогчид ч Монгол Улсад хуурамч мэдээллийн цар хүрээ нэмэгдэхэд сүүлийн үеийн технологийн өөрчлөлтүүд нөлөөлсөн гэдэгтэй санал нэгдэж байв (Ярилцлага #1, 5, 6, 7, 11, 14). V-Dem-ийн тайланд (2025) тэмдэглэснээр 2014-2024 онд Монголд хуурамч мэдээллийн түвшин ойролцоогоор хоёр дахин нэмэгдсэн байна. Мөн Монголд үйл ажиллагаа явуулдаг баримт шалгах хоёр төвийн мэдээлж буйгаар COVID-19 цар тахлаас өмнө аливаа нэг чухал үйл явдлын үеэр л зохион байгуулалттай хуурамч мэдээлэл түгээх нь ажиглагддаг байсан бол одоо хуурамч мэдээлэл илүү тогтмол шинжтэй болж, ердийн үеүдэд ч тасралтгүй түгээгдэх болсон байна.

Энэ нь дэлхий дахинд ардчилал болон түүний институциудыг сулруулахад томоохон аюул занал учруулж, улс орнуудын дотоод улс төр хийгээд олон улсын зөрчилд ч хувь нэмэр оруулж байна (Schünemann, 2022). Тиймээс ч 2024 оны Дэлхийн эрсдэлийн тайланд хуурамч мэдээллийг ойрын хугацааны хамгийн ноцтой эрсдэлүүдийн нэгдүгээрт, урт хугацаанд нөлөөлөх эрсдэлүүдийн тавдугаарт жагсаасан байна (WEF, 2024). Харин Монгол Улсын хувьд Бүгд найрамдахчуудын олон улсын хүрээлэн (БНОУХ) (2024)-ийн хийсэн үндэсний санал асуулгаар судалгаанд оролцогчдын 85.8% нь хуурамч мэдээллийг томоохон асуудал хэмээн үзсэн байна.

Үүнтэй холбоотойгоор олон улсад хуурамч мэдээлэлтэй холбоотой судалгааны ажлууд үлэмж нэмэгдсэн (Sadler, 2025) ч Монгол Улсад энэ чиглэлээр хийгдсэн судалгаа хангалттай бус хэвээр байна (OptimalNMax, 2024). Өнөөдрийг хүртэл хийгдсэн судалгаануудыг харахад тодорхой нэг төрлийн сэдвийн хүрээнд (NEST, 2025), тодорхой нэг мэдээллийн суваг (Д.Идэржаргал & Б.Маралмаа, 2023; Я.Болорчулуун & Д.Идэржаргал, 2019) эсвэл арга техникт (Баяр, 2024) төвлөрсөн байна. Харин эсрэгээрээ Монголд ямар хуурамч мэдээллийг хэн бүтээж, хэрхэн түгээж буй талаар өргөн хүрээнд, системтэй судалсан судалгаа байхгүй байна. Тиймээс тайлангийн энэхүү хэсэгт экспертүүдтэй хийсэн ганцаарчилсан ярилцлага болон хоёрдогч мэдээллүүд дээр үндэслэн Монгол дах хуурамч мэдээллийн нөхцөл байдлын тоймыг тайлбарлах болно.

Ингэхдээ Колумбын Их Сургуулийн François (2020)-ийн хуурамч мэдээллийг тайлбарлаж, анализ хийх зорилгоор гаргасан ABC Framework-ыг ашигласан. Энэхүү аргачлал нь хуурамч мэдээллийг гурван бүрэлдэхүүн хэсэгт хувааж, дараах байдлаар тайлбарласан байдаг.

- **Талууд (Actors)** гэж тухайн мэдээллийг хуурамч болохыг мэдсээр байж, тодорхой зорилготойгоор түгээх үйл явцад оролцож буй талууд;
- **Зан байдал (Behaviors)** гэж талуудын хуурамч мэдээлэл түгээхдээ ашиглаж буй арга техник, тактикууд;
- **Агуулга (Content)** гэж хувь хүн, байгууллага, олон нийтийн эрх ашиг, нийтийн хэлэлцүүлэгт сөргөөр нөлөөлөх мэдээллийн агуулгыг хэлнэ.

1.1 Хуурамч мэдээллийг бүтээж, түгээж буй талууд, тэдний эрх ашиг, мэдээллийн төрлүүд

Байнгын бөгөөд өргөн хүрээтэй хуурамч мэдээллийг зөвхөн нэг хүн эсвэл нэг тал бүтээж, түгээдэггүй бөгөөд эсрэгээрээ олон төрлийн талууд ялгаатай байдлаар оролцдогоороо онцлогтой (Hameleers, 2023). Монгол дахь хуурамч мэдээллийг төрийн байгууллагаас эхлээд жирийн иргэн хүртэл олон төрлийн оролцогч талууд үйлдвэрлэж, түгээж, өөгшүүлж байгаа нь судалгааны үр дүнгээс харагдсан. Эдгээр талуудыг ерөнхийд нь **санаачлагч буюу санхүүжүүлэгч** (засгийн газар, төрийн байгууллагууд, дотоодын улс төрчид, намууд, гаднын оролцогчид болон бусад), **зохион байгуулагч буюу бүтээгч** (Пи-ар, медиа багууд), **түгээгч** (хэвлэл мэдээлэл, инфлюенсерүүд, сошиал медиа хуудас/групп), **өдөөгч** (тролл сүлжээ, цөөн дагагчтай инфлюенсерүүд, иргэд) гэж ангилж болохоор байна.

Дүрс 1. Монгол дахь хуурамч мэдээллийн оролцогч талууд



Тайлангийн энэ хэсэгт эдгээр талуудын эрх ашиг, хуурамч мэдээлэл түгээж буй зорилго, сэдэл, үйл ажиллагааны хэв шинжийг тоймлон танилцуулав.

1.1.1 Засгийн газар, төрийн байгууллагууд

Засгийн газар, төрийн байгууллагууд, албан хаагчид Монгол дахь хуурамч мэдээллийн орчны гол тоглогч бөгөөд хуурамч мэдээллийг санаачлагч, түгээгч байдлаар оролцдог байна (Ярилцлага #2, 3, 4, 5, 7, 9, 14). Хэдий төр институцын түвшинд системтэйгээр хуурамч мэдээлэл түгээдэг эсэх нотолгоо

байхгүй байгаа ч тодорхой нийгэм, улс төрийн үйл явдлын үеэр, нөхцөл байдлаас хамаарч хуурамч мэдээлэл бүтээж, түгээдэг талаар судалгаанд оролцогчид мэдээлж байв (Ярилцлага #2, 3, 4, 5, 7, 9, 14). Зорилгын хувьд авч үзвэл, нэгдүгээрт, нэр хүндээ өсгөх, олон нийтийн дэмжлэгийг бий болгох, бодлого, шийдвэрүүдээ хууль ёсны мэт харагдуулах зорилгоор хэт нэг талыг барьсан эсвэл төөрөгдүүлсэн мэдээлэл түгээх нь элбэг (Ярилцлага #5, 7, 14). Жишээлбэл, 2023 онд Ерөнхий сайд асан Л.Оюун-Эрдэнэ “Самурай” бондын 30 тэрбум иень буюу 200 сая ам.долларын өрийг төлсөн талаар мэдэгдэхдээ “Монгол Улс 12 жил үргэлжилсэн өрийн гинжин хэлхээсээс гарч чадлаа” гэснийг Монголын баримт шалгах төв (MFCC) шалгаж, төөрөгдүүлсэн мэдээлэл болохыг баталсан юм. Учир нь 2023 оны 3-р улирлын байдлаар Монгол Улсын нийт гадаад өр 33,9 тэрбум ам.доллар байсан нь 12 жилийн өмнөх буюу 2011 онтой харьцуулахад 20 орчим тэрбум ам.доллараар нэмэгдсэн үзүүлэлт аж (MFCC, 2023).

Хоёрдугаарт, засгийн газар болон төрийн байгууллагууд аливаа шийдвэр гаргахын өмнө олон нийтийн хандлагыг тандахын тулд тухайн шийдвэрийг гаргасан мэтээр хуурамч мэдээлэл түгээдэг талаар судалгаанд оролцогчид дурдсан (Ярилцлага #2, 3, 4, 5, 9). Жишээлбэл, судалгаанд оролцогчдын ажигласнаар Улаанбаатар хотод зам хаах талаарх зэрэг мэдээллийг сошиал медиа платформуудаар түгээж, иргэд эсэргүүцэж байвал төрийн байгууллагуудаас ийм шийдвэр гаргаагүй, хэвлэл мэдээллийн байгууллагууд худал мэдээлэл гаргасан байна гэж мэдэгддэг. Гэтэл энэ нь иргэдийн хэвлэл мэдээлэлд итгэх итгэлийг сулруулж, нийгэмд хортой үр дагавар авчирч болзошгүй байна.

Гуравдугаарт, улс төр, бодлогын томоохон үйл явдлуудын үеэр олон нийтийн анхаарлыг өөр зүгт чиглүүлэх зорилгоор хуурамч мэдээлэл тараах эсвэл улс төрийн манипуляц хийдэг байна (Ярилцлага #5, 6). Судалгаанд оролцогчдын ажигласнаар улсын төсөв батлах, авлига, ашиглах сонирхлын асуудал хөндөгдөх зэрэг чухал үйл явдлуудын үед нийгмийг цочроосон гэмт хэрэг, золгүй явдлын мэдээллүүд огцом нэмэгдэж, бүх хэвлэл мэдээллийн хэрэгслээр олон нийтэд түгээдэг байна. Сонирхолтой нь энэ үеүдэд төрийн байгууллагууд тухайн гэмт хэрэг, золгүй явдалтай холбоотой мэдээллийг ил тод мэдээлдэг ч бусад үеүдэд хаалттай байдаг талаар дурдсан юм (Ярилцлага #5). Үүнийг хуурамч мэдээлэл гэж нэрлэх боломжгүй ч мэдээллийн орон зайг стратегийн хэрэгсэл болгон ашиглаж, тодорхой асуудлаас олон нийтийн анхаарлыг сарниулах зорилготой байж болзошгүй юм.

Түүнчлэн, Монгол Улсын Засгийн газар, төрийн байгууллагууд хэвлэл мэдээлэл хариуцсан тусдаа нэгжтэй ажилладаг ба эдгээр нэгжүүд нь ил тод байдлыг ханган мэдээлэл түгээхээс илүүтэй удирдлагын нэр хүндийг хамгаалах, сэтгүүлчдийн үйл ажиллагааг хязгаарлах болсныг хэвлэл мэдээллийн салбарын мэргэжилтнүүд шүүмжилж байв (Eguur.mn, 2025). Энэ нь хэвлэлийн эрх чөлөө болон сэтгүүл зүйн бие даасан байдалд сөргөөр нөлөөлж, байгууллагын хэвлэлийн албууд үнэн бодит мэдээлэл түгээх бус суртал ухуулгын бүтэц болон хувирах эрсдэлтэй байгааг ярилцлагад оролцогчид мэдээлсэн (Ярилцлага #5).

Эдгээрээс харахад засгийн газар болон эрх баригчид олон нийтийн санал бодолд нөлөөлөх, удирдах, анхаарлыг нь сарниулах, дэмжлэгээ нэмэгдүүлэх болон эрх мэдлээ хамгаалах зорилгоор хуурамч мэдээлэл бүтээж, түгээдэг байна. Гэвч төрөөс хуурамч мэдээлэл түгээх нь урт хугацаандаа засаглалын чанарыг доройтуулах, олон нийтийн итгэлцлийг бууруулах зэрэг ноцтой сөрөг үр дагавартайг судалгаанд оролцогчид онцолж байв.

1.1.2 Дотоодын улс төрчид, улс төрийн намууд

Судалгаанд оролцогчдоос Монголд хуурамч мэдээллийг бүтээж, түгээж буй талуудыг тодруулахад хамгийн түрүүнд улс төрчид, улс төрийн хүчнүүдийг нэрлэж буй нь эдгээр талууд хуурамч мэдээллийн хамгийн гол “үйлдвэрлэгч, захиалагч” болохыг харуулж байна. Оролцогчдын ажиглалтаар хуурамч мэдээлэл сонгууль болон улс төрийн томоохон үйл явдлуудын үеэр хамгийн их эрчимждэг нь нэгдүгээрт улс төрчид өрсөлдөгчдөө харлуулах, хоёрдугаарт олон нийтийн дэмжлэгээ нэмэгдүүлэх

зорилготой байна (Ярилцлага #3, 4, 5, 6, 7, 8, 10, 11, 14, 15). 2020 болон 2021 оны сонгуулийн үеэр хийсэн хэвлэл мэдээллийн мониторинг ч үүнтэй төстэй үр дүнг мэдээлсэн байдаг (БНОУХ & Хэвлэлийн хүрээлэн, 2021).

Пи-ар баг, хэвлэл мэдээлэл, олны танил инфлюенсерүүд, троллууд зэрэг олон талуудыг нэгтгэсэн хуурамч мэдээллийн экосистемийг улс төрчид бүрдүүлдэг байж болзошгүй нь мөн ярилцлагын үр дүнгээс харагдсан. Хэдийгээр энэхүү сүлжээг шууд нотлох хангалттай дата байхгүй ч судалгаанд хамрагдсан салбарын экспертүүд, улс төрчдийн ажиглалт, туршлага болон хоёрдогч мэдээллүүдэд үндэслэн тодорхой зураглал гаргаж болохоор байна. Эдгээр талуудын талаар доор дэлгэрэнгүй тайлбарлах болно.

1.1.3 Гадаад оролцогчид

Гадаад улс орнууд, ялангуяа Монгол Улсад шууд ашиг сонирхол бүхий хөрш гүрнүүд манай мэдээллийн орон зайд зохион байгуулалттайгаар хуурамч мэдээлэл түгээх, мэдээллийн орон зайд нөлөөлөлж байж болзошгүйг судалгаанд оролцогчид онцолсон (Ярилцлага #4, 5, 6, 9). Монгол руу чиглэсэн улс төрийн зорилготой хуурамч мэдээлэл түгээдэг хоёр гол тоглогчид нь Оросын холбооны Улс (ОХУ) болон Бүгд Найрамдах Хятад Ард Улс (БНХАУ) байна.

ОХУ нь бусад улс орнуудруу чиглэсэн хуурамч мэдээллийг бэлтгэн идэвхитэй түгээдэг орнуудын нэг (Bennett & Livingston, 2018) бөгөөд тэдний стратегийг хуучин Зөвлөлт Холбоот Улсын бүрэлдэхүүнд багтаж эсвэл нөлөөнд байсан орнууд (Near abroad), бусад улс орнуудруу (Far abroad) чиглэсэн гэж 2 хуваан авч үздэг (Kleinschmidt, Minailo, Gabdulhakov, & Nguyen, 2023). Оросын хуурамч мэдээлэл нь тодорхой бэлтгэсэн өгүүлэмжтэй, түүнээ олон янзын сувгаар, өндөр давтамжтэй түгээж хоногшуулах замаар тараадаг онцлогтой (Paul & Matthews, 2016; Robbins, et al., 2020). Тэд тухайн улс орныхоо онцлогт тохируулан өгүүлэмж гаргадаг хэдий ч түгээмэл ашиглаж байсан зарим нийтлэг өгүүлэмж бий. Эдгээр нь “Барууны орнууд ёс суртахууны хувьд доройтсон”, “ЛГБТ-г сурталчлах гэх мэтээр барууныхан нийгмийн уламжлалт үнэт зүйлсийн эсрэг үйл ажиллагаа явуулдаг бол Орос хамгаалдаг”, “Орос хэлээр ярьдаг үндэсний цөөнх хэсгийг хэрхэн гадуурхаж буй тухай”, “Барууныхан био зэвсгийн лаборатори байгуулж шинэ өвчин тахал үүсгэхээр оролдож байна” гэх мэт нарративууд байдаг (Andrzej, Łukasz, & Stanisław, 2023).

ОХУ-ын хувьд өөрийн геополитикийн ашиг сонирхолд нийцүүлэн Монголын олон нийтийн санаа бодолд нөлөөлөх мэдээллийн кампанит ажил олон жил үргэлжилсэн байх боломжтой. Сэтгүүл зүйн Инновац, Хөгжлийн Үүр төв НҮТББ (2025)-ээс Монгол дахь Оросыг дэмжсэн агуулга бүхий хуурамч мэдээллийг илрүүлэх зорилгоор Фэйсбүүк дээрх Оросыг дэмжсэн мэдээлэл түгээдэг, хамгийн идэвхтэй 16 аккаунтын 20 мянга орчим пост дээр дүн шинжилгээ хийсэн. Ингэхэд хамгийн идэвхтэй өгүүлэмжүүд нь нэгдүгээрт, Оросыг дэмжсэн, магтан дуулсан, хоёрдугаарт, Орос-Украины дайнд Оросыг зөвтгөж, дэмжсэн, гуравдугаарт, Монголын дотоодын улс төрийн агуулгатай мэдээллүүд байв. Үүн дээр нэмээд Барууны эсрэг, Ураны эсрэг, Израйль-Палестины зөрчил, Хятадын эсрэг, вакцины эсрэг агуулга бүхий мэдээллүүд мөн түгээмэл байжээ. Постууд дээрх хариу үйлдэл (interactions)-үүдийг шинжлэхэд 2024 оны парламентын сонгуулийн өмнө, хүний папиллома вирусын вакцинжуулалт эхлэх үед ОХУ-ын Ерөнхийлөгч Владимир Путин Монголд айлчилсан 2024 оны 9 сард хамгийн их идэвхжсэн нь ажиглагдсан. Мөн зарим идэвхгүй байсан аккаунтууд Монгол Улсын Засгийн газар Францын Орано Майнинг компанитай Хөрөнгө оруулалтын гэрээ байгуулсан 2025 оны 1 сард дахин идэвхжсэн зэрэг сонирхолтой үр дүн гарчээ. Эдгээрээс харахад Монголд ОХУ-ын суртал ухуулгын мэдээллийг идэвхтэй түгээдэг агентууд хэдий нь бий болсон бөгөөд Монголын гуравдагч хөршийн бодлого, ардчиллын үнэ цэнийг сулруулах, ОХУ-ын дэмжлэг, нэр хүндийг нэмэгдүүлэх, гуравдагч хөршийн хөрөнгө оруулалттай төсөл хөтөлбөрийн эсрэг олон нийтийг турхирах, олон нийтийн дунд төөрөгдөл бий болгох зэрэг зорилготой байх магадлалтай байна.

Харин БНХАУ-ын зүгээс илт хуурамч мэдээлэл түгээх нь ховор ч хэвлэл мэдээллийн салбарт нөлөөлөх байдлаар Хятадын талаарх олон нийтийн эерэг хандлагыг нэмэгдүүлэхийг оролддог байна (Ярилцлага #3, 5, 9, 11, 14). Ингэхдээ хоёр төрлийн арга ашиглаж буй нь ярилцлагын үр дүнгүүдээс харагдсан. Нэгдүгээрт, БНХАУ-ын зүгээс жил бүр монголын сэтгүүлчдийг БНХАУ-д урьж хөтөлбөртэй аялуулах, сургалтад хамруулах, хамтарсан форум, үйл ажиллагаанууд зохион байгуулах, хамтарсан сурвалжлага хийх, Бүх Хятадын сэтгүүлчдийн эвлэл Монголын сэтгүүлчдийн нэгдсэн эвлэлтэй хамтран ажиллах, бэлтгэсэн мэдээллээр хангах зэргээр хамтын ажиллагааг өргөн хүрээнд тогтмол зохион байгуулж, зөөлөн хүчний аргаар нөлөөлөх оролдлогуудыг хэрэгжүүлж байна. Хоёрдугаарт, БНХАУ-аас Монгол Улсад суугаа Элчин сайдын яам хэвлэл мэдээллийн байгууллагуудад шууд цензур тавих оролдлогууд байдаг болохыг ч судалгаанд оролцогчид мэдээлсэн. Тухайлбал, БНХАУ-ын эрх ашгийг зөрчсөн, нэр хүндэд нь сөргөөр нөлөөлж болзошгүй мэдээллийг устгуулах гэж оролдох, шахах эсвэл тодорхой үйл явдлуудыг мэдээлүүлэхгүй байх хүсэлт тавих, хахууль өгөх зэргээр хэвлэл мэдээллийн байгууллагын редакцуудад шууд нөлөөлөх оролдлогууд хийдэг байна (Ярилцлага #14).

Гадаадын хуурамч мэдээллийн кампанит ажлуудын нийтлэг шинж нь дотоод оролцогч талуудтай сүлэлдэж, тэдгээрийг ашиглах явдал юм. ОХУ, БНХАУ-д зэрэг орнууд өөрсдийн хуурамч өгүүлэмжүүдийг түгээхдээ Монгол дахь хэвлэл мэдээлэл, улс төрчид, тролл сүлжээ зэргийг дам сувгаар ашиглах хандлагатай. Тухайлбал, Хятад, Оросын суртал ухуулгын контентыг Монголын зарим фэйсбүүк хуудсууд, вебсайтууд шууд хуулбарлан түгээх, эсвэл орчуулж нийтлэх тохиолдол байдаг нь гаднын мэдээлэл дотоод сувгаар орж ирж байгаагийн илрэл юм (Ярилцлага #4, 5, 9). Зарим тохиолдолд Монголын улс төрчид гаднынхны ашиг сонирхолд нийцсэн хуурамч мэдээллийг түгээж, нийтэд хүргэж байж ч болзошгүй талаар судалгаанд оролцогчид онцолсон.

1.1.4 Пи-ар болон медиа багууд

Олон улсад улс төрийн манипуляц хийх, хуурамч мэдээлэл түгээхэд хувийн компаниудыг ашиглах нь түгээмэл практик болоод байна. Тухайлбал, Bradshaw (2021) нарын судлаачдын 81 орныг хамарсан судалгаагаар улс төрийн зорилгоор мэдээллийн манипуляцийн үйлчилгээ үзүүлдэг 65 гаруй компани 48 улсад үйл ажиллагаа явуулж буй нь илэрсэн ба энэ тоо жил бүр өссөн үзүүлэлттэй байна.

Монгол Улсын хувьд ч дээр дурдсан захиалагч/санхүүжүүлэгчид хуурамч мэдээлэлд түгээхдээ пи-ар болон медиа багуудыг ашигладаг талаар ярилцлагын оролцогчид мэдэгдсэн (Ярилцлага #2, 3, 6). Тэдний үзэж буйгаар тус багууд хуурамч мэдээллийн экосистемд нэгдүгээрт, хуурамч мэдээллийн сэдэв болон агуулгыг бэлдэж, бусад түгээгч талуудад тараах зэргээр бүтээгч байдлаар, хоёрдугаарт, хэвлэл мэдээлэл, инфлюенсерүүд, тролл сүлжээ, бот зэргийг ашиглаж, уялдаа холбоотой, системтэй улс төрийн манипуляц хийх, хуурамч мэдээлэл түгээх зэргээр зохион байгуулагч байдлаар ажилладаг байна. Ярилцлагад хамрагдсан оролцогчийн мэдээлснээр энэ төрлийн үйлчилгээ үзүүлдэг багууд Монголд байдаг ба улс төрчдөд үйлчилгээ санал болгодог байна (Ярилцлага #15).

1.1.5 Хэвлэл мэдээллийн байгууллага, сэтгүүлчид

Мэргэжлийн, уламжлалт хэвлэл мэдээллийн байгууллагууд хуурамч мэдээлэл түгээх нь харьцангуй бага ч хэвлэл мэдээллийн орчны зарим тоглогчид, ялангуяа шинээр гарч ирж буй дижитал медиа багууд санхүүгийн, улс төрийн, бизнесийн ашиг сонирхлын үүднээс хуурамч мэдээлэл түгээхэд оролцдог байна (Ярилцлага #3, 4, 5, 6, 10, 12). Жишээлбэл, Хил хязгааргүй сэтгүүлчид болон Хэвлэлийн хүрээлэн (2016) хамтран гүйцэтгэсэн хэвлэл мэдээллийн мониторингд хамрагдсан 39 байгууллагын 29 нь буюу 74 орчим хувь нь улс төрийн хамаарал бүхий эзэн, хөрөнгө оруулагчтай байжээ. Бидний судалгаанд хамрагдсан хэвлэл мэдээллийн салбарын төлөөлүүд энэ байдал одоо ч хэвээр байгааг

онцолж, улс төрийн томоохон үйл явдлуудын үеэр хэвлэл мэдээллийн байгууллагууд хоёр талд хуваагдан ажилладаг нь тод анзаарагддаг гэсэн юм.

Үүнээс гадна, зарим улс төрчид, төрийн болон бизнесийн байгууллагууд өөрсдийн үйл ажиллагаагаа олон нийтэд сурталчилах зорилгоор хэвлэл мэдээллийн байгууллагуудтай “Хамтран ажиллах гэрээ” байгуулж, мэдээллээр хангадаг байна. Энэхүү хамтын ажиллагаанаас олж буй орлого нь хэвлэл мэдээллийн байгууллагуудын орлогын нэлээдгүй хэсгийг бүрдүүлдэг тул хэвлэл мэдээлэл төрөөс санхүүгийн болон редакцийн хувьд хараат ажиллах эрсдэлтэй (Баасанжав et al., 2024). Тухайлбал, зарим байгууллагатай байгуулсан энэ төрлийн гэрээнд тус улс төрч эсвэл байгууллагын талаар **сөрөг мэдээлэл түгээхгүй байх талаар тодорхой заалтууд багтсан байдаг** (Г.Туяагэрэл & Э.Эрдэнэцэцэг, 2024) нь шууд хуурамч мэдээлэл түгээхтэй холбоогүй ч иргэдийн үнэн зөв мэдээллээр хангагдах эрхэд сөргөөр нөлөөлдөг гэж судалгаанд оролцогчид дурдаж байв (Ярилцлага #2, 6, 11, 14, 15). Үүнийг практикт “Хаалтын гэрээ” гэж нэрлэдэг. **Сонирхолтой нь, сүүлийн жилүүдэд төрийн байгууллага болон улс төрчид хэвлэл мэдээллийн байгууллагатай гэрээ хийхээс гадна хувь сэтгүүлчидтэй хаалтын гэрээ хийх үзэгдэл нэмэгдсэн байна.** Ингэснээр сэтгүүлчид өөрийн сошиал медиа хаягуудыг ашиглаж захиалагчийн мэдээллийг түгээж, олон нийтэд хэвлэл мэдээлэл мэтээр ойлгогдох эрсдэл бий болсон байна (Ярилцлага #14).

Дижитал орчин дахь мэдээллийн урсгал нэмэгдэхийн хэрээр “Халаасны сайтууд” гэх нэршил хэвлэл мэдээллийн салбарт олны анхаарлыг татах болсон. Судалгаанд оролцогчид үүнийг тодорхой редакцгүй, ажилтнууд болон хаягийн мэдээлэл байхгүй, ихэвчлэн татвар төлдөггүй, нэг эзний үзэл бодлоор мэдээллийн урсгалаа зохицуулдаг мэдээллийн вэбсайтууд хэмээн тодорхойлж байна. Eguur.mn (2022) мэдээллийн сайтын дүн шинжилгээгээр Монголд бүртгэлтэй 390 орчим мэдээллийн сайтын 20-60 нь редакциятай гэсэн ангилалд багтах боломжтой бол үлдсэн 300 орчим нь редакцгүй буюу халаасны сайтууд байна. Салбарын мэргэжилтнүүдийн мэдээлж буйгаар **энэ төрлийн сайтууд хуурамч мэдээллийг түгээдэг гол талуудын нэг бөгөөд нэг хүн олон тооны домайн нэр эзэмшиж, хармааны сайтууд ажиллуулан, төрийн болон бизнесийн байгууллагууд, улс төрчидтэй хаалтын гэрээ байгуулж, аль нэг талд ажиллах нь түгээмэл байдаг байна** (Ярилцлага #3, 5, 6, 11, 14).

Түүнчлэн, мэргэжлийн хэвлэл мэдээллийн байгууллагууд редакцийн бодлого болон мэргэжлийн ёс зүй, хэм хэмжээг баримтлан ажиллах гэж хичээдэг ч **баримт шалгах чадвар сул тул** (Баасанжав et al., 2024) **хуурамч мэдээллийг санамсаргүй байдлаар түгээх тохиолдлууд бий.** Үүнийг ч ярилцлагын оролцогчид хүлээн зөвшөөрч байв (Ярилцлага #10, 13).

1.1.6 Сошиал медиа инфлюенсерүүд, олны танил

Сүүлийн жилүүдэд хуурамч мэдээллийг түгээхэд инфлюенсерүүдийн оролцоо ихээхэн нөлөөтэй байгааг олон улсын судалгаанууд (Palacios López et al., 2023) ч, манай судалгаанд оролцогчдын өгсөн мэдээллүүд ч харуулж байв (Ярилцлага #1, 3, 4, 5, 6, 8, 13). Түүнчлэн, Монголд үйл ажиллагаа явуулдаг баримт шалгагч хоёр байгууллагын (Factcheck.mn, MFCC) нягталсан хуурамч ташаа мэдээллүүдэд шинжилгээ хийхэд хамгийн их хуурамч мэдээлэл түгээсэн эхний гурван хаяг нь Фэйсбүүк дээр тус тус 82 мянга, 23 мянга, 7 мянган дагагчидтай инфлюенсерүүд байгаа нь үүнийг баталж байна.

Сошиал медиа дээрх инфлюенсерүүд нь тодорхой дагагчидтай, өөрсдийн гэсэн дэмжигчдийн хүрээллийг бий болгож чадсан, тогтмол идэвхтэй үйл ажиллагаа явуулдаг, контент бэлтгэх, түүнийгээ олон хүнд хүргэх ур чадвартай зэрэг шалтгаануудаар **олон хүний мэдээллийн эх сурвалж болж, хэвлэл мэдээлэл, төрийн байгууллага зэрэг дээр дурдсан албан ёсны эх сурвалжуудын хүрч чадаагүй, орхигдсон мэдээллийн орон зайг нөхдөг байна.** Жишээлбэл, Eguur.mn (2022) мэдээллийн сайт нэг цаг хугацаанд, нийгэмд тохиолдсон ижил үйл явдлыг мэдээлсэн хамгийн өндөр хандалттай таван мэдээллийн вэбсайтууд болон Фэйсбүүк дэх таван инфлюенсерийн хандалтыг харьцуулахад инфлюенсерүүдийн дундаж хандалт вэбсайтуудаас 2 дахин өндөр байжээ. Мөн инфлюенсерүүдийн

сурталчилгаа, мэдээлэл түгээх төлбөр нь мэдээллийн сайтуудынхаас өндөр байгааг ч дурдсан байна. **Эндээс инфлюенсерүүд хэдийн Монголын мэдээллийн орчны гол тоглогчид болсныг харж болохоор байна.**

Гэхдээ хуурамч мэдээлэл түгээдэг инфлюенсерүүд дотроо ялгаатай, үндсэн хоёр бүлэгт хувааж болно (Ярилцлага #2). **Эхний бүлэгт жүжигчид, дуучид, контент бүтээгчид зэрэг олны танил, олон дагагчидтай инфлюенсерүүд орох ба тэдгээр нь улс төрийн агуулгатай мэдээлэл тогтмол түгээдэггүй.** Тэд өөрсдийн нэр хүндээ бодож илт худал мэдээлэл түгээхгүй ч тодорхой нэг үйл явдлын үеэр, ялангуяа сонгуулийн үеэр аль нэг улс төрч эсвэл нам эвслийг дэмжиж, олон нийтийн санаа бодолд нөлөөлөхийг оролддог. Ингэж илт улс төржихгүй ч далд сурталчилгааны хэлбэрээр нөлөөлөл үзүүлдэг байна. Харин **хоёр дахь бүлэгт цахим орчин дахь олон нийтийн хэлэлцүүлэгт идэвхтэй оролцдог инфлюенсерүүдийг багтаана.** Тэдний зарим нь олон дагагчидтай, олон нийтэд танигдсан (идэвхтэнүүд, улс төрийн тэмцэгчид, сэтгүүлчид гэх мэт) байх бол зарим хэсэг нь харьцангуй цөөн дагагчтай ч зорилтот агуулгыг тууштай түгээдэг. Энэ төрлийн инфлюенсерүүд өдөөн хатгасан, төөрөгдүүлсэн, хуурамч мэдээллийг тогтмол, системтэйгээр түгээх нь түгээмэл болохыг судалгаанд оролцогчид онцолсон (Ярилцлага #2).

Түүнчлэн тодорхой төлбөртэйгөөр, ялангуяа нэг талыг барьсан мэдээлэл, пост түгээдэг сошиал медиа хэрэглэгчдийг “хиамчин” гэж нэрлэх болсон бөгөөд энэ нь нэршил болж тогтон, өдөр тутмын хэрэглээнд нэвтэрчээ. Энэ үгийн үүслийг харвал, анх Твиттер (одоогийн X) платформ дээр олон дагагчтай хэсэг хэрэглэгчид нэр бүхий хиамны брендийг нэгэн зэрэг сурталчилж, төлбөртэй постууд оруулснаас эхлэлтэй. Үүнээс хойш “хиамчин” гэх нэршил цахим орчинд өргөн хүрээтэйгээр хэрэглэгдэх болсон юм. Анх хошин, егөөдсөн утгаар хэрэглэж эхэлсэн энэ үг аажмаар улс төр, нийгмийн асуудлаар нэг талыг барьсан байр суурь илэрхийлэгч, төлбөртэй агуулга түгээгч, хөлсний бичээч гэх утгыг давхар агуулж эхэлжээ. Эдгээр “хиамчид” зохион байгуулалтад орж, сонгууль, жагсаал цуглаан гэх мэт улс төр, нийгмийн тодорхой нэг үйл явдлын үед нэгэн зэрэг пост оруулах замаар нийтийн санаа бодолд нөлөөлөхийг оролддог.

1.1.7 Тролл сүлжээ

Тролл буюу зохион байгуулалттай хуурамч аккаунтуудын сүлжээ нь Монголд хуурамч мэдээллийг олшруулан түгээх гол хэрэгслийн нэг болсныг дараах жишээнүүд баталж байна. Нэгдүгээрт, Цагдаагийн Ерөнхий Газрын мэдээлснээр 2023 онд Монголд 400 мянга орчим хуурамч цахим хаяг нээсэн байж болзошгүй ба тухайн оны жилийн эцсийн байдлаар хуурамч хаяг үүсгэж, хуурамч мэдээлэл тараах үйлдлийг 50.3 хувьтай илрүүлсэн байна. Хоёрдугаарт, 2019-2020 онд нэр бүхий бүлэг этгээдүүд “Z shadow” ашиглан “фишинг” халдлага зохион байгуулж, олон тооны Фэйсбүүк хэрэглэгчдийн аккаунтад нэвтэрч, нууц үг, дугаарыг сольж, холбогдох мэдээллүүдийг нь устган, зарсан болон сонгуулийн/сошиал ажиллагаанд ашигласнаа хүлээн зөвшөөрчээ. Сүхбаатар дүүргийн Эрүүгийн хэргийн анхан шатны шүүх эдгээр хэрэгтнүүдийг Эрүүгийн хуулийн тусгай ангийн 26.1 дүгээр зүйлийн 2 дахь хэсэгт заасан “бусадтай бүлэглэн цахим мэдээллийн сүлжээнд хууль бусаар халдаж мэдээллийг устгасан, өөрчилсөн, засварласан, мэдээлэл нэмж оруулсан, ашиглах боломжгүй болгосон, хэвийн үйл ажиллагаа алдагдуулсан” гэмт хэргийг үйлдсэн гэж үзэн, ял оноосон байна (185/2021/0460/Э индекстэй хэрэг, 2021). Энэ мэт албаны тоо мэдээ болон бодит кэйсүүд нь тролл сүлжээ Монголд байдаг бөгөөд цахим орчинд иргэдийн үзэл бодолд нөлөөлөх зорилгоор ашиглаж буйг харуулж байна.

Судалгаанд оролцогчдын мэдээлж буйгаар ч тролл сүлжээ нь Монголд нарийн зохион байгуулалтад орж, тусдаа эдийн засгийн салбар (industry) болсон ба ихэвчлэн улс төрийн болон бизнесийн ашиг сонирхол бүхий этгээдүүд санхүүжүүлдэг байна (Ярилцлага #5,15). Троллууд сонгууль, төсөв зэрэг улс төрийн томоохон үйл явдлуудын үеэр идэвхждэг ба тэдний зорилго нь тодорхой улс төрчийг

олон нийтийн дэмжлэгтэй мэт харагдуулах, өрсөлдөгчийг нь гутаан доромжлох (ШСТИНХС & ЭССТТ, 2021), эсвэл маргаантай асуудлаар иргэдийн санал бодлыг өөрчлөх, чиглүүлэхэд оршдог.

Тролл хаягуудын ард улс төрчид, бизнесийн бүлэглэлүүдээс гадна гаднын суртал ухуулгын сүлжээ ч байж (зохион байгуулах эсвэл үйлчилгээ авах байдлаар) болзошгүй талаар судалгаанд оролцогчид мэдээлсэн. Гэвч үүнийг зөвхөн ажиглалт дээр үндэслэж л таамаглаж байгаагаас, одоог хүртэл найдвартай нотолгоо байхгүй хэвээр байна.

1.1.8 Иргэд, олон нийт

Мэдээллийн орчны хамгийн өргөн хүрээний оролцогч бол энгийн иргэд, сошиал медиа хэрэглэгчид өөрсдөө юм. Тэдний олонх нь санаатайгаар хуурамч мэдээлэл үйлдвэрлэдэггүй ч, аливаа шуугиант мэдээ, цуурхлыг баталгаажуулалгүй түгээх байдлаар хуурамч мэдээллийг илүү далайцтай түгэхэд нөлөөлдөг байна.

Иргэд хуурамч мэдээлэл тараах нь олон шалтгаантай. Marwick (2018)-ийн үзсэнээр хүмүүс бусдад мэдээлэл өгөх, хуурамч мэдээлэл түгээхээс илүүтэйгээр өөрийн үзэл бодол, нийгмийн бүлгийн харьяалал, улс төрийн байр суурийг батлах, илэрхийлэх зорилгоор хуурамч мэдээллийг түгээдэг байна. Үүнийг өдөөгч хүчин зүйлс нь тухайн хувь хүний өмнөх итгэл үнэмшлээс гадна нийгмийн бүтэц, соёлын орчин, цахим платформын алгоритм зэрэг социотехникийн хүчин зүйлүүдийн нийлбэр юм. Эдгээрийн талаар дараагийн бүлгүүдэд дэлгэрэнгүй хэлэлцэх болно.

Дүгнэвэл, Монголын хуурамч мэдээллийн орчин нь ялгаатай түвшинд байрлах олон оролцогч талуудтай байна. Төр, улс төрчдөөс эхтэй зохион байгуулалттай хуурамч мэдээллүүд, гадаадын нөлөөтэй суртал ухуулга, мөн мэргэжлийн бус хэвлэл, инфлюенсер, тролл сүлжээ зэрэг дундын оролцогч талууд, иргэд олон нийтийн санаатай болон санаандгүй оруулж буй хувь нэмэр зэрэг нь хуурамч мэдээллийн цогц урсгалыг бүрдүүлж байна.

1.2 Хуурамч мэдээлэл түгээж буй суваг, арга техникүүд

Хуурамч мэдээллийг илүү олон хүнд хүргэх, үр нөлөөг нь нэмэгдүүлэхийн тулд талууд тодорхой суваг, платформуудаар, тухайн сувагт тохирсон төрөл бүрийн техникүүд ашигладаг. Тэгвэл энэ хэсэгт Монголд хуурамч мэдээлэл түгээхэд ашиглаж буй хамгийн түгээмэл сувгууд болон техникүүдийг тодруулах болно.

1.2.1 Сошиал медиа ба арга техникүүд

Монгол Улсын хувьд сошиал медиа, тэр дундаа Фэйсбүүкийн хэрэглээ өндөр бөгөөд мэдээлэл хүлээн авах гол сувгуудын нэг болоод байна. Дижитал дэд бүтэц сайжирч, дижитал технологийн хэрэглээ нэмэгдэхийн хэрээр уламжлалт мэдээллийн хэрэгсэл (телевиз, радио, сонин)-ийн тоо жил ирэх бүр цөөрч (Хэвлэлийн Хүрээлэн, 2025), эсрэгээрээ иргэд онлайн эх сурвалжуудаас мэдээлэл авах нь улам бүр нэмэгдэж байна. Тухайлбал, GGGI & IRIM (2023) нарын гүйцэтгэсэн үндэсний хэмжээний түүвэр судалгаанаас харахад иргэдийн улс төр, эдийн засаг, эрүүл мэнд, боловсрол, байгаль орчин зэрэг чухал сэдвийн талаар мэдээлэл авдаг эх сурвалжид телевиз (73.6%)-ийн дараа орох хоёр дахь үндсэн эх сурвалж нь интернет буюу вэбсайт, сошиал медиа (63.7%) байна. Ялангуяа 18-34 насны залуучуудын дунд интернет хамгийн гол мэдээллийн эх сурвалж байгаа ба нийт сошиал медиа хэрэглэгчдийн 95.1% нь Фэйсбүүк ашиглаж байна. Мөн DataReportal (2024)-ийн тайланд дурдсанаар Монгол Улсын нийт хүн амын 83.9% нь интернет ашигладаг, 13-аас дээш насны иргэдийн 100% нь Фэйсбүүк, 37.6% нь Инстаграм, 4.4% нь X (хуучнаар Твиттер) ашиглаж буй нь сошиал медиагийн өндөр хэрэглээг харуулж байна.

Тогтмол, идэвхтэй хэрэглэгчдийн тоо өндөр, мэдээлэл түгээх боломж хялбар, хямд зэргээс шалтгаалж Монголд хуурамч мэдээлэл түгдэг хамгийн том талбар нь Фэйсбүүк байна. Тухайлбал, Fact Check Mongolia санаачилга, factcheck.mn талбарын нягталж шалган олон нийтэд түгээсэн нийтлэлүүдээс харахад нийт хуурамч мэдээллийн 89% нь сошиал медиа, тэр дундаа Фэйсбүүк, 11% нь хэвлэл мэдээллийн хэрэгслийн сувгаар олон нийтэд хүрсэн байна (Fact Check Mongolia, 2021). БНОУХ & Хэвлэлийн хүрээлэн (2021)-ийн хэвлэл мэдээллийн мониторингийн үр дүнгээс харахад 2021 оны Ерөнхийлөгчийн сонгуулийн үеэр Фэйсбүүкд нийтлэгдсэн сонгуультай холбоотой мэдээллийн 80% нь гуйвуулсан, төөрөгдүүлсэн, худал мэдээлэл байсан бол 13% нь улс төрийн шууд сурталчилгаа, дөнгөж 7% нь л сэтгүүл зүйн мэдээ байжээ. Өөрөөр хэлбэл, Фэйсбүүк орчин нь хуурамч мэдээллийг түгээх, хамгийн олон хүнд, богино хугацаанд, тодорхой тактиктайгаар хүргэх боломжийг олгож байна. Харин Х (хуучнаар Твиттер) платформд улс төрийн болон нийгмийн зарим асуудлаар хэлэлцүүлэг өрнөдөг боловч идэвхитэй хэрэглэгчид харьцангуй цөөн, түгэж буй цар хүрээний хувьд Facebook-ээс бага.

Ярилцлагын үр дүн болон бусад судалгаа, мэдээллээс харахад **Фэйсбүүк дээр хуурамч мэдээллийг системтэйгээр түгээдэг бүлэг (Я.Болорчулуун & Д.Идэржаргал, 2019), тодорхой механизм тогтсон нь ажиглагдаж байна.** Үүнийг бүрэн нотлох хангалттай дата мэдээлэл байхгүй ч одоо байгаа мэдээлэлд үндэслэн дараах байдлаар таамаглах боломжтой байна. Томоохон эрх ашгийн төлөө, ялангуяа улс төр, геополитикийн зорилгоор түгээж буй хуурамч мэдээллүүдийг тодорхой пи-ар баг/агентлаг үйлдвэрлэж, бэлтгэдэг болох нь Фэйсбүүк дээр түгсэн ихээхэн хэмжээний хичээл зүтгэл (цаг хугацаа, санхүү, ур чадвар) зарж бүтээсэн зураг, теме, видео эвлүүлгүүд, бүтээлч нийтлэл, өгүүлэмжүүдээс харагддаг (Ярилцлага #6). Пи-ар багаас ирүүлсэн зааврын дагуу бэлдсэн контентуудыг инфлюенсер, тролл сүлжээ, "хармаа"-ны сайтууд, сэтгүүлчид, пэйжүүд зэрэг өмнө нь дурдсан мэдээлэл түгээгч талууд өөр өөрсдийн аккаунтдаа хувирган байршуулж, олон нийтэд түгээдэг байна. Ингэхдээ Фэйсбүүк платформын бүтэц, функцийн боломжуудад нийцүүлэн ашиглах тактик хэрэглэдэг нь тархалтыг эрс түргэсгэдэг.

Юун түрүүнд, эдгээр аккаунтууд дээр нийтэлсэн мэдээллүүдийг тролл хаягууд өөрсдийн аккаунт дээрээ болон олон тооны хэрэглэгчидтэй эсвэл зорилтот хэрэглэгчид цугласан группүүд рүү түгээдэг байна. Ингэхдээ тухайн бүлгийн итгэл үнэмшил, сонирхолд нь нийцэхүйц хэлбэрээр бэлтгэсэн мэдээллийг оруулж, уг мэдээлэл нь тэр группийн гишүүдийн дунд органикаараа тархаж эхэлдэг. Жишээлбэл, Я.Болорчулуун & Д.Идэржаргал (2019) нар Фэйсбүүк дэх 200 орчим хуурамч мэдээлэлд дүн шинжилгээ хийхэд тухайн мэдээллүүдийг 300 орчим хуурамч аккаунт, давхардаагүй тоогоор 59 групп, 138 хуудсаар дамжуулсан байна. Мөн 92 вэбсайт түгээлтэд оролцсоны дийлэнх нь мэргэжлийн ангилалд оруулах боломжгүй, редакцгүй сайтууд байжээ. Хуурамч мэдээлэл түгсэн группүүдийн дийлэнхийг хуурамч аккаунтууд ажиллуулж байсан нь сонирхол татахуйц үр дүн юм. Цаашилбал, эдгээр мэдээллийг 1,076 эх сурвалж 125,500 удаа цааш хуваалцаж (share), хамгийн багадаа 222,000 хүнд хүрсэн нь Фэйсбүүк дэх хуурамч мэдээллийн тархалт асар өндөр байгааг харуулж байна.

Үүн дээр нэмээд хуурамч мэдээллүүдийг илүү өргөн хүрээнд, олон хүнд хүргэхийн тулд Фэйсбүүкийн төлбөртэй сурталчилгаа (Boost) ашиглах ба тухайн мэдээллийг олон нийт дэмжиж буй мэтээр харуулах зорилгоор бот хаягуудыг ашигладаг (Ярилцлага #4, 9). Ингэж зохиомол хандалт үүсгэснээр Facebook-ийн алгоритм уг мэдээллийг бусад хэрэглэгчдэд автоматаар түгээж эхлэх нөхцөл бүрддэг байна.

Фэйсбүүк болон бусад сошиал медиагийн алгоритмууд хэрэглэгчийн оролцоог дээд хэмжээнд хүргэх, контентыг хувь хүнд тохируулж харуулах зорилготой байдаг тул хуурамч мэдээллийг санамсаргүйгээр түгээх нөхцөл болж байна (Ceylan et al., 2023; Д.Идэржаргал, 2017). Тухайлбал, оролцоонд суурилсан эрэмбэлэх системүүд (engagement-based ranking systems) нь илүү олон лайк, сэтгэгдэл авч, илүү олон түгээгдсэн мэдээллүүдийг эхэнд санал болгож, сенсаацтай буюу сэтгэл хөдлөл хүчтэй өдөөсөн контентыг (түүний дотор хуурамч, төөрөгдүүлсэн мэдээллийг) дэмжих хандлагатай байдаг (Ceylan et al., 2023). Харин хувь хүнд тохируулах алгоритмууд (personalization algorithms) нь

хэрэглэгчийн өмнөх үйлдэл, сонирхолд үндэслэн мэдээллийг шүүж харуулдаг тул өмнө нь түлхүү хариу үйлдэл үзүүлж байсан мэдээллүүд нь улам ихээр харагдана (Zimmer et al., 2019). Ийнхүү анх анхаарал татсан хуурамч мэдээллүүд алгоритмын тусламжтай өндөр давтамжтайгаар гарч ирж, чанаргүй эсвэл найдваргүй эх сурвалжууд олон хүнд хүрэх боломжтой болдог (Bandy & Diakopoulos, 2023).

Мэдээж алгоритмууд нь хуурамч мэдээллийг үйлдвэрлэдэггүй тул хувь хэрэглэгчийн мэдээллийн зан төлөвтэй хоршиж, тархалтыг нэмэгдүүлнэ. Үүнийг вакцины талаарх хуурамч мэдээллээр жишээ болгон тайлбарлъя. COVID-19 цар тахлын үед шинэ тутам вакцинуудтай холбоотой айдас, уур хилэн зэрэг хүчтэй сэтгэл хөдлөл төрүүлэхүйц, үндэслэлгүй хуурамч мэдээллүүд цацагдаж, үүнд итгэсэн, итгэл үнэмшилд нь нийцсэн хэрэглэгчид лайк дарах зэргээр хариу үйлдэл үзүүлж байв. Ингэж “вакцин үргүйдэл үүсгэдэг”, “вакцин бол чип” зэрэг хуурамч мэдээлэлд тодорхой давтамжтай хариу үйлдэл үзүүлсний дараа алгоритмууд тухайн хэрэглэгчдэд энэ төрлийн мэдээллүүдийг улам их харуулж, ижил сонирхолтой хүмүүсийн бөөгнөрлийг бий болгон, мэдээлэл хүлээн авах хүрээг нь явцуу, хязгаарлагдмал болгодог байна. Ингэж итгэл үнэмшил нь батжиж, хуурамч нарративт бүрэн итгэсэн хэрэглэгчид тухайн хуурамч мэдээллүүдийг цааш хуваалцаж, хуваалцсан мэдээлэл нь хандалт авах тусам урамшиж, тодорхой дадлыг төлөвшүүлдэг байна. Товчхондоо, алгоритмууд нь хэрэглэгчдийн мэдээлэл хүлээн авах, түгээх хэв маягтай хоршиж, хуурамч мэдээллийг илүү өргөн хүрээнд тархах нөхцөл болдог байна. Үүний үр дүнд сошиал медиа хэрэглэгчид өөрийн мэдэлгүй хуурамч мэдээллийг түгээдэг гол талуудын нэг болдгийг судалгаанд оролцогчид онцолж байв.

Дүрс 2. Фейсбүүк дэх хуурамч мэдээллийн тархалтын урсгал



Эх сурвалж: Судалгааны баг

Фейсбүүкээс бусад сошиал медиа платформуудын тухайд хуурамч мэдээлэлтэй холбоотой хийгдсэн судалгаа, мэдээллүүд байхгүй байна. Оролцогчдын мэдээлж буйгаар бусад платформууд дээр хуурамч мэдээлэл түгэх нь харьцангуй бага ч сүүлийн үед нэмэгдэх хандлага байгааг дурджээ (Ярилцлага #5, 6, 9).

1.2.2 Хэвлэл мэдээллийн хэрэгслүүд ба арга техникүүд

Хэвлэл мэдээллийн хэрэгслүүдээр илт худал мэдээлэл тархах нь харьцангуй бага ч өмнө нь дурдсанчлан дараах гурван байдлаар хуурамч мэдээлэл түгээхэд оролцдог байна.

Нэгдүгээрт, олон хэвлэл мэдээллийн хэрэгсэл улс төр, бизнесийн хүчний эзэмшил, нөлөөнд байдаг тул өмчлөгч, санхүүжүүлэгчийн ашиг сонирхолд нийцүүлж мэдээлэл дарах, гүйцэд мэдээлэхгүй байх, эсвэл эсрэг талын байр суурийг огт тусгахгүй орхих зэргээр хараат ажилладаг. Эдгээр нь шууд хуурамч мэдээлэл биш ч мэдээллийн өнцгийг гуйвуулах байдлаар олон нийтийн дунд ташаа ойлголт үлдээх эрсдэлтэй. Мөн зарим талууд мэргэжлийн редакцгүй, цөөн хүнтэй мэдээллийн вэбсайтууд ажиллуулж, түүгээрээ дамжуулан хуурамч мэдээлэл түгээдэг. Энэ төрлийн вэбсайтууд ихэвчлэн Фэйсбүүк хаягаараа дамжуулж олон нийтэд хүрч, иргэдийн дунд баттай эх сурвалжаас мэдээлж буй мэт төөрөгдөл үүсгэж, санал бодолд нь нөлөөлдөг.

Хоёрдугаарт, төр болон бизнесийн байгууллагууд үйл ажиллагаагаа олон нийтэд мэдээлэх зорилгоор хэвлэл мэдээллийн байгууллагуудтай “Хамтран ажиллах гэрээ” байгуулж, гэрээндээ захиалагч байгууллагын талаар сөрөг мэдээлэл түгээхгүй байх тухай заалтыг тусгадаг. “Хаалтын гэрээ” гэж нэрлэгдсэн уг тохироо нь зарим талаараа редакцийн хараат бус байдалд нөлөөлөх боломжтой аж. Мөн хамтран ажиллах гэрээний хүрээнд төрийн байгууллагаас бэлэн контент нийлүүлж, нотлох боломжгүй, төөрөгдүүлсэн мэдээллийг нэгэн зэрэг асар олон хэвлэл мэдээллийн хэрэгслээр түгээдэг нь пропаганда, манипуляцийн шинжтэй болохыг судалгаанд оролцогчид онцолж байв.

Гуравдугаарт, гаднын улс орнууд Монголын хэвлэл мэдээллийн байгууллагуудтай олон талаар хамтран ажиллах буюу зөөлөн аргаар, мөн мэдээлэл цацахыг эсэргүүцэх, хянах, эсвэл хүссэн мэдээлэл түгээхийг тулгах зэргээр хатуу аргаар өөрсдийн эрх ашигт нийцсэн мэдээллийг түгээх, пропаганда хийхийг хичээдэг байна.

Ярилцлагад оролцогчдын мэдээлж буйгаар талууд хэвлэл мэдээллээр хуурамч, төөрөгдүүлсэн мэдээлэл түгээхдээ дараах аргуудыг ашигладаг байна:

- Захиалгат мэдээ, мэргэжлийн нэвтрүүлэг бэлтгэн, түгээх;
- Нэг агуулгатай мэдээлэл, нэг контентыг олон сувгаар зэрэг түгээх;
- Нэг талын өнцөг барьсан мэдээллүүд бэлтгэн, түгээх зэрэг болно.

Сүүлийн жилүүдэд Засгийн газар, эрх баригчдад сөрөг нөлөөтэй томоохон асуудал дэгдсэн үед олны анхаарлыг өөр зүгт чиглүүлэх зорилгоор өөр нэг хүчтэй мэдээллийн давалгаа үүсгэн, анхаарал шаардсан чухал мэдээллээс сарниулах арга ашиглаж байж болзошгүйг оролцогчид дурдсан (Ярилцлага 5, 7). Тухайлбал, улсын төсөв хэлэлцэх, томоохон бодлого, шийдвэрүүд батлах үеэр нийгмийг цочроосон гэмт хэрэг, зөрчлүүдийн мэдээлэл хэвлэл мэдээллийн хэрэгслүүдээр хурдацтай тархаж, жирийн үед хаалттай байдаг мэдээллүүдийг ч олны өмнө ил болгодог байна.

1.3 Хуурамч мэдээллийн агуулга

Хуурамч мэдээллийн судалгаанд түүний өгүүлэмжийг ойлгох, цаг хугацааны явцад хэрхэн хувирч байгааг анзаарах нь ач холбогдолтой. Хуурамч мэдээлэлд ашигладаг хамгийн түгээмэл агуулгын төрөл нь худал, төөрөгдүүлсэн өгүүлэмж, эвлүүлэг зураг бөгөөд сүүлийн үед хиймэл оюуны тусламжтайгаар бүтээсэн синтетик контентууд нэмэгдэж байна.

Монголд хамгийн түгээмэл тархаж буй хуурамч мэдээллийн сэдвүүд нь 1) хүний эрүүл мэндтэй холбоотой (Ярилцлага 5, 6, 9, 14), 2) нийгэм, улс төрийн үйл явдалтай холбоотой (Ярилцлага 2, 3, 4, 6, 9, 14) 3) санхүүгийн залилангийн (Ярилцлага 5, 6, 7) шинжтэй мэдээллүүд дийлэнх хувийг эзэлж байна. Олон нийтийн мэдээлэл хүлээн авах зан үйлд гарч буй өөрчлөлтийн улмаас хүний анхаарал төвлөрөл суларч, тогтвортой төвлөрөх чадвар буурсаар байна. Үүний нөлөөгөөр урт мэдээ, текст унших нь


багасаж, хэдхэн секундын видео хэлбэрээр мэдээлэл хүлээн авах хандлага нэмэгдэж байна. Үүнээс гадна анхаарал татсан гарчиг, содон зураг ашиглан төөрөгдүүлэх аргыг түгээмэл ашиглах болсон (Ярилцлага 3, 9, 14). Мөн уншигч, мэдээлэл хүлээн авагчийн дурсамж, сэтгэл хөдлөлийг зорилготойгоор хөндөх байдлаар бэлтгэсэн агуулга ажиглагддаг (Ярилцлага 1, 4, 8, 9).

Судалгааны хүрээнд Монголд үйл ажиллагаа явуулдаг баримт шалгагч хоёр байгууллагын (factcheck.mn, MFCC) нягталсан хуурамч ташаа мэдээллүүдэд шинжилгээ хийж, Монголд тархаж буй хуурамч мэдээллийг сэдэв, ашиглаж буй арга хэлбэрийг тодруулахыг зорьсон. Тус хоёр байгууллагын цахим хуудсанд 2020 оны 1-р сараас 2025 оны 9 сарыг дуустал хугацаанд нийтлэгдсэн нийт 1,618 мэдээнд шинжилгээ хийв.

Ингэхдээ мэдээний өгүүлэмжид бүхлээр нь шинжилгээ хийгээгүй бөгөөд зөвхөн мэдээний агуулгыг ерөнхий сэдэв, дэд сэдвүүдэд ангилан авч үзсэн. Өгөгдлийн зарим талбар бүрэн бус байсан тул шинжилгээ тус бүрт бүрэн бус өгөгдлийг хассан. Монголд тархаж буй хуурамч мэдээллүүд нь эдгээр 1,618 мэдээгээр хязгаарлагдахгүй гэдгийг дурдах нь зүйтэй бөгөөд эдгээр мэдээнүүд нь зөвхөн цахим орчинд тархаж буй хуурамч мэдээллүүдээс дээрх хоёр байгууллагын сонгон авч нягталсан мэдээллүүд болно.


Эдгээр мэдээллүүдийг сэдвийн хувьд 8 ерөнхий ангилал, 28 дэд ангилалд хуваан авч үзсэн. Ингэхэд хуурамч мэдээллийн хамгийн түгээмэл сэдэв нь хүний эрүүл мэндтэй холбоотой мэдээллүүд байв (Дүрс 3). Ярилцлагад оролцогсдын дурдсанаар зарим сэдвээр тараадаг хуурамч мэдээллүүд нь улирлын шинжтэй эсвэл тодорхой нэг үйл явдалтай холбоотойгоор нэмэгдэх шинжтэй байдаг бол эрүүл мэндийн сэдэвтэй мэдээлэл байнга ажиглагдах болсон байна. (Ярилцлага 3, 5, 13).

Дүрс 3. Хуурамч мэдээллийн сэдвүүд, (n=1618)



Сэдвийн хувьд нотлогдоогүй зөвлөгөө эмчилгээ, COVID-19-ын вакцин, умайн хүзүүний хорт хавдарын эсрэг вакцин, болон бүх төрлийн вакциныг эсэргүүцсэн агуулгатай мэдээлэл зонхилж байна. Төрөл бүрийн вакцин эсэргүүцсэн агуулгатай мэдээллүүдийг тодорхой тооны хэрэглэгч тогтмол хугацаанд оруулдаг 2024 оны 11-р сард хүний папилома вирусын эсрэг вакцины тухай хуурамч мэдээлэл огцом ихэссэн байна (Дүрс 4). Өгүүлэмжийн хувьд вакцин эсэргүүцсэн агуулгатай мэдээллүүд нь голдуу айдас төрүүлсэн худал баримт, зураг ашигласан байх бөгөөд вакцин эрүүл мэнд, амь нас, монгол хүний удмын санд хортой, дэлхийн улс орнууд вакцинжуулалтаа зогсоолоо гэх мэт өгүүлэмжтэй байна.

Дүрс 4. Вакцины тухай сэдэвтэй мэдээллийн тоо, сараар




Вакцинтай холбоотой энэхүү их хэмжээний хуурамч мэдээлэл нь олон нийтийн эрүүл мэндэд эрсдэл үүсгэх үр дагаварт хүргэж болзошгүй бөгөөд жишээлбэл вакцинаар бүрэн сэргийлэх боломжтой Улаанбурхан өвчин 2025 оны 2-р сараас эхлэн дэгдэж 13,000 хүн өвчилж 11 хүн нас барсан тохиолдол гарчээ (News.mn, 2025).

Мөн вакцины тухай хуурамч мэдээлэл түгээж байсан хаягууд Орос Украины дайны тухай мэдээлэл эсвэл уран олборлохыг эсэргүүцсэн мэдээллийг түгээж байсан давхцал ажиглагдсан тухай ярилцлагын үеэр дурдсан (Ярилцлага #4, 5).


Баримт шалгасан хуурамч мэдээллүүд цаг хугацааны хувьд хэрхэн тархсаныг дараах зурагт харуулав. Гэхдээ энэхүү зураг нь цаг хугацааны явцад хуурамч мэдээлэл хэрхэн нэмэгдэж, буурч байгааг харуулахгүй, харин баримт шалгах төвүүдийн таньж тогтоосон хуурамч мэдээллийн тоо цаг хугацааны явцад хэрхэн өөрчлөгдөж байгааг л харуулна. Зурагт харагдах динамикд олон төрлийн хүчин зүйл нөлөөлж болно.

Дүрс 5. Нягтлагдсан хуурамч мэдээллийн тоо, сараар



Энэ хугацаанд нягтлагдсан хуурамч мэдээллүүд нь ихэвчлэн худал өгүүлэмж зохиох болон баримт материалыг гуйвуулан ашиглаж төөрөгдүүлэх шинжтэй байна (Дүрс 6). Deepfake ашиглан бүтээсэн бичлэг харьцангуй цөөн байгаагаас харахад хэдий синтетик медиа шинээр гарч ирж буй ч Монголын хуурамч мэдээллийн орчинд уламжлалт арга техникүүд давамгайл хэвээр байна.

Дүрс 6. Хуурамч мэдээлэлд ашиглаж буй аргууд (n=1618)



Дотоод улс төртэй холбоотой хуурамч мэдээлэл

Дотоод улс төртэй холбоотой хуурамч мэдээлэл хамгийн өргөн тархдаг үе нь ихэвчлэн улс төрийн сонгуулийн мөчлөг байдаг. Сонгуулийн сурталчилгааны хугацаа богино, нэгэнт тархсан худал мэдээллийг залруулах боломж хязгаарлагдмал тул өрсөлдөгчийн нэр хүндийг унагах зорилготой гүтгэлгийн шинжтэй контентыг зориуд түгээх нөхцөл бүрддэг. Энэ технологи өргөн тархаж, зохион байгуулалттай тролл бүлгүүдийг ашиглан мэдээллийг богино хугацаанд олон нийтийн сүлжээгээр түгээж байгаа нь ажиглагддаг (Ярилцлага 6).

Ярилцлагад оролцогчид төр болон Засгийн газрын зарим байгууллага, албан тушаалтнууд өөрсдөө тодорхой нөхцөлд хуурамч эсвэл төөрөгдүүлсэн мэдээлэл түгээх тохиолдол ажиглагддаг тухай дурдсан. Тэдний өгүүлснээр, ийм мэдээлэл нь олон нийтэд бодит байдлын талаарх ойлголтыг бүдгэрүүлэх, улс төрийн өрсөлдөгч институтуудын нэр хүндийг сулруулах зэрэг зорилготой байж болзошгүй. Тухайлбал, шүүх эрх мэдлийн нэр төрд халдсан агуулгатай, батлах буюу үгүйсгэхэд төвөгтэй, мэдээллийн эх сурвалж нь тодорхой бус контентууд тодорхой давтамжтайгаар түгээгддэг нь ажиглагдсан гэж ярилцагчид тэмдэглэсэн (Ярилцлага 5, 7).

Цаг үеийн болон нийгэм, эдийн засгийн тодорхой нэг үйл явдалтай холбоотой хуурамч мэдээлэл түгээх нь түгээмэл болж, энэ нь олон нийтэд бодит бус ойлголт төрүүлэх, улмаар тухайн асуудлаар бодлого тодорхойлогчид, олон нийт, орон нутгийн иргэдийн хооронд үл ойлголцол бий болгох нөхцөл болж байна. Жишээлбэл, 2025 оны 1-р сард Монгол Улс Франц Улстай ураны төсөлд хамтран ажиллах хөрөнгө оруулалтын гэрээ байгуулсан нь энэ тухай хуурамч мэдээллийн тархалтыг идэвхижүүлснийг баримт шалгах төвүүдийн мэдээллээс харж болно. Энэ үйл явдал олон нийтийн анхаарлын төвд орж, ураны олборлолтоос байгаль орчинд үзүүлэх нөлөөлөл, цацрагийн аюулгүй байдлын тухай олон нийтийн санаа зовнил нэмэгдэж үүний зэрэгцээ худал, төөрөгдүүлсэн агуулгатай мэдээлэл цахим орчинд 2 сард хамгийн ихээр таржээ. Зарим өгүүлэмжээс дурдвал:

- “Ураны орд газар байрлах Дорноговь аймгийн Улаанбадрах суманд 2012 туршилтын олборлолт хийснээс болж тухайн жилд Дорноговь аймагт 10860 эх зулбасан”,
- “Улаанбадрахад цацрагийн хэмжээ Чернобылтэй адил хэмжээнд байгааг гадны эрдэмтэд нотоллоо”,
- “Уранд хордож мутацид орсон 2 ам 3 нүдтэй ишиг” зэрэг байна. Эдгээр мэдээллүүдэд төөрөгдүүлсэн баримт, өөр үйл явдлын зураг бичлэг ашиглах, эсвэл худал өгүүлэмж ашиглажээ.

Дүрс 7. Уран олборлох тухай сэдэвтэй мэдээллийн тоо, сараар



Энэ төрлийн мэдээллүүд нь “баялгийг өмчирхөх үндсэрхэг үзэл (resource nationalism)”-тай мөн холбогдох бөгөөд гадаадын, ялангуяа гуравдагч хөрш орны хөрөнгө оруулалтыг эсэргүүцэх нийгмийн сэтгэл зүйг чиглүүлэх хэрэгсэл болж ашиглагдаж байж болзошгүй юм. Ярилцлагын үеэр, “баялгийг өмчирхөх үндсэрхэг үзэл”-ийг идэвхтэй ашигладаг тодорхой байгууллагын зохион байгуулсан үйл ажиллагаанд Монголын талууд оролцож байсан талаар дурдагдсан (Ярилцлага #5) боловч энэ төрлийн хуурамч мэдээлэл түгээх үйл ажиллагаа болон эдгээр байгууллагын хооронд тодорхой харилцаа байгааг эсэхийг нотлоход илүү дэлгэрэнгүй баримт мэдээлэл шаардлагатай юм.

2.Хуурамч мэдээллийн үр нөлөө

Хуурамч мэдээллийн нөлөө нь олон талтай, нарийн нийлмэл (multifaceted) бөгөөд хэмжихэд төвөгтэй асуудлуудын нэг юм (Warin, 2024). Олон улсын түвшинд энэ сэдэв харьцангуй сайн судлагдсан бөгөөд тэдгээр судалгааны ажлуудад хуурамч мэдээллийн нөлөөг шинжлэх ухааны салбараар (эрүүл мэнд, эдийн засаг, улс төр...), нөлөөллийн түвшнээр (хувь хүн, институц, нийгэм), нөлөөлөл үзүүлж буй талуудаар (төр, хэвлэл мэдээлэл, олон нийт), мөн баримтаар нотлох боломжийн хувьд (factual буюу unspecified) гэх мэт олон өнцгөөс ангилан судалж иржээ.

Тухайлбал, аюулгүй байдлын бодлогын судлаачдын өнцөгөөр хуурамч мэдээлэл нь улс орны аюулгүй, тогтвортой байдалд ноцтой заналхийлэл учруулж, үндэстэн хоорондын дипломат харилцаанд сэв суулгах, үндэстний дотоод харилцааг хурцатгах, хүчирхийлэл, эсэргүүцэл, мөргөлдөөнийг өдөөх (Mohammed Hafiz Nabila, Matilda Thompson, 2025) эрсдэлийг дагуулж байдаг бол эрүүл мэндийн салбарт хуурамч мэдээлэл нь шинжлэх ухааны үндэслэлтэй урьдчилан сэргийлэх арга хэмжээг хэрэгжүүлэх боломжгүй болгож, улмаар олон хүнийг үхлийн үр дагаварт хүргэж байгааг тэмдэглэсэн байна (Posetti, 2021; Sezer Kisa, Adnan Kisa, 2024).

Эдийн засагчдын хийсэн тооцоолоор дэлхий дахинд нэг жилд ойролцоогоор хуурамч мэдээллээс үүдэлтэй 78 тэрбум ам.долларын шууд болон шууд бус хохирол учирч байдаг бөгөөд үүнээс 17 тэрбум ам.доллар нь хуурамч мэдээллээс үүдэлтэй санхүүгийн буруу шийдвэрүүдийн үр дагавар байна (University of Baltimore, CHEQ, 2019). Харин улс төр судлаачдын өнцөгөөс хуурамч мэдээллийн хамгийн ноцтой үр дагавар бол “ардчиллын үндэс болох мэдээллийн орчныг доройтуулах” (Colomina, C.; Sánchez Margalef, H.; Youngs, R., 2021) ардчиллын тулгуур үнэт зүйлсийг ганхуулах явдал юм.


Хуурамч мэдээллийн нөлөөллийн түвшин (impact strength) улс орон бүрт харилцан адилгүй бөгөөд “Хуурамч мэдээллийг сөрөн тэсвэрлэх чадавх” (resilience)-ыг дэлхийн нийт улсуудын хэмжээнд харьцуулсан индекс одоогоор байхгүй. Гэвч Humphrit тэргүүтэй зарим судлаачид улс орнуудын хуурамч мэдээллийн сөрөн тэсвэрлэх чадавхад нөлөөлж байдаг зарим факторуудыг судалгаагаараа дэвшүүлсэн байдаг. Үүнд: (1) Нийгмийн талцал хуваагдал их байх, (2) Популист коммуникац их байх, (3) Хэвлэл мэдээллийн байгууллагуудад итгэх иргэдийн итгэл сул байх, (4) Үндэсний олон нийтийн хэвлэл мэдээллийн чадавх сул байх, (5) Зар сурталчилгааны зах зээлийн хэмжээ бага байх болон (6) иргэдийн сошиал медиа хэрэглээний түвшин өндөр байх зэрэг үзүүлэлтүүдийг авч үзсэн байна (Humprecht, E., Esser, F., & Van Aelst, P., 2020). Ерөнхийд нь авч үзвэл, аливаа улс орны хуурамч мэдээлэлд тэсвэртэй байх чадавх нь зөвхөн технологи, эсвэл баримт нягтлан шалгах чадавхаас хамаарах бус, харин мэдээллийн орчны тогтвортой байдалд нөлөөлж байдаг улс төрийн соёл, хэвлэл мэдээллийн шударга байдал, нийгмийн нэгдэл, нягтрал зэрэг өргөн хүрээний хүчин зүйлсээс ихээхэн шалтгаалдаг байна.

Монгол Улсад хуурамч мэдээллийн нөлөөллийг нарийвчлан судалсан судалгаа хомс хэдий ч зарим холбогдолтой цөөн ажлууд хийгдэж ирсэн. Тухайлбал, Аюулгүй байдал судлалын хүрээлэн Монгол Улсын Мэдээллийн сөрөн тэсвэрлэх чадавхыг (1) Сэтгүүл зүйн салбарын эдийн засгийн бие даасан байдал, (2) Сэтгүүл зүйн салбарын оюуны бүтээл нь иргэдийн оюуны хэрэгцээг хангаж буй байдал, (3) Хэвлэл мэдээллийн байгууллагуудын нэгдмэл байдал, (4) иргэд, олон нийтийн цахим ур чадвар гэсэн бүтцийн түвшний дөрвөн индикатороор 2024 онд үнэлсэн бөгөөд Монгол Улс бүх үзүүлэлтээр хангалтгүй буюу хуурамч мэдээллийг сөрөн тэсвэрлэх чадавх сул дүгнэгдсэн байна (АБСХ, 2025).

Мөн OptimalNMax компанийн 2024 оны судалгаа хуурамч мэдээллийн тархалтад нөлөөлөгч хүчин зүйлсийг хувь хүний түвшинд, БНОУХ 2020 оноос хойш олон нийтийн санал бодлын судалгаандаа хуурамч мэдээллийн талаарх иргэдийн хандлагыг тус тус судалж иржээ.

Эдгээр судалгаанууд болон хэвлэл мэдээлэл, улс төрийн салбарын 15 эксперттэй хийсэн чанарын ярилцлагад тулгуурлан, Монгол Улсад ажиглагдаж буй хуурамч мэдээллийн нөлөөллийг энэхүү бүлэгт авч үзлээ. Ингэхдээ улс төртэй холбоотой хуурамч мэдээллийн нөлөөлөлд илүү төвлөрч, **хувь хүн болон нийгмийн түвшинд** гарч буй нөлөөллийг илүү тодруулав.

Дүрс 8. Монголд хуурамч мэдээлэл ардчиллыг сулруулахад хэрхэн нөлөөлж буй байдал



Эх сурвалж: Судалгааны баг

Судалгааны үр дүнгээр улс төртэй холбоотой хуурамч мэдээлэл нь **хувь хүний түвшинд** сэтгэлзүйн стресс, бухимдал, түгшүүрийг ихээр өдөөхөөс гадна, улс төртэй холбоотой худал ойлголт буюу танин мэдэхүйн гажуудлыг ихээр үүсгэдэг байна. Улмаар энэхүү нөлөөлөл удаан хугацаанд, олон арга техникээр давтагдан үргэлжлэх тусам иргэдийн итгэл үнэмшилд нөлөөлж, цаашлаад иргэдийн төөрөгдөл нэмэгдэх тусам хэвлэл мэдээлэлд, төрийн байгууллагууд, институцэд болон ардчилсан үйл явцад итгэх итгэл суларч байгаа нь хуурамч мэдээллийн хамгийн хүчтэй үр дагавар байна. Нийгмийн итгэлцэл суларснаар улс төрийн туйлшрал, талцал нэмэгдэх, нөгөө талд хуурамч мэдээлэлтэй тэмцэх арга хэмжээ нь хүний эрхийн, хэвлэл мэдээллийн салбарт зарим тулгамдсан асуудлуудыг бий болгож байгааг тус судалгааны үр дүнгүүд харуулсан. Эдгээр нь ардчилсан институцийн тогтвортой байдал, үйл явц, үнэт зүйл зэргийг сулруулж ардчиллын легитим байдлыг урт хугацаанд доройтуулах талтай.


Эдгээр үр дүнгүүдийг холбогдох баримтуудын хамт дор дэлгэрүүлэн тайлбарлая.

2.1 Хуурамч мэдээллийн нийгмийн түвшний үр нөлөө

1. Хуурамч мэдээлэл иргэд хоорондын итгэлцлийг сулруулахад нөлөөлөх нь: Ярилцлагын мэдээллээр Монголчуудын дунд илэрч буй хуурамч мэдээллийн хамгийн нийтлэг нөлөөллийн нэг нь иргэд хоорондын итгэлцэл сулрах явдал байна. Органикаар иргэд хуурамч мэдээлэлд итгэж хууртагдан, уг нөхцөл байдал олон дахин давтагдах тусам иргэдийн бусдад итгэх итгэл аажмаар суларч эхэлдэг (Ярилцлага #1, 2). Тодруулбал, “Монголчуудын нийгмийн сайн сайхан байдлын судалгаа”-аар 2018-2022 онуудад Монголчуудын бие биедээ итгэх итгэлийг 10 шкалаар үнэлүүлэхэд **4.6-аас 4.1 болж буурсан** дүнтэй байна (Я.Бямбасүрэн, 2024). Түүнчлэн ерөнхийд нь хэлбэл та ихэнх хүмүүст итгэж болно гэж боддог уу? гэдэг асуултад “бусдад итгэхгүй/маш болгоомжтой байх хэрэгтэй” гэж хариулсан Монголчуудын хувь 2018 онд 61% байсан бол 2022 онд 69.7% болж өссөн байх ба уг үр дүнд нөлөөлж


буй хүчин зүйлсийн нэгд “хуурамч мэдээллийн нөлөө” зүй ёсоор тусаж буйг судалгааны баг дүгнэлтэндээ дурдсан байна (IRIM, 2018,2022). Хэдийгээр Монголчуудын бие биедээ итгэх итгэлцлийн үзүүлэлт буурч буй нь зөвхөн хуурамч мэдээллээс хамааралтай гэж тайлбарлаж болохгүй ч, уг хоёр үзүүлэлт хооронд тодорхой хамаарал бийг өмнөх судалгаад болон ярилцлагын үр дүнгүүд харуулж байв.

Дүрс 9. Монголчуудын бие биедээ итгэх итгэлцэлд гарч буй өөрчлөлт, 0-10 хүртэлх шкалын дундаж утга 2018, 2022



Эх сурвалж: IRIM, Монголчуудын Нийгмийн сайн сайхан байдлын судалгаа

Дүрс 10. Ерөнхийд нь хэлбэл ихэнх хүмүүст итгэж болно гэж боддог үү?, 2018, 2022



Эх сурвалж: IRIM, Монголчуудын Нийгмийн сайн сайхан байдлын судалгаа

Үүнээс гадна хуурамч мэдээлэл байнгын давтамжтай, олон янзын хэлбэрээр явагдаж буй мэдээллийн хэт нийлүүлэлт нь тухайн мэдээлэлд итгүүлэх гэдэг зорилгоос гадна иргэдийн ер нь ямар ч мэдээлэлд итгэх итгэлийг сулруулах, төөрөгдөлд оруулж, улмаар **нийгмийн сэтгэл зүйг эмзэг, тогтворгүй болгож байгааг** ярилцлагад оролцогчид онцолж байв (Ярилцлага #3, 10, 11, 14). Нийгэм сэтгэлзүйн эмзэг, тогтворгүй байдал гэдгийг тодруулбал олон нийтийн дунд стресс, түгшүүр, аюулгүйн мэдрэмж буурах байдлыг оролцогчид илүү дурджээ. Мэдээллийн хэт нийлүүлэлт, олон давтамж (hyper-saturation) болон бусад нийгмийн хүчин зүйлс (хувьсал, хямрал) нь олон нийтийн итгэлцлийг унагаж, нийгмийн сэтгэлзүйн эмзэг байдлыг нэмэгдүүлэх замаар **манипуляцид өртөх эмзэг байдлыг нэмэгдүүлдэг** байна (Sadiq Muhammed T, Saji K Mathew , 2022).

2. Олон нийтийн хэвлэл мэдээлэлд итгэх итгэл сулрах: Хуурамч мэдээллийн хамгийн хүчтэй нөлөөлж буй нөлөөллийн өөр нэг илрэлд иргэдийн хэвлэл мэдээлэлд итгэх итгэл сулрах байдал зүй ёсоор нэрлэгдэж байна (Ярилцлага #2,3,4,5,6,11,13). БНОУХ-ийн иргэдийн санал бодлын судалгааны үр дүнгээр Монголчуудын хэвлэл мэдээлэлд хандах ерөнхий хандлага бусад байгууллагуудтай харьцуулахад харьцангуй эерэг (55%), гэхдээ хэвлэл мэдээллийн байгууллага аливаа асуудлыг хараат бусаар, чөлөөтэй хэвлэн нийтлэх байдал сул байгаа гэж дийлэнх хэсэг (56.1%) нь үзжээ (БНОУХ, 2024). Уг үр дүнг 2022 оны үр дүнтэй харьцуулахад сөрөг үнэлгээ нь мэдэгдэхүйц нэмэгдсэн болох нь харагдаж байна.

Дүрс 11. Хуурамч мэдээллийг ноцтой асуудал гэж авч үзэж буй иргэдийн хэвлэл мэдээллийн байгууллагад хандах хандлага, 2021, 2024



Эх сурвалж: Олон нийтийн санал бодлын судалгаа, 2022, 2024

Ялангуяа, редакцын бодлогогүй, 1-3 ажилтантай зөвхөн сошиал медиад мэдээлэл түгээдэг цахим сайтууд болон хувийн эзэмшлийн уламжлалт медиа хэрэгслүүдэд итгэх олон нийтийн итгэл илүү сул байгааг тодруулах хэрэгтэй (Ярилцлага #1, 3, 4, 11, 13).

2024 оны байдлаар Монголд 389 хэвлэл мэдээллийн хэрэгсэл идэвхтэй үйл ажиллагаа явуулж байгаагийн 42% нь цахим сайт, 73% нь хувийн эзэмшилд байна (Хэвлэлийнхүрээлэн, 2025). Цахим сайтуудын бизнес загвар нь сошиал медиан алгоритмын дагуу хандалт их татах агуулгыг түлхүү түгээхэд төвлөрдөг тул иргэдийн хандалтыг их авахын тулд сэтгүүлчид улс төр, нийгмийн үйл явдлыг мэдээлэхдээ илүү сэтгэл хөдлөлийн өнгө аяс оруулах, үйл явдлыг мэдээлэхдээ зарим тохиолдолд аль нэг талын байр суурийг илт дэмжих эсвэл эсэргүүцэх хандлага шингээх болсон. Энэ нь иргэдийн хэвлэл мэдээллийн мэргэжлийн, хөндлөнгийн байр сууринд эргэлзэхэд ихээхэн нөлөөлөх болсныг Монголын Сэтгүүлчдийн Нэгдсэн Холбоо (МСНЭ, 2025/6) сэтгүүлчдэд зориулсан уриалгадаа дурдсан байна. Мөн сэтгүүл зүйн салбарын мэргэжлийн байдал, ёс зүй алдагдах, төлбөртэй контент, хаалтын гэрээ хийх, зарим сэтгүүлчид хуурамч мэдээллийг түгээж байгаа тохиолдлууд нь тус салбарын нэр хүнд, иргэдийн итгэлцлийг сулруулахад нөлөөлж буй хүчин зүйлс болж байгааг судалгаанд оролцогчид онцолж байв (Ярилцлага #3, 4, 6, 13).

3.Иргэдийн төрд итгэх итгэл сулрах: Орчин үеийн нөхцөлд улс төртэй холбоотой хуурамч мэдээлэл нь ардчилсан тогтолцоон дахь итгэлцлийн багануудыг чиглэж, төр, улс төрчид, улс төрийн намууд болон төрийн институциудыг гол бай болгодог. Аль ч ардчилсан нийгэмд төрийн үйл ажиллагаанд шүүмжлэлтэй хандах, хяналт тавих иргэний оролцоо чухал хэдий ч төрд итгэх итгэл хэт буурах, төрийн бүх институцид итгэх итгэлцэл системийн хэмжээнд доошлох нь урт хугацаандаа ардчиллын суурийг ганхуулах сөрөг үр дагавартай болохыг ярилцлагад оролцогчид онцлон тэмдэглэж байв (Ярилцлага #3, 7, 9, 10, 11, 13).

Ялангуяа шүүх тогтолцоо уруу чиглэсэн хуурамч мэдээллийн урсгал нь иргэдийн төрийн шударга байдалд итгэх итгэлд хамгийн их нөлөө үзүүлдэг хэмээн олон ярилцлагад дурдагдсан. Тухайлбал, “шүүгч, өмгөөлөгч нар худалдагдсан”, “авлигад идэгдсэн”, “үнэн зөв шийдвэр гаргадаггүй” гэх хэв маягтай, давтамжтай, зохион байгуулалттай хуурамч нарратив сүүлийн жилүүдэд хүчтэй тархаж байгааг зарим оролцогчид онцолсон. Ийм мэдээлэл нь төр, засгийн түвшинд зохион байгуулалттайгаар түгж байсан жишээ ч ажиглагдаж байжээ (Ярилцлага #7,9).


Засгийн зүгээс дахин дахин яваад байсан хэв маяг бол шүүхэд итгэх итгэлийг бууруулах уруу чиглэсэн дайралтууд бол яг pattern болж харагдсан. Маш тодорхой хатгаж байгаа асуудал дээр бол хүмүүс эрхээ хамгаалаад босоод ирж байгаа юм, жишээ нь Ноорог-ийн жишээ, яг ийм асуудал надад ч тохиолдож болохын байна гэж хүн тодорхой харвал хариу үйлдэл үзүүлж байна.

Гэтэл шүүхийн жишээ шиг маш тодорхойгүй, барьцгүй, няцаашгүй ийм нарративууд явахаар яг ямар асуудал байгаа гээд реакцлахад хэцүү, ер нь л ямар нэг юм нь болохгүй байгаа юм байна гэдэг мэдрэмжийг олон нийтэд төрүүлээд байгаа нь иргэдийн итгэлцэл, ардчиллын үнэт зүйлд цаагуураа маш хор нөлөөтэй.

Ярилцлагын хэсгээс

Эдгээр ажиглалтыг олон нийтийн санал бодлын судалгааны тоон үр дүн бататгаж байна. 2024 онд БНОУХ-ийн гүйцэтгэсэн судалгаагаар иргэдийн дунд хамгийн сөрөг хандлагатай институциуд нь улс төрийн намууд (75%), Сонгуулийн ерөнхий хороо (67%), шүүх тогтолцоо (64%) жагсжээ.

Дүрс 12. Хуурамч мэдээллийг ноцтой асуудал гэж авч үзэж буй иргэдийн төрийн байгууллагуудыг авч үзэх сөрөг хандлага, 2021, 2024




Эх сурвалж: Олон нийтийн санал бодлын судалгаа, 2021, 2024

Төрийн болон улс төрийн институциудад итгэх итгэлийн түвшинг хэмжсэн бусад судалгаануудын үр дүнгүүдийг харьцуулбал мөн ойролцоо чиг хандлага ажиглагдаж байна. Сант Марал ТББ-ын жил бүрийн “Улс төрийн барометрийн судалгаа”-ны үзүүлэлт итгэлцлийн үзүүлэлт нь бусад судалгаанаас харьцангуй өндөр боловч хэлбэлзэл ихтэй. Харин дөрвөн жил тутам хийгддэг Азийн Барометрийн судалгаагаар сүүлийн найман жилийн туршид итгэлийн түвшин харьцангуй тогтвортой байгаа бол, таван жил тутам хийгддэг “Монголчуудын нийгмийн сайн сайхан байдлын судалгаа”-гаар төрд итгэх итгэл аажмаар буурч буй үр дүнгүүд гарчээ.

Нийт дүнгээр авч үзвэл, богино хугацаанд төрд итгэх итгэлийн хэлбэлзэл улс төр, эдийн засгийн нөхцөл байдлаас хамаарч өөрчлөгдөж байгаа ч урт хугацааны чиг хандлага нь аажим бууралттай байна. Үүнийг нөгөө талаас иргэд төрийн бодит гүйцэтгэл, хариуцлага, ил тод байдалд илүү мэдрэг болж буйтай холбон тайлбарлаж болох юм.

Дүрс 13. Төрийн байгууллагуудад итгэх итгэлийн түвшин, 2014, 2018, 2022




Эх сурвалж: Азийн Барометрийн судалгаа, 2014, 2018, 2022

4.Хуурамч мэдээлэл нийгмийн талцал, туйлшралыг нэмэгдүүлэхэд нөлөөлөх нь: Судалгаанд оролцогчид цахим орчин дахь нийгмийн талцал, туйлшралд хуурамч мэдээлэл хүчтэй нөлөө үзүүлж буйг онцолсон. Монголын нөхцөлд нийгмийн талцал хүчтэй илэрч буй сэдвүүдийг авч үзвэл байгаль орчны асуудал (сэргээгдэх эрчим хүчний шилжилт, нүүрсний станцууд), уул уурхай (лиценз ба олборлолтын нөлөөлөл), эрүүл мэнд (вакцинтай холбоотой маргаан), хүний эрх (цаазын ялыг сэргээх асуудал), шашин (10-р Богдыг тойрсон маргаан) зэрэг сэдвүүд давамгайлж байна (Ярилцлага #2, 7, 8, 10, 13).

Зарим оролцогчдын (Ярилцлага #10, 13) үзэж байгаагаар, эдгээр сэдвээр үүсэж буй маргаан, талцал нь нийгэм дэх үзэл баримтлалын органик ялгаанаас илүүтэйгээр зориуд өдөөсөн, сэтгэл хөдлөлд тулгуурласан, тролл хаягийн оролцоо ихтэй зэрэг нийтлэг шинжүүдийг дурдаж байв. Мөн улс төрийн хувьд чухал мөчүүд, сонгууль, төсвийн хэлэлцүүлгийн үе гэх мэт томоохон шийдвэр гаргалтын өмнөх хугацаанд ийм талцал эрчимждэг нь олон нийтийн анхаарлыг сатааруулах нэг төрлийн тактик байж болзошгүй гэж үзэж байв (Ярилцлага #7).

Тоон судалгааны дүнгээр ч энэ хандлага тодорхой ажиглагддаг. Азийн Барометрийн судалгаагаар (2014–2022) Монголчуудын ойролцоогоор гурван хүн тутмын нэг нь улс төрийн туйлшрал мэдэрдэг гэж хариулсан байна. Энэ нь Азийн бусад улс орнуудтай харьцуулахад дунд түвшинд буюу хэт хурцадмал бус боловч тодорхой хэмжээгээр талцал туйлшрал илэрч буйг харуулдаг.


Дүрс 14. Найзууд эсвэл хамт ажиллагсдын улс төрийн үзэл бодол өөр байвал, тэдэнтэй ойлголцож ярилцахад бэрхшээлтэй байдаг гэж хариулсан иргэдийн хувь



Эх сурвалж: Asian Barometer Survey, 2014-2022

V-Dem-ийн гаргадаг Political polarization index-ийн дагуу Монголын улс төрийн туйлшралын түвшин 0.01 (0–4 хооронд), бусад улс орнуудтай харьцуулахад дунд түвшинд, гэхдээ 1999–2024 оны урт хугацааны өөрчлөлтийг авч үзвэл бага зэрэг өсөх хандлага илэрч байна.

Дүрс 15. Монголчуудын улс төрийн хуваагдал, 1999-2024



Эх сурвалж: V-DEM data

Улс төрийн талцал хамгийн өссөн жилүүдийг харвал 2008-2009 онд буюу Улсын Их Хурал (УИХ)-ын сонгуулийн үр дүнг эсэргүүцсэн жагсаалын үеэр хамгийн хүчтэй хуваагдаж, түүнээс хойш 2012 оны сонгуулиар, 2020-2022 онд буюу COVID-19 цар тахлын үед дараагийн эрчимжилт явагдаж байжээ. Ялангуяа цар тахлын үе дэхь сэтгэл зүйн хямрал, тодорхойгүй байдал нь иргэдийн үзэл бодлыг хуваагдуулж, олон нийтийг хамарсан талцал, хуваагдлыг эрчимжүүлж байв (Б.Тэргэл, 2021). Эндээс харвал улс төрийн талцлын үзэгдэл нь сонгууль болон улс төрийн бусад нийгмийн томоохон үйл явдлын үед улам тод илэрдэг байна.

Олон улсын түвшний шинжилгээ ч мөн ижил үр дүнгүүдийг харуулж байна (Vasist PN, Chatterjee D, Krishnan S., 2023) нарын конфигурацийн анализаар 177 улс орны датан дээр хийсэн шинжилгээгээр улс төрийн талцал, туйлшралд (1) хуурамч мэдээллийг нөлөөллийг судалсан бүх загваруудад “хуурамч мэдээлэл” өндөр нөлөөтэй гарсан байна. Мөн (2) улс төрчдийн дайсагналт өнгө аястай мэдэгдэл, парламентын маргаан дахь hate speech нэмэгдэх (3) төрөөс интернэт орчинд тавих хяналт, цензур нэмэгдэх (internet censorship and social media monitoring) нь нийгмийн туйлшралыг улам гүнзгийрүүлдэг байна.

5. Иргэдийн үг хэлэх, үзэл бодлоо илэрхийлэх эрх чөлөөг хязгаарлахад хуурамч мэдээлэл нөлөөлөх нь: Хуурамч мэдээлэлтэй тэмцэх бодлого, арга хэмжээ нь ардчилсан нийгэмд зайлшгүй шаардлагатай ч, нөгөө талаас үзэл бодлоо илэрхийлэх эрх чөлөөг хязгаарлах эрсдэлийг үүсгэх талтай. Өөрөөр хэлбэл, энэ хоёр нь нэг зоосны хоёр тал гэж үзэж болно (Colomina, C.; Sánchez Margalef, H.; Youngs, R., 2021).

Дэлхий дахинд сүүлийн арав гаруй жилийн хугацаанд ардчиллын хамгийн ихээр доройтсон (alarming loss) шинж нь иргэдийн үзэл бодлоо илэрхийлэх эрх чөлөө байна. 2024 онд энэ доройтол түүхэнд байгаагүй түвшинд хүрч, дэлхийн 44 оронд доройтсон нь өмнөх жилийн 35 орноос эрс өссөн үзүүлэлт болжээ. Тэр дундаа хэвлэлийн эрх чөлөө, сэтгүүлчдийн аюулгүй байдал, иргэдийн улс төрийн асуудлаар нээлттэй хэлэлцүүлэх боломж, мөн соёл, академийн илэрхийллүүд бүгд буурсан (Marina Nord, David Altman, Fabio Angiolillo, Tiago Fernandes, Ana Good God, Staffan I. Lindberg., 2025).

Монгол Улс дэлхийн хэвлэлийн эрх чөлөөний индексээр 2025 онд 180 улсаас 102-р байранд, хэвлэлийн эрх чөлөө хүнд ангилалд багтаж байна (RSF, 2025). Дэд үзүүлэлтүүдээс сэтгүүлчдийн аюулгүй байдлын үзүүлэлт хамгийн доогуур байдаг. Үүнтэй уялдан V-Dem-ийн Үзэл бодлоо илэрхийлэх эрх чөлөөний индекс 2024 онд 0.69 оноотой гарсан нь 8 жилийн өмнөх 0.9 түвшнээс тогтвортой буурсаар ирсэн үзүүлэлт юм (V-Dem, 2016-2024). Энэ бууралтад нөлөөлсөн гол хүчин зүйлсийн нэг нь мөн л сэтгүүлчдийн аюулгүй байдал (harrasment of journalists) ба дарамтын түвшин юм.

Ярилцлагуудад дурдсанаар, Монгол Улсад үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх орон зай хумигдаж, иргэд болон сэтгүүлчид “худал мэдээлэл тараасан” гэх үндэслэлээр шалгагдах, шийтгэгдэх, дарамт шахалтад өртөх эрсдэл нэмэгдэх болжээ. Энэ нөхцөл байдал нь төрийн зарим албан тушаалтнуудад энэхүү орон зайг өөрт ашигтайгаар ашиглах боломжийг нээж өгч байна (Ярилцлага #5, 7, 9, 12).

Тодруулбал, сэтгүүлчидтэй холбоотой “худал мэдээлэл тараах” хэргүүдийн дийлэнх нь төрийн өндөр албан тушаалтнууд, УИХ-ын гишүүд, Засгийн газрын байгууллагуудын нэхэмжлэлээр үүссэн байдаг (ХЭҮК, 2024). Мөн Эрүүгийн хуулийн 13.14 дүгээр зүйл (“Худал мэдээлэл тараах”) хэт ерөнхий, тодорхой бус заалттай байгаа нь уг хуулийг шүүхийн процессоор шийтгэхээс гадна сэтгүүлчдийг залхаах, айдас үүсгэх хэрэгсэл болгон ашиглах бололцоог бий болгож байна (Ярилцлага #7).

Ингэснээр хуурамч мэдээлэлтэй тэмцэх нэрийн дор хэрэгжиж буй төрийн арга хэмжээнүүд нь эргээд хэвлэл мэдээллийн эрх чөлөө болон үг хэлэх, үзэл бодлоо илэрхийлэх эрхийг ноцтойгоор хязгаарлах сөрөг нөлөөг бий болгох боломжтой юм.

Дээр дурдсан нөлөөллүүдээс гадна, Монгол Улсад одоогоор нарийвчлан судлагдаагүй, дата мэдээлэл хомс байгаа хэдий ч судалгааны ярилцлагуудад давтагдан дурдагдсан хэд хэдэн боломжит нөлөөллүүд ажиглагдсан. Эдгээр нь одоогоор эмпирик түвшинд нягтлан батлагдаагүй боловч цаашдын судалгаанд анхаарал хандуулах шаардлагатай асуудлууд юм.

Төрийн бодлого, шийдвэр гаргалтад тусаж буй хуурамч мэдээллийн нөлөө: Ярилцлагад оролцсон экспертүүдийн үзэж буйгаар, нийгмийн сүлжээнд зориудаар түгээгдэж буй хуурамч мэдээлэл нь төрийн бодлого, шийдвэр гаргалтад бодит нөлөө үзүүлэх хэмжээнд хүрсэн. Тухайлбал, тодорхой асуудалтай холбоотой хуурамч мэдээлэл цахим орчинд сөрөг хандлага үүсгэж эсвэл хэт магтан сурталчилснаар, зарим төрийн шийдвэр батлагдах эсвэл цуцлагдахад хүртэл нөлөөлж байгаа жишээг оролцогчид дурдсан байна (Ярилцлага #1, 9, 15).

Ингэснээр төрийн бодлого олон нийтийн сэтгэл зүйд нийцэх “популист” чиглэл рүү хэлбийх, эсвэл манипуляцад орсон олон нийтийн үзэл бодлоор дамжуулан шийдвэр гаргах эрсдэл үүсэж буйг онцолж байна. Нөгөө талаас, өмнөх бүлэгт дурдсанчлан төрийн зарим байгууллага олон нийтийн хандлагыг тандах, эсвэл шийдвэрүүдэд урьдчилан дасгах зорилгоор зохион байгуулалттайгаар хуурамч мэдээлэл түгээх тохиолдлууд гардаг талаар ч оролцогчид тэмдэглэсэн (Ярилцлага #2, 3, 4).

Эдгээр тохиолдлуудыг баримтаар нотлоход хүндрэлтэй, цаашид хуурамч мэдээлэл төрийн бодлого төлөвлөлт, шүүхийн шийдвэр, хууль, зохицуулалтын өөрчлөлт, цахим мониторингийн практикт хэрхэн нөлөөлдөг талаарх нарийвчилсан кейс судалгаа хийх шаардлага өндөр байна.

Сонгуулийн үр дүнд нөлөөлөх: Улс төртэй холбоотой хуурамч мэдээллүүд сонгуулийг угтсан жилээс эхлэн эрчимжиж, сонгуулийн үр дүнд нөлөөлөх эцсийн зорилготой хэрэгждэг. Тэдгээр хуурамч мэдээллийн кампанит ажлууд нь ялангуяа мэдээлэлд хязгаарлагдмал, улс төрийн сонирхол, үнэлэмж нь тогтворгүй, эсвэл эсрэгээр хэт туйлширсэн үзэл баримтлалтай нийгмийн бүлгүүдэд хамгийн хүчтэй нөлөөлөл үзүүлдгийг олон улсад хийсэн судалгааны ажлууд харуулж байна. Цаашид сонгуулийн үеийн хуурамч мэдээллийн хэв маяг, нийгмийн бүлгийн улс төрийн шийдвэрт хэрхэн нөлөөлж буйг сонгуулийн нөхцөл байдалд нарийвчлан судалж хуурамч мэдээлэлтэй тэмцэх кампанит ажлуудад ашиглаж болох юм.

Мэдээллийн хямрал бий болох: Технологийн хурдацтай хөгжил, синтетик медиа (deepfake), хиймэл оюуны алгоритмууд нь хуурамч мэдээллийг үр ашигтайгаар үйлдвэрлэх, хэрэглэгч бүрийн сонирхол, үзэл бодлын хэв маягт тохируулан контент хүргэж буй нь (Cambridge Analytica жишээтэй ижил) мэдээллийн орчныг хэт сегментчилж, хуурамч мэдээллийг чиглүүлсэн зэвсэг болгон ашиглах боломж улам нэмэгдэж буйг харуулж буй юм. Синтетик медиад суурилсан, мэдээллийн боловсрол сайтай иргэн ч ялгах боломжгүй хэмжээнд хуурамч мэдээллийн хөгжүүлэлтүүд явагдах нь ирээдүйд

мэдээллийн хямрал (infocalypse) үүсгэх хамгийн ноцтой эрсдэлийг дагуулж байна (Ярилцлага #1, 3). Монгол Улсад ч үүнтэй төстэй нөхцөл байдал цар тахлын үед тодорхой хугацаанд үүссэн талаар Б.Тэргэл (2021) өгүүлэлдээ дурдсан байх бөгөөд ийм нөхцөл дахин бий болох, цаашид эрчимжих магадлал өндөр хэвээр байгааг судлаачид сануулж байна.

2.2 Хуурамч мэдээллийн хувь хүнд үзүүлж буй нөлөө

Худал аргумент, хуурамч мэдээлэл нь улс орны засаглалын эрүүл мэндийг дордуулахаас гадна иргэдийн өдөр тутмын амьдралд олон талаар ноцтой сөрөг нөлөөллүүдийг учруулж байдаг (Marta Pérez-Escolar, Darren Lilleker, Alejandro Tapia-Frade, 2023). Тайлангийн энэ хэсэг хуурамч мэдээллийн хувь хүний түвшинд учруулж буй нөлөөллүүд, мөн хувь хүний ямар шинж нь иргэдийг эмзэг өртөмтгий болгож буйг авч үзэв.

1. **Танин мэдэхүйн гажуудал: (Cognitive biases)** Судалгаанд оролцогчдын хамгийн ихээр онцолсон, хуурамч мэдээллийн үндсэн нөлөө бол алдаатай ойлголт ба итгэл үнэмшлийн гажуудал юм. Ялангуяа мэдээллийн хүртээмж бага, танин мэдэхүйн тодорхой хэв шинж бүхий бүлгийн иргэдэд хуурамч мэдээлэл “баримт” мэт ойлгогдох хандлага түгээмэл байна (Ярилцлага #6, 7, 8, 9, 13). Уг асуудал нь танин мэдэхүйн дараах гүнзгий нөлөөллүүдээр илэрч байна. Үүнд:

- **Хуурамч мэдээллийн залруулга үр дүнд хүрэхгүй байх (Resistance to correction):** Худал мэдээллийн залруулга хэзээ ч худал мэдээллийн нөлөөг гүйцдэггүй буюу яаж ч залруулж, үнэн мэдээллийг түгээсэн хуурамч мэдээллийн хүрсэн цар хүрээнд хүрч чаддаггүйг оролцогчид ярилцлагадаа дурдаж байв (Ярилцлага #7, 13). Танин мэдэхүйн сэтгэл зүйч Eryn J Newman (2022)-ий тайлбарласнаар хуурамч мэдээлэл зарим хүний хувьд итгэл үнэмшил болж тогтох (To form false beliefs), буруу мэдээллийг үнэн мэт эргэн сэргээн санах (remember false claims as true), хуурамч мэдээллийг залруулгыг хүлээж авсан ч тархины санах ой болон нэгэнт суусан итгэл үнэмшлийг шинэчлэхэд хүндрэлтэй байх (struggle with memory updating and belief revision) нөлөөллүүд илэрдэг бөгөөд эдгээр нөлөөллийн хүч нь хувь хүний танин мэдэхүйн хэв шинжээс ихээхэн хамааралтайг тайлбарласан байна. Өөрөөр хэлбэл, хэдий мэдээллийг залруулсан ч гэсэн хүний санах ойд үлдсэн мэдээллүүд нь дараа дараагийн бодол, шийдвэр гаргалтад нөлөөлсөөр байдаг бөгөөд үүнийг хуурамч мэдээллийн үргэлжилсэн нөлөө (continued effect) гэж үздэг. Тухайлбал, 2021 болон 2024 оны сонгуульд санал өгч оролцоогүй залуучуудын зан үйлд өмнө нь сонсож байсан “саналаа өгөөд нэмэргүй, санал хураалтын үр дүнг өөрчилдөг” гэх итгэл үнэмшил хуурамч мэдээллийн нөлөөгөөр бий болж, сонгуульд оролцохоос татгалзах шийдвэрт хүргэж буйг тэмдэглэсэн байна (Н.Ганчимэг, 2024).
- **Итгэл үнэмшлээ батлахын тулд хуурамч мэдээллийг сонгож ашиглах (Motivated reasoning):** Цаашлаад, хүн шийдвэр гаргахдаа урьдчилан бодсон итгэл үнэмшлээ хамгаалахын тулд мэдээллийг сонгон авч ашиглах, энэ нь заримдаа бодит үнэнтэй зөрчилдсөн ч өөрийн итгэлээ батлахын тулд үнэн мэдээлэл, залруулгыг үл ойшоох эсвэл буруу тайлбарлахад хүргэх буюу motivated reasoning бий болж байдаг (GaLeotti, 2020).
- **Мэдээллийн бөмбөлөгт орох (Filter bubble/Echo-chamber):** Өөр нэгэн нөлөөг судалгаанд оролцсон талууд мэдээллийн filter bubble үзэгдэл бусад улс орнуудтай ижил Монголд улам эрчимжиж байгаа гэж үзэж байв (Ярилцлага #8, 9). Өмнө үзэж байсан мэдээлэлтэй ижил төстэй мэдээллийг харуулдаг сошиал медиан алгоритм (engagement driven approach) нь хувь хүнийг зөвхөн өөрийн итгэл үнэмшилтэй нийцсэн мэдээлэл, контентыг харах, ижил үзэл бодолтой хүмүүс, бүлгийг санал болгох буюу зөвхөн өөрийн үзэл бодлыг баталгаажуулах мэдээлэлтэй тулж, ижил байр суурьтай хүмүүстэй л харилцах нөхцөл бүрдэхийг filter bubble буюу мэдээллийн бөмбөлөгт орох үзэгдэл гэж үздэг (Magma, 2025).

Энэ үзэгдэл өргөжин echo chamber/цуурайн танхим буюу нэг төрлийн үзэл санаа дотроо эргэлдэх мэдээллийн хязгаарлагдмал орон зай болж хувирдаг. Ийм мэдээллийн бөмбөлөгт орсон хүн эсрэг байр суурьтай хүмүүстэй зөрчилдөх, үзэл бодлоо хамгаалж туйлшрах, өөрийн итгэл үнэмшилтэй зөрсөн мэдээллийг үл хүлээн зөвшөөрөх, харин түүнийг дэмжиж байвал хуурамч мэдээлэл байсан ч “үнэний ортой” гэж үзэх хандлагатай болдог (GaLeotti, 2020). Ийнхүү хувь хүний түвшинд эхэлсэн энэ итгэл үнэмшлийн туйлшрал, танин мэдэхүйн гажуудал нь олон нийтийн түвшинд нийгмийн хуваагдал, талцлыг өдөөх үндэс суурь болдог байна.

2. **Мэдээллийн хэт ачааллаас үүдэлтэй итгэл сулрах (Information fatigue):** Хувь хүний түвшинд илэрч буй өөр нэг нөлөөлөл нь тогтмол давтамжтай явагддаг улс төрийн хуурамч мэдээллүүд нь тухайн мэдээлэлд итгүүлэх гэхээсээ илүүтэй ямар ч мэдээлэл, эх сурвалжид итгэх иргэдийн итгэлийг сулруулж буйг судалгаанд оролцогчид онцолсон (Ярилцлага #2, 5, 6, 10, 15). Энэ үзэгдлийг Edson C. Tandoc & Hye Kyung Kim (2022) нар “analysis paralysis” буюу мэдээллийн хэт их ачааллаас шалтгаалсан шүүн тунгаах чадварын доройтол үүсэх үзэгдэл хэмээн тайлбарласан байдаг. Ийм нөхцөлд хүмүүс мэдээллийг идэвхгүйгээр хүлээж авах, анхаарлаа хандуулахгүй байх буюу information avoidance-ын зан үйл үзүүлэх хандлагатай болдог. COVID-19-ийн үеийн судалгаанууд (Qing Huang, Sihan Lei, 2022) ч үүнийг баталж, мэдээллийн илүүдэл нь аливаа мэдээлэлд итгэх итгэлийг сулруулж, иргэд ойлгоход илүү хялбар мэдээлэлд итгэх буюу эргээд хуурамч мэдээлэлд өртөх, түгээх магадлалыг нэмэгдүүлэх нөлөөтэй байсныг дурдсан байна.

3. **Иргэдийн сэтгэл зүйн төлөв байдалд үзүүлэх нөлөөлөл (Emotional and Psychological Effects):** Хуурамч мэдээллийн өөр нэг хүчтэй нөлөөлөл нь Монголчуудын дунд стресс, бухимдал, аюул, түгшүүрийн мэдрэмжийг нэмэгдүүлж, иргэдийн сэтгэл зүйн төлөв байдлыг тогтворгүй болгож буй явдал байна (Ярилцлага #2,10,11). Энэ нь нэг талаас төрийн шийдвэр, бодлогод иргэд хяналт тавих байдлыг сулруулж, нөгөө талаас олон нийтийн сэтгэл зүй тогтворгүй нөхцөлд шийдвэр гаргалтад нөлөөлөх нөхцөл болдог байна (Ярилцлага #10, 11).

Энэ чиглэлд хийгдсэн судалгааны ажлууд ч ижил үр дүнг харуулж байв. Тухайлбал, OptimalNMax (2024)-ийн судалгаагаар Монголчуудын дунд айдас, түгшүүр төрүүлсэн хэв маягаар бичигдсэн хуурамч мэдээлэл илүү түгээмэл хуваалцагддаг бол сэтгэл гутралтай, бусдыг буруутгах хандлагатай иргэд хуурамч мэдээллийг түгээх магадлал өндөр байжээ. Бусад улс орнуудын судалгаанууд ч мөн адил хуурамч мэдээлэл иргэдийн стресс, депресс, айдас түгшүүр, нойргүйдлийг нэмэгдүүлж, сэтгэлзүйн төлөв байдалд сөргөөр нөлөөлдөг болохыг (Alfred Nela, Etion Parruca, 2022; Claudia, 2022), сэтгэцийн эрүүл мэндэд нөлөөтэйг (Mahek Vhora, 2023)-г танилцуулсан байна.

Мөн амьдралын чанар (life meaningfulness, enjoyment зэрэг үзүүлэлтийг багтаасан) ба хуурамч мэдээлэл хоорондын хамаарлыг судалсан Baeta Gavurova et al., (2024) судалгааны үр дүн хуурамч мэдээллийг тархаах зан үйл болон амьдралын чанар доогуур байх хоёр үзүүлэлт хооронд корреляцийн хамааралтайг баталсан байна. Монголд ч мөн ижил хандлага ажиглагдаж, БНОУХ (2024)-ийн судалгаагаар залуучуудын 74% нь боломж олдовол урт хугацаагаар гадаад улс уруу явахыг илүүд үзнэ гэж хариулсан нь залуучуудын улс эх орныхоо ирээдүйдээ итгэх итгэл буурч буйн нэг илрэл гэж оролцогчид (Ярилцлага #6, 10, 15) дүгнэж байв.

Хуурамч мэдээлэлд эмзэг, өртөмтгий байдал

Өмнөх хэсэгт дурдсанчлан хуурамч мэдээлэл нь хүний танин мэдэхүй, сэтгэл зүйн төлөв байдалд тодорхой нөлөөллийг үүсгэхээс гадна хүлээн авагчийн өөрийнх нь сэтгэл зүй, танин мэдэхүйн хэв шинж нь хувь хүний эмзэг байдалтай шууд холбоотойг сэтгэл зүйн салбарынхан (OptimalNMax, 2024;

Eryn J Newman, 2022), **нийгэм, эдийн засаг, хүн ам зүйн шинж нь холбоотойг** социологийн судлаачид (MMCG, 2021) тэмдэглэсэн байна.

2024 онд OptimalNMax сэтгэлзүйчдийн багийн гүйцэтгэсэн судалгаанд улс төртэй холбоотой хуурамч мэдээлэлд итгэн, цааш түгээх зан үйлтэй байгаа хүмүүсийн дунд нийтлэг **хохирогч сэтгэл зүйн төлөв шинж буюу болон гаднын нөлөөг дөвийлгөх хандлага** (аливаа өөрт нь тохиолдож буй асуудлын шалтгааныг тайлбарлахдаа гаднын нөлөөтэй холбон тайлбарлах нэг төрлийн бодлын алдаа) хамгийн түгээмэл байгааг онцолжээ. Өөрөөр хэлбэл, би зовж байна, үүнд бусад буруутай гэсэн хандлагатай хүмүүсийн хувьд сэтгэл хөдлөлд тулгуурласан хуурамч мэдээлэл илүү хүрдэг байна. Нэмэлтээр шүүмжлэлт сэтгэлгээ сул, бодох хэв маягийн гажуудалтай, бусдыг сэрдэж хардах, бусадтай дайсагнах хандлагатай, яаран дүгнэлт гаргадаг гэх мэт шинжүүд нь хуурамч мэдээллийг түгээж буй хүмүүсээс нийтлэг илэрчээ.

Харин нийгэм, эдийн засаг, хүн ам зүйн талаас нь авч үзвэл **насны хувьд өсвөр нас, эрт үеийн залуучууд болон ахмад настнууд, хөдөлмөр эрхлэлтийн хувьд ажилгүй, малчин, хөдөө аж ахуй (ХАА)-н салбарт ажилладаг иргэд, амьдрах орчны хувьд хөдөө орон нутагт амьдардаг олон нийтийн сүлжээ хэрэглэгчид** хуурамч мэдээллийг тараах, түгээх төлөв Улаанбаатар хотын иргэдтэй харьцуулахад илүү өндөр гарч, статистик ач холбогдолтой дүгнэгджээ (OptimalNMax, 2024).

Эдгээр шинжүүдийг нэгтгэн ямар нийгэм, эдийн засаг, хүн ам зүй, сэтгэл зүйн хэв шинжтэй иргэд Монгол Улсад хуурамч мэдээлэлд хамгийн эмзэг өртөмтгий байгааг дараах хүснэгтэд нэгтгэн харууллаа:

Хүснэгт 3. Хуурамч мэдээлэлд өртөх эмзэг байдлыг нэмэгдүүлэгч болон бууруулагч хүчин зүйлс

Бүлэг	Эмзэг байдлыг бий болгож буй шинжүүд	Эмзэг байдлыг нэмэгдүүлж буй бусад шинжүүд
Ахмад настнууд (55-69 нас):	- Жинхэнэ болон хуурамч зураг, бичлэг, мультимедиа контентийг ялгаж таних чадвар сул - Цахим орчинд хуурамч мэдээлэл байрлах, хуурамч мэдээллүүд олон хувилбараар бүтээгдэж буй, бүтээх боломжтой талаар мэдээлэл бага буюу цахим ур чадвар сул - Нийгмийн харилцаанд орох, сүүлийн үеийн мэдээлэлд анхаарал хандуулдаг	Хөдөлмөр эрхлэлт: Ажилгүй, Малчин, ХАА эрхэлдэг Боловсрол: Боловсролын түвшин бага байх Байршил: Хөдөө орон нутагт амьдардаг Орлого: Сарын орлого нь 1 сая болон түүнээс доош Сэтгэл зүйн хувьд: Хохирогч сэтгэлзүйтэй буюу бусдыг буруутгах хандлагатай Цахим ур чадвар: Сул байх
Өсвөр үе, эрт үеийн залуучууд (18-25 нас):	- Цар тахалтай холбоотойгоор хяналтгүй хэрэглээ огцом нэмэгдсэн хүүхэд, залуучууд - Цахимд зарцуулах цаг их хэдий ч мэдээллийг шүүн тунгаах чадвар сул - Мэдээлэл рүү орж дэлгэрэнгүй уншдаггүй зөвхөн гарчиг уншдаг - Цаг зав, чөлөөт цаг ихтэй - Мэдээллийн хэт нийлүүлэлт буюу хэт их мэдээлэл дунд байдаг ч дүн шинжилгээ хийх чадвар сул - Бусдыг даган дуурайх, уйдаагаа гаргах сэдэл давамгайлдаг - Тухайн сэдэв, асуудлаар ойлголт мэдээлэл бага	

Эх сурвалж: (OptimalNMax, 2024), (MMCG, 2021)

Дээрх шинжүүдээс нийгэм, хүн ам зүйн зарим шинжүүдэд нь үндэслэн хуурамч мэдээлэлд хамгийн эмзэг, өртөмтгий бүлгийн ерөнхий хүрээг тооцоолох оролдлого хийв. 2020 оны хүн ам, орон сууцны тооллогын өгөгдлөөс (1) нас, (2) хөдөлмөр эрхлэлт, (3) боловсролын түвшин, (4) оршин суугаа байршил зэрэг хүн ам зүйн үзүүлэлтүүдийн огтлолцолыг хангасан бүлгийг улсын хэмжээнд тооцоход, нийт хүн амын ойролцоогоор 7.3% нь хуурамч мэдээлэлд хамгийн эмзэг, өртөмтгий бүлэгт хамрагдаж байна.

Хүснэгт 4.Хуурамч мэдээлэлд хамгийн эмзэг өртөмтгий бүлгийн тоо

(1) Нас	N	(2) Хөдөлмөр эрхлэлт	N	(3)Боловсрол	N	(4) Амьдарч буй байршил	Зорилтот бүлэг
18-25 насны	39,016	Ажилгүй	24,562	Бүрэн дунд ба түүнээс доош	19,845	Хөдөө орон нутагт	10,901
18-25 насны		Ажилгүй		Бүрэн дунд ба түүнээс доош		Улаанбаатар хотод	8,943
18-25 насны		Малчин	2228	Бүрэн дунд ба түүнээс доош	1896	Хөдөө орон нутагт	1830
18-25 насны		Малчин		Бүрэн дунд ба түүнээс доош		Улаанбаатар хотод	23
65-69 насны	5,510	Ажилгүй/Тэтгэвэрт	4551	Бүрэн дунд ба түүнээс доош	2589	Хөдөө орон нутагт	1554
65-69 насны		Ажилгүй/Тэтгэвэрт		Бүрэн бус дундаас доош		Улаанбаатар хотод	989
Нийт							24,240

*2020 оны хүн ам, орон сууцны тооллогын датанд үндэслэн тооцов.

Уг тооцооллыг нарийвчлах дараагийн шатны шалгуур нь (1) цахим ур чадвар, (2) мэдээллийн боловсрол болон (3) иргэдийн сэтгэл зүйн хэв шинж зэрэг үзүүлэлтүүд байна. Эдгээр үзүүлэлтийг хүн амын түвшинд тодорхойлсон нэлэнхүй судалгаа байхгүй тул уг үзүүлэлтийг скрининг асуулт байдлаар тухайлсан судалгаануудад оруулж, хуурамч мэдээлэлд илүү эмзэг өртөмтгий бүлгийг нарийвчлан тодорхойлох боломжтой.

3. Авч хэрэгжүүлж буй арга хэмжээнүүд

БНОУХ-ээс гүйцэтгэдэг олон нийтийн санал асуулгад 2024 онд хамрагдсан оролцогчдын 85% нь худал мэдээлэл Монгол Улсын хувьд тулгамдсан асуудал болсон үзсэн ба энэ хувь 2022 оныхоос бага зэрэг буурсан байна. Мөн V-Dem-ийн индикаторуудаар ч 2022 оноос хойш Монгол дахь худал мэдээллийн түвшин бага зэрэг буурсан байгаа нь COVID-19 цар тахалтай холбоотой байж болзошгүй (V-Dem, 2025). Харин ярилцлагад оролцогчид энэ талаар ялгаатай байр сууриуд илэрхийлж байв. Тухайлбал, зарим оролцогчид (Ярилцлага #5, 6, 11) сүүлийн жилүүдэд хуурамч мэдээллийн хэмжээ мэдэгдэхүйц нэмэгдсэн гэсэн бол зарим (Ярилцлага #2, 7, 14) нь хуурамч мэдээлэл үргэлж байсан ба сүүлийн үеийн технологийн хөгжлөөс шалтгаалж зөвхөн хурд болон хамрах хүрээ нь нэмэгдсэн гэж өгүүлжээ (Хоёрдугаар бүлгээс дэлгэрэнгүйг үзнэ үү).


Олон нийт Монгол дахь хуурамч мэдээлэлтэй холбоотой асуудлуудад санаа зовниж, мэргэжилтнүүд хуурамч мэдээлэл улам нэмэгдэж, хор хөнөөлтэй болж буйд анхаарал хандуулж буй боловч энэ асуудлаарх бодлого, арга хэмжээний цар хүрээ хязгаарлагдмал хэвээр байна. Иймээс бид төрөөс болон бусад талуудын хуурамч мэдээлэлтэй шууд болон шууд бус байдлаар тэмцэж буй хүчин чармайлт, үйл ажиллагаануудыг энэхүү бүлэгт зураглахыг зорилоо.

3.1 Хуурамч мэдээлэлтэй тэмцэх эрх зүй, бодлогын арга хэмжээнүүд

Хуурамч мэдээлэлтэй тэмцэхэд цогц хандлага, олон талт оролцогчдын хамтын ажиллагаанд тулгуурласан эрх зүйн болон бодлогын арга хэрэгсэл шаардлагатай. Гэвч ихэнх оронд Засгийн газрын хариу арга хэмжээ хязгаарлагдмал, ихэвчлэн түр зуурын шинжтэй байна (Matasick et. al., 2020). Монголд ч үүнтэй ижил нөхцөл байдал байгаа ба хуурамч мэдээлэлтэй тэмцэх Засгийн газрын бодлого, зохицуулалт хомс, системтэй бус, нарийн тодорхой бус байна. Зарим ярилцлагад оролцогч (Ярилцлага #13) хуурамч мэдээлэл рүү шууд чиглэсэн бодлого, зохицуулалт байхгүй гэсэн бол зарим оролцогчид цогц бодлого, хүрээ байхгүй ч Засгийн газрын тодорхой санаачлагууд байдгийг мэдээлж байв. Үүнд дижитал ур чадварын түвшнийг дээшлүүлэх (Ярилцлага #2), хуурамч мэдээлэлд эрүүгийн хариуцлага хүлээлгэх, торгох (Ярилцлага #6, 7, 11), хууль бус, зөрчил бүхий контентыг хянан зохицуулах арга хэмжээ (Ярилцлага #10, 12) зэрэг орно. Гэвч эдгээр арга хэмжээнүүд хоорондоо уялдаа холбоогүй, хэрэгжилт нь үр ашиггүй байна.

Нэгдсэн Үндэстний Байгууллага (НҮБ), Эдийн засгийн хамтын ажиллагааны хөгжлийн байгууллага (ЭЗХАХБ), Европын комисс зэрэг олон улсын байгууллагууд хуурамч мэдээлэлтэй тэмцэх арга хэмжээг цогцоор нь авч үзэхийг зөвлөдөг. Манай судалгааны баг НҮБ-ын Ерөнхий нарийн бичгийн даргын 2022 оны тайлан, Хуурамч мэдээллийг сөрөх нь (Countering Disinformation) портал, ЭЗХАХБ-ийн сүүлийн үеийн тайлан, бодлогын хураангуй, олон нийттэй харилцах сайн туршлагын зарчмууд, Европын Комиссын 2018 оны Цахим хуурамч мэдээллийг бууруулах арга хэмжээний талаарх баримт зэргийг гол эх сурвалжаар ашиглан тэдгээрийн зөвлөсөн хуурамч мэдээлэлтэй үр дүнтэй тэмцэх үйл ажиллагааны хүрээг дараах байдлаар зураглав.


Дүрс 16. Хуурамч мэдээлэлтэй тэмцэх хүрээнд санал болгож буй арга хэмжээний хүрээ



Эх сурвалж: Судалгааны баг

Энэхүү хүрээ нь хуурамч мэдээлэлтэй тэмцэх арга хэмжээний ерөнхий хүрээ учир зарим арга хэмжээнүүд нь Монголын нөхцөлд бүрэн тохирохгүй, хэрэгжих боломж хязгаарлагдмал. Жишээлбэл, Meta, X, Youtube, Tik Tok зэрэг Монголчуудын ашигладаг дийлэнх дижитал платформууд нь олон улсын томоохон технологийн компаниудын эзэмшил ба одоогоор Монголд эдгээр платформуудад хариуцлага хүлээлгэх зохицуулалт байхгүй байна. Харин Монгол Улсын хуурамч мэдээллийн эсрэг хариу арга хэмжээнүүд нь цогц, олон салбарыг хамарсан гэхээс илүү системгүй, хэсэгчилсэн, цар хүрээ багатай, тодорхой чиглэлгүй байна.

Дүрс 17. Монгол дахь хуурамч мэдээлэлтэй тэмцэж буй оролдлогууд



Хуурамч мэдээллэл тараахад эрүүгийн хариуцлага хүлээлгэх зохицуулалт:

Хуурамч мэдээллийг таслан зогсоох зорилготой хамгийн их маргаан дагуулсан эрх зүйн арга хэрэгслийн нэг нь хуурамч мэдээллийг эрүүгийн хэрэгт тооцох явдал юм. НҮБ-ын Ерөнхий Ассамблейн А/RES/76/227 (2021) тогтоол, Хүний эрхийн зөвлөлийн А/HRC/RES/49/21 (2022), А/HRC/RES/55/10 (2024) тогтоолууд хуурамч мэдээллийг эрүүгийн хэрэгт тооцох өргөн хүрээтэй, тодорхой бус хуулийн зохицуулалтууд нь хүний эрхийг хязгаарлах, цензурыг зөвтгөхөд ашиглагдаж болзошгүй болохыг онцолсон байдаг.

УИХ-аас 2020 оны 1 сарын 10-ны өдөр Эрүүгийн хуулийн нэмэлт, өөрчлөлтийг баталж, 13.14 дүгээр зүйлийг шинээр оруулсан. Уг зүйлээр хүний нэр төр, алдар хүнд, хуулийн этгээдийн ажил хэргийн нэр хүндэд халдсан "илт худал мэдээлэл" тараахыг эрүүгийн гэмт хэрэгт тооцох болсон.

Үүнээс өмнө, 2017 оны Эрүүгийн хуулийн нэмэлт, өөрчлөлтөөр сонгуулийн үеийн хуурамч мэдээллийг эрүүгийн хэрэгт тооцсон байдаг. Аль аль нь хувь хүн болон хуулийн этгээдийн (сонгуулийн зохицуулалтын хувьд нам болон нэр дэвшигчийн) нэр төр, алдар хүндийг хуурамч мэдээллээс хамгаалах зорилготой. Ерөнхийд нь авч үзвэл, энэ хоёр заалт нь Монгол Улс 2015 онд НҮБ-ын зөвлөмжийн дагуу Эрүүгийн хуулиас хассан гүтгэх, доромжлох үйлдлыг гэмт хэрэгт тооцох заалттай ижил төстэй зохицуулалт болсон (ННФ, 2021).

Сүүлийн гурван жилийн статистик мэдээллээс харвал цагдаагийн байгууллага жилд дунджаар 543 хуурамч мэдээлэлтэй холбоотой гомдол хүлээн авсан. Эдгээр гомдлын 72 (13.3%)-т нь мөрдөн шалгах ажиллагаа нээсэн бол 421 (77.5%) гомдлыг хэрэгсэхгүй болгожээ. Нөгөөтээгүүр, цагдаагийн байгууллага жил бүр Эрүүгийн хуулийн 13.14 дүгээр зүйлийн дагуу дунджаар **266** эрүүгийн хэргийг шалгаж, жилд дунджаар **33** яллах дүгнэлт үйлддэг байна. Эрүүгийн хэргийн шүүхийн нээлттэй мэдээллийн сангийн тоо баримтаас харахад 2020 оноос хойш нийт **133** хэрэг 13.14 дүгээр зүйлээр шийтгэгдсэн байна.

Дүрс 18. Цагдаагийн байгууллагад ирсэн болон шийдвэрлэсэн гомдлын тоо, мөн "хуурамч мэдээлэл"-ийн хэргүүдийг мөрдөн шалгасан статистик



Хэдийгээр 13.14 дүгээр зүйл хүчин төгөлдөр болоод таван жил болсон ч хэрэгжилттэй холбоотой асуудал, сорилтууд байсаар байна. Эрх зүйн үүднээс авч үзвэл, 13.14 дүгээр зүйл заалтыг "хэт ерөнхий хуульчилсан", хуучин гүтгэх гэмт хэргийн агуулгыг багтаасан, мөн хуурамч мэдээллийн "объектив

шинж"-д хэт төвлөрч, хорхирол учруулах санаа зорилго буюу субъектив талыг бүдгэрүүлсэн хэмээн шүүмжилдэг. Энэ нь өөрөөр хэлбэл хэн нэгнийг зориуд гүтгэх санаагүй байсан ч худал мэдээлэл тараасан тохиолдолд эрүүгийн хариуцлага хүлээх боломжтой гэсэн үг юм. Ийм өргөн хэрэглээтэй, тодорхой бус эрүүгийн тодорхойлолт нь сэтгүүлчдэд хэрэг нээх, удаан хугацаанд мөрдөн шалгах, нууц эх сурвалжаа ил болгох зэргээр дарамтад оруулах эрсдлийг бий болгодог. Энэ нь сэтгүүл зүйн ёс зүйтэй шууд зөрчилдөж, эрэн сурвалжлах сэтгүүл зүйд саад учруулна.

Үйл ажиллагааны өнцгөөс харж үзвэл 13.14 дүгээр зүйлийг хэрэгжүүлэхэд голлон оролцдог шүүх, прокурор, цагдаагийн байгууллага, өмгөөлөгч зэрэг хууль зүйн салбарын талууд хүний эрх, үзэл бодлоо илэрхийлэх эрх, хуурамч мэдээллийн талаарх мэдлэг, ойлголтоо нэмэгдүүлэх шаардлагатай байна. Ингэснээр хуурамч мэдээлэлтэй холбоотой эрүүгийн хэргийн мөрдөн шалгах ажиллагаа, шүүх хуралдаан үзэл бодлоо илэрхийлэх эрх чөлөөг зөрчихгүй байх нөхцөлийг бүрдүүлнэ.

Ийм шүүмжлэл, болгоомжлол байгаа хэдий ч ярилцлагад оролцогчид ерөнхийдөө Эрүүгийн хуулийн 13.14 дүгээр зүйл байх хэрэгтэй гэж үзэж, үг хэлэх болон хэвлэлийн эрх чөлөөнд үзүүлэх сөрөг нөлөөнөөс нь сэргийлэх байдлаар нэмэлт, өөрчлөлт оруулах ёстойг онцолж байв. Тэдний үзэж буйгаар 13.14 дүгээр зүйл нь энгийн иргэдийг цахим орчинд гүтгүүлэх, хор хөнөөлтэй контент болон бусад зөрчлөөс хамгаалдаг байна. Гэсэн ч тодорхойлолт, хүрээг нарийвчилж, үг хэлэх болон хэвлэлийн эрх чөлөөнд үзүүлэх нөлөөг бууруулах ёстой гэдгийг дурдсан. Нөгөө талаас, хуульчид гүтгэлгийн шинжтэй хэргүүдийг Иргэний хуулиар шийдвэрлэж, Эрүүгийн хуулиас 13.14 дүгээр зүйлийг хасах хэрэгтэй гэж үздэг (ННФ, 2021).

Саяхан буюу 2025 оны 11 дүгээр сарын 25-ны өдөр Монгол Улсын Үндсэн хуулийн цэц 13.14 дүгээр зүйл Үндсэн хууль зөрчсөн гэж дүгнэжээ. Уг шийдвэрийн дэлгэрэнгүй үндэслэл одоогоор нийтлэгдээгүй байгаа ба Цэцийн дүгнэлт, шийдвэрийг Улсын Их Хурал хэлэлцэхээр хүлээгдэж байн

Ерөнхийд нь авч үзвэл "худал мэдээллийг тараах" (13.14 дүгээр зүйл)-ыг эрүүгийн хэрэгт тооцсон нь үзэл бодлоо илэрхийлэх эрх чөлөөнд томоохон саад учруулж, Монгол дахь хэвлэлийн эрх чөлөөг сүүлийн жилүүдэд хамгийн доод түвшинд хүргэхэд нөлөөлсөн. Мэргэжилтнүүдийн зүгээс Эрүүгийн хуулиас 13.14 дүгээр зүйлийг хасах, эсвэл наад зах нь ийм төрлийн зохицуулалтыг үзэл бодлоо илэрхийлэх эрх чөлөөнд нөлөөлөхгүй байдлаар өөрчлөн найруулах шаардлагатайг зөвлөж байна. Мөн тэдний үзэж буйгаар тодорхой, ойлгомжтой тодорхойлолт боловсруулж, хүнд суртал бүхий хэрэг шийдвэрлэх хугацааг багасгаж, эх сурвалжийн нууцлалыг хамгаалах зайлшгүй шаардлагатай.

Хуурамч мэдээллийг зөрчлийн хуулиар шийтгэх зохицуулалт:

Эрүүгийн хуульд нэмэлт, өөрчлөлт орохоос өмнө гүтгэх болон худал мэдээлэл тараах үйлдлийг 2017 оноос 2020 он хүртэл Зөрчлийн хуулийн 6.21 дүгээр зүйлээр зохицуулж байсан. 2020 онд уг зүйл хүчингүй болсноор, Эрүүгийн хуулийн өөрчлөлтөөр хуурамч мэдээллийг эрүүжүүлэх зохицуулалт (13.14) орж ирсэн юм. Зөрчлийн хуульд гүтгэлгийн заалт шинээр орсноос хойших эхний саруудад 100 гаруй сэтгүүлч энэ зүйлээр шийтгэгдсэн бөгөөд эдгээрийн ихэнх нь улс төрчдийн гаргасан өргөдөл, гомдлын үндсэн дээр үүссэн хэрэг байжээ².

Хэдийгээр гүтгэлгийн зохицуулалт 2020 онд хүчингүй болсон ч COVID-19 цар тахлын эхэн үед Гамшгаас хамгаалах тухай хууль, Коронавируст халдварын цар тахлаас урьдчилан сэргийлэх, тэмцэх, нийгэм, эдийн засагт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах тухай хууль, мөн COVID-19-тэй холбоотой хуурамч мэдээллээс урьдчилан сэргийлэх журам зэрэг онцгой нөхцөлд үйлчлэх зохицуулалтуудад COVID-19 болон гамшгийн нөхцөл байдалтай холбоотой худал мэдээлэл тараахад торгууль

² <https://www.transparency.org/en/press/mongolia-criminalisation-of-defamation-is-another-disturbing-attack-on-media-freedom-threatening-anti-corruption-efforts>

оногдуулахаар заасан. Үүний дагуу Зөрчлийн хуулийн 5.13 дугаар зүйлд нэмэлт, өөрчлөлт оруулж, иргэдийг төөрөгдүүлэх зорилгоор байгалийн гамшиг, халдварт өвчний дэгдэлт зэрэгтэй холбоотой худал мэдээллийг олон нийтэд тараахыг хориглосон. Энэхүү заалтаар зөвхөн 2020 онд л гэхэд 1,790 зөрчил бүртгэгдэж, 1,480 хувь хүн, хуулийн этгээдэд хариуцлага тооцсон байна (ННФ, 2021).

Худал мэдээлэл тараахыг шийтгэхээс гадна онцгой байдлын үеийн зохицуулалтуудаар төрийн байгууллагуудад хэвлэл мэдээлэл, олон нийтийн сүлжээнд хуурамч мэдээллийн тархалтыг зогсоох арга хэмжээ авах эрхийг олгосон. Тухайлбал, Гамшгаас хамгаалах тухай хуулийн 10.4.13-р заалт ийм боломжийг олгодог боловч эдгээр арга хэмжээний хүрээ болон зарчмыг тодорхой болгож чадаагүй байна. Үүний зэрэгцээ, COVID-19-ийн тухай хуулийн 9.13-р зүйлээр COVID-19-тэй холбоотой цахим орчин дахь хуурамч мэдээллийг таслан зогсоох зорилгоор Цагдаагийн Ерөнхий Газарт “цахим орчныг зохицуулах” эрх олгосон.

Ерөнхийд нь авч үзвэл, Хэвлэлийн эрх чөлөөний 2020 оны тайланд цар тахлын үед хуурамч мэдээллийг таслан зогсоох зорилгоор баталсан онцгой байдлын үеийн нэмэлт өөрчлөлтүүдийг иргэдийн эсрэг буруугаар ашигласан гэж тэмдэглэсэн байдаг. Мөн “худал мэдээлэл” гэх ойлголтын нарийн, тодорхой тодорхойлолтгүй байдал нь хуулийг дур зоргоороо мөрдүүлэх нөхцлийг бүрдүүлдэг гэж дурджээ (GIC, 2021).

Бодит бус сүлжээний хэрэгслүүдийг устгах зохицуулалт:

Нэгдүгээр бүлэгт дурдсанчлан хамгийн хортой, өргөн хүрээнд түгдэг хуурамч мэдээллийг тролл сүлжээ болон тодорхой мэдээлэл эсвэл ард нь хэн байгаа нь мэдэгдэхгүй хуурамч аккаунт, групп, пэйж зэрэг бодит бус сүлжээний хэрэгслүүдийг ашиглан зохион байгуулалттай түгээдэг байна. Тиймээс өөрийн хэн болохоо нуун далдалсан аккаунт, пэйжүүдийг платформуудаас илрүүлж, устгах нь илт үр нөлөөтэй (Bateman and Jackson, 2024). Гэвч Bateman болон Jackson (2024)-ийн тэмдэглэснээр бодит бус сүлжээний хэрэгслүүдийг илрүүлэх, устгах арга хэмжээний үр нөлөөг үнэлэх нь бэрхшээлтэй асуудал.

Мэдээллийн манипуляц явуулах, хуурамч мэдээллийг түгээх, дэлгэрүүлэхэд оролцдог зарим талуудын үйл ажиллагааг хязгаарлаж, зогсоосноор тэдгээр талуудад илүү зардал бий болгож, хүндрэл үүсгэж болох ч хуурамч мэдээлэлтэй үр дүнтэй тэмцэх стратеги болж чадахгүй байж болзошгүй.

Энэ тал дээр Монголд Харилцаа холбооны зохицуулах хороо (ХХЗХ) дижитал контентыг хянан зохицуулах үйл ажиллагааг явуулдаг. ХХЗХ нь дижитал орчин дахь контентууд Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал, Сонгуулийн тухай хууль, Хүүхэд хамгааллын тухай хууль, Эрүүгийн хууль, Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хууль, оюуны өмчийн эрхийн хамгааллын тухай хууль зэрэг олон төрлийн эрх зүйн зохицуулалттай нийцүүлэх ажлыг гүйцэтгэдэг.

Дижитал контентыг зохицуулах үүргийнхээ хүрээнд бодит бус сүлжээний хэрэгслүүд, түүн дотро зөрчилтэй контент болон хуурамч хаяг, зөрчилтэй цахим хуудас зэргийг устгах чиглэлээр тодорхой арга хэмжээ авч ажилладаг. Цахим контентыг хянах, тэр дундаа бодит бус сүлжээний хэрэгслүүдийг устгах чиглэл дэх гол ажил нь 2019 оноос эхлэн Facebook компанитай хамтран байгуулсан Засгийн Газрын Кейс Ажиллагааны Суваг буюу олон нийтэд “ногоон суваг” нэрээр танигдсан хамтын ажиллагаа юм. “Ногоон суваг”-ын зорилго нь Монгол Улсын холбогдох хууль тогтоомжийг зөрчсөн эсвэл Meta-ийн олон нийтийн стандартад нийцэхгүй контентыг хязгаарлах явдал бөгөөд үүнд худал мэдээлэл, хуурамч хаяг, мөн Монгол Улсын хууль зөрчсөн хаяг, хуудсуудыг устгах үйл ажиллагаа багтдаг.

Үйл ажиллагааны түвшинд авч үзвэл, ХХЗХ нь тухайн контент эсвэл хэрэглэгч Монгол Улсын холбогдох хууль тогтоомжийг зөрчсөн эсэх талаар шийдвэр гаргадаг байгууллага биш. Харин цагдаа, прокурор, шүүх зэрэг холбогдох байгууллагууд гомдол, мэдээлэл, хэргийг хуульд заасан журмын дагуу шалган, контент эсвэл хаягийг хязгаарлах шийдвэрийг гарган ХХЗХ-д шилжүүлдэг. Улмаар ХХЗХ уг шийдвэрийг биелүүлж, эцсийн шатны арга хэмжээ болох хууль бус контентыг устгах эсвэл бодит бус хэрэглэгчийн

хаягийг хаах ажиллагааг платформ тал (Facebook)-тай хамтран хэрэгжүүлдэг. Хуурамч мэдээллийг таслан зогсоох үйл ажиллагаанд энэхүү механизмыг ашиглах үр нөлөө, ач холбогдлыг үнэлэхэд шаардлагатай хэдэн кейс хэрхэн шийдвэрлэгдсэн талаарх статистик болон дэлгэрэнгүй мэдээлэл одоогоор олон нийтэд нээлттэй байхгүй байна.

3.2 Олон нийтийн боловсрол, нийгмийн сөрөн тэсвэрлэх чадавх

Хэвлэл мэдээллийн болон дижитал ур чадвар, боловсрол:

Олон улсын байгууллагуудын бодлогын зөвлөмжүүдэд урт хугацааны бүтцийн шинэчлэл, тэр дундаа хэвлэл мэдээллийн боловсролын ач холбогдлыг онцолдог (Bateman and Jackson, 2024). Ярилцлагын бараг бүх оролцогч олон нийтийн дижитал болон хэвлэл мэдээллийн ур чадвар, боловсролыг дэмжих нь хуурамч мэдээллийн сөрөг нөлөөг бууруулах урт хугацааны, үр дүнтэй арга болохыг онцолж байв.

Монгол Улсад дижитал болон хэвлэл мэдээллийн боловсрол гэх ойлголтууд нь шинэ тутам сэдэв тул энэ чиглэлээрх судалгаа, нотолгоо хязгаарлагдмал байна. Монголд хэвлэл мэдээлэл, мэдээллийн боловсролыг цогц байдлаар хэмжих үндэсний индекс эсвэл тодорхой судалгаа байдаггүй боловч дижитал боловсролын чиглэлээрх өргөн хүрээтэй судалгаануудад хязгаарлагдмал байдлаар судлагдсан байдаг. Тухайлбал, Үндэсний статистикийн хороо (ҮСХ)-ны судалгааг (2021) эшэлсэн саяхны судалгаанд нийт хүн амын 43.8 хувь нь мэдээллийн ур чадвартай гэж өгүүлсэн байна (Баясгалан, 2023). ҮСХ-ны Өрхийн болон хувь хүний мэдээлэл, харилцаа холбоо, технологийн хэрэглээний судалгаанд (2021) мэдээллийн ур чадварыг хүмүүсийн бараа, үйлчилгээний талаарх мэдээлэл хайх (40.9%), төрийн байгууллагын вэбсайтаас мэдээлэл авах (29%), файлыг цахим орчинд хадгалах (19.8%), дижитал орчинд өгөгдөл, мэдээлэл хуулж, дамжуулах чадвар (16.9%) гэсэн шалгууруудаар тодорхойлсон байдаг.

Хэвлэл мэдээлэл, мэдээллийн боловсролын чиглэлээр ЮНЕСКО 2018 оноос хойш ажиллаж, боловсролын системд хэвлэл мэдээлэл, мэдээллийн боловсролыг тусгах нөлөөллийн болон чадавх бэхжүүлэх ажлуудыг идэвхтэй хэрэгжүүлж ирсэн (UNESCO, 2025). Энэхүү ажлын нэг хэсэг болгож ЮНЕСКО-ын дэмжлэгтэйгээр 2024 онд Хэвлэлийн хүрээлэн сургуулийн өмнөх, бага, дунд боловсролын сургалтын хөтөлбөрт хэвлэл мэдээлэл, мэдээллийн боловсролыг тусгах чиглэлээр хэлэлцүүлгүүд зохион байгуулж, талуудын чадавхыг бэхжүүлсэн байна. Үүнээс өмнө буюу 2019 оноос хойш ЮНЕСКО Хэвлэлийн хүрээлэнтэй хамтарч хэвлэл мэдээлэл, мэдээллийн боловсролын чиглэлээр үндэсний хэмжээний форумууд зохион байгуулж (UNESCO, 2024), хэвлэл мэдээлэл, мэдээллийн боловсролын ач холбогдлыг түгээн дэлгэрүүлэх зорилгоор Үндэсний Сүлжээ үүсгэн байгуулж байсан (UNESCO, 2021).

Ярилцлагад оролцогчдын мэдээлснээр хэвлэл мэдээлэл, мэдээллийн боловсролын чиглэлээрх ихэнх санаачилгыг иргэний нийгмийн байгууллагууд голлон хэрэгжүүлж ирсэн байдаг (Ярилцлага #2, 5, 6, 8). Зарим тохиолдолд төрийн байгууллагууд иргэний нийгмийн байгууллагуудтай хамтран олон нийтэд чиглэсэн хэвлэл мэдээллийн боловсролын кампанит ажил, үйл ажиллагаа зохион байгуулж байсан байна (Ярилцлага #10). Жишээлбэл, Хэвлэлийн хүрээлэн, Сэтгүүл зүйн Инновац, Хөгжлийн Үүр төв, Боловсролын Хамтын Ажиллагааны Нийгэмлэг, Faro Foundation Mongolia зэрэг байгууллагууд олон улсын байгууллагуудтай хамтран хэвлэл мэдээлэл, мэдээллийн боловсролын чиглэлээр сургалт, сурталчилгааны кампанит ажлууд зохион байгуулжээ.

Үндсэндээ Засгийн газрын авч хэрэгжүүлж буй арга хэмжээ нь дижитал ур чадварын өргөн хүрээтэй бодлогоор дамжуулж мэдээллийн боловсролыг дэмжих байна. Засгийн газар 2024 оны 4 сард “Бүх нийтийн цахим ур чадварын бүтцийн хүрээ”-г баталсан³ ба энэхүү хүрээ нь өгөгдөл, мэдээлэл хайх,

³ <https://legalinfo.mn/mn/detail?lawId=17431761078932&type=3>


өгөгдөл, мэдээллийг ашиглах, өгөгдөл, мэдээллийг боловсруулах гэсэн өгөгдөл, мэдээлэлтэй холбоотой гурван бүрэлдэхүүнийг багтаасан байдаг. Эдгээрээс хоёр дахь бүрэлдэхүүн нь цахим орчинд үнэн болон худал өгөгдөл, мэдээллийг ялгах талаар мэдлэг ойлголт, өгөгдөл, мэдээллийг ёс зүйтэй ашиглах талаар байна. Хэдий энэхүү хүрээний дагуу Засгийн газрын 141 дүгээр тогтоолоор Цахим хөгжил, инновац, харилцаа холбооны сайдад олон нийтийн дижитал ур чадварын сургалтууд зохион байгуулах үүрэг хүлээлгэсэн ч бидний судалгаагаар энэ тогтоолын хэрэгжилттэй холбоотой холбогдох мэдээлэл олдоогүй байна.

НҮБХХ болон НҮБ-ын Хүүхдийн сан нь иргэдийн дижитал ур чадварыг хөгжүүлэх чиглэлд Монгол Улсын Засгийн газрыг дэмжин ажиллаж байна (UN Mongolia, 2024). Энэхүү хөтөлбөрийн хүрээнд 2024 онд сургуульд түшиглэсэн “Олон нийтийн цахим мэдээллийн ажилтан (ОНЦМА)” бэлтгэх төслийг хэрэгжүүлжээ. Үүний үр дүнд нийт 68 ОНЦМА бэлтгэн ажиллуулж, 6,400 гаруй багш, сурагч, эцэг эхчүүдэд e-Mongolia, eKids, цахим гарын үсэг, цахим орчны аюулгүй байдал зэрэг сэдвээр дижитал боловсрол олгох сургалтууд зохион байгуулжээ. Уг төсөл нь туршилтын байдлаар зөвхөн нэг аймагт хэрэгжсэн тул цар хүрээний хувьд хязгаарлагдмал байна.

Гэсэн хэдий ч төслийн явцын тайланд сургуульд түшиглэсэн олон нийтийн цахим мэдээллийн ажилтан бэлтгэх арга нь үр дүнтэй байсныг дурджээ. Ярилцлагад оролцогчид ч мөн хэвлэл мэдээлэл, дижитал боловсролын сургалтыг албан болон албан бус боловсролын хөтөлбөрүүдэд оруулж, тогтвортой байдлыг хангах хэрэгтэй талаар мэдээлж байв. Тухайлбал, зарим оролцогчид ерөнхий боловсролын хөтөлбөрт оруулах хэрэгтэй гэсэн бол зарим оролцогчид үүн дээр нэмээд насан туршын боловсролын хөтөлбөрт оруулах хэрэгтэй талаар дурджээ.

Судалгааны багийн зүгээс албан боловсролын хөтөлбөрт хэвлэл мэдээллийн боловсролын агуулга хэрхэн туссан болохыг Боловсролын яамнаас тодруулахад бүх түвшний олон төрлийн хичээлүүдэд мэдээллийн боловсролын агуулга туссан гэж мэдэгдсэн. Тухайлбал, бага боловсролын цөм хөтөлбөрт “мэдээлэл, технологийн ур чадвар” багтсан байдаг ба үүнд мэдээлэл цуглуулах аргыг сонгох, мэдээлэл цуглуулах, боловсруулах, ашиглах зэрэг агуулга орсон байна (Боловсрол, Соёлын яам, 2014). Гэвч албан боловсролд хэвлэл мэдээлэл, мэдээллийн боловсролын агуулга ямар хэмжээнд туссаныг тогтоохын тулд боловсролын хөтөлбөрийг цогцоор нь үнэлж, шинжлэх шаардлага байна.

Дүрс 19. И-Монгол Академийн дижитал ур чадварын сургалтад хамрагдсан оролцогчдын тоо



Цахим ур чадварыг дэмжих өөр нэгэн санаачилга бол 2022 онд үйл ажиллагаагаа эхлүүлсэн улсын төсөвт үйлдвэрийн газар болох И-Монгол Академиас зохион байгуулдаг сургалтууд юм. Тус академи байгуулагдсан цагаасаа хойш 41,140 төрийн албан хаагч, 38,880 иргэнийг танхимын болон цахим сургалтад хамруулсан гэж мэдээлсэн. Гэвч уг академийн сургалтын хөтөлбөрт хэвлэл мэдээлэл, мэдээллийн боловсролын агуулга ямар түвшинд тусгагдсан нь тодорхой бус байна.

Хараат бус баримт шалгалт

Хуурамч мэдээлэлтэй тэмцэх, худал ташаа өгүүлэмжийг няцаах, нийгмийн дархлааг дэмжих хамгийн түгээмэл аргуудын нэг нь баримт шалгалт юм. Тодорхой өгүүлэмжийн талаарх худал ташаа ойлголтыг засахад, ялангуяа улс төрийн ямарваа нэг хүчтэй байр суурь баримталдаггүй хүмүүсийн хувьд (Bateman and Jackson, 2024) баримт шалгалт үр дүнтэй арга болохыг олон тооны судалгаанд өгүүлсэн байдаг.

Монгол Улсад хоёр хараат бус баримт шалгах төв ажилладгийн нэг нь Nest төвийн 2020 онд байгуулагдсан MFCC бол нөгөөх нь мөн онд байгуулагдсан Fact Check Mongolia (FCM) юм. MFCC нь Олон улсын баримт шалгагчдын сүлжээнд албан ёсоор бүртгэгдсэн Монгол дахь цор ганц байгууллага юм. Энэхүү хоёр байгууллага ойролцоогоор 2,000 гаруй мэдээллийг нягталж, баримт шалгажээ. Үүнээс гадна MFCC нь нийгмийн сүлжээ платформууд дахь хуурамч мэдээллийн тархалтыг бууруулах зорилгоор Meta компанийн хөндлөнгийн баримт шалгах түншээр ажиллах болсон.

2024 оны 5 сард MFCC АНУ-ын ашгийн бус байгууллага Meedan-тай хамтран Facebook Messenger дээр АСУУ нэртэй чатботыг ажиллуулж эхэлсэн байна. Meedan-ий Check програм хангамжаар ажилладаг энэхүү чатбот руу иргэд цуу яриа, медиа контент зэрэг мэдээллийг илгээж, баталгаажсан тайлбар, нягталсан мэдээллийг авах боломжтой болсон. Энэхүү ажлыг Монгол Улсын 2024 оны УИХ-ын сонгуулийн өмнө, сонгуулийн мөчлөгийн үеэр нэмэгдэх хуурамч мэдээллийг бууруулах зорилгоор санаачилсан байна.

Хараат бус баримт шалгалттай зэрэгцэн, төрийн байгууллагын баримт шалгах төв байгуулах санаачилгуудыг зарим төрийн албан тушаалтнууд, улс төрчид дэвшүүлж байв. Тухайлбал, 2025 оны 2 сард Цахим хөгжил, инновац, харилцаа холбооны сайд хэвлэлийн хурлын үеэрээ төрийн баримт шалгах төв байгуулах талаар мэдэгдэл хийсэн нь хүчтэй шүүмжлэл дагуулсан. Мэргэжилтнүүдийн зүгээс цагдаагийн байгууллага болон бусад байгууллага ямар ч баримт шалгах зарчим, аргачлал, процесс баримталдаггүй хэр нь “худал мэдээ” гэсэн тамга (шошго)-ыг ашиглаж буй нь ноцтой асуудал гэж үздэг. Ийм “худал мэдээ” гэдэг шошгыг баримт шалгах стандарт, зарчим, аргачлалыг мөрддөг, хараат бус мэргэжлийн байгууллагууд ашиглах ёстой байтал, үүнийг баримталдаггүй байгууллагууд дураар ашиглах нь хуурамч мэдээллийг бууруулахад эерэг нөлөө үзүүлэхгүй төдийгүй, хараат бус баримт шалгах үйл ажиллагааны нэр хүндийг унагаж, олон нийтийг төөрөгдүүлэх эрсдэлтэй.

Үр нөлөөний хувьд баримт шалгалт нь нэлээд маргаантай сэдэв. Худал мэдээлэл нь түүнийг няцааж, зассан мэдээллээс илүү хурдан түгэж, илүү хямд зардлаар бүтээгддэг учир баримт шалгагчид бүтцийн хувьд сул талтай байдаг (Bateman ба Jackson, 2024). Монголын нөхцөлд энэ бүтцийн бэрхшээл дээр нэмэгдээд, өргөн хүрээтэй, тогтвортой баримт шалгах үйл ажиллагааг санхүүжүүлэх болон нөөцийн тогтвортой байдлыг хангах боломж хязгаарлагдмал байна. Мөн хуурамч мэдээлэл нь ихэвчлэн зохион байгуулалттай, системтэй байдлаар тардаг тул баримт шалгалтын үр дүнг бодвол хавьгүй олон хүнд хүрдэг. Үүнээс гадна, баримт шалгалт нь тухайн хүний баримт, нотолгооны талаарх ойлголтод нөлөөлж болох ч тэдний хандлага, зан байдлыг өөрчлөхгүй байх нь элбэг.

Гэсэн хэдий ч баримт шалгалт нь хуурамч мэдээлэлтэй тэмцэх, тогтвортой тархаж буй худал өгүүлэмжийг няцаах, мөн хувь хүний хэвлэл мэдээлэл, мэдээлэлтэй харьцах зан байдлыг урт хугацаанд өөрчлөхөд чухал ач холбогдолтой хэвээр байна.

3.3 Институцийн чадавх, хамтын ажиллагаа

Хэвлэлийн эрх чөлөө ба хэвлэл мэдээллийн салбарыг чадавхжуулах

Мэдээллийн технологи хурдтай хөгжсөнөөр дэлхий дахинд хэвлэл мэдээллийн орчин, зах зээл эрс өөрчлөгдөж (Matasick нар, 2020), мэдээллийн манипуляцийн кампанит ажлуудын өмнө хэвлэл мэдээллийн салбарын дархлааг сулруулсан. Хэвлэл мэдээллийн салбар дахь ийм томоохон

өөрчлөлтүүд нь Монгол дахь “уламжлалт хэвлэл мэдээлэл”-д нөлөөлж, “дигитал медиа” өргөжсөнөөр хуурамч мэдээлэл, мэдээллийн манипуляцид өртөмтгий байдлыг улам нэмэгдүүлж, хэвлэл мэдээллийн байгууллагад итгэх олон нийтийн итгэл сулрахад хүрсэн (Нэгдүгээр бүлгийг үзнэ үү). Иймд хэвлэл мэдээллийн салбарыг бэхжүүлэх нь хуурамч мэдээлэлтэй үр дүнтэй тэмцэх үндсэн арга хэмжээний нэг юм (Bateman and Jackson, 2024).

Монголын хэвлэл мэдээллийн орчин нь нэг талаар олон ургалч үзэл, төрөлжсөн байдалтай боловч нөгөө талаар бүтцийн хувьд сул, эмзэг хэвээр байна. Хэвлэлийн Хүрээлэнгийн Монголын хэвлэл мэдээлэл-Өнөөдөр (2025) тайланд дурдсанаар Монголд нийт 389 хэвлэл мэдээллийн хэрэгсэл байна. Гэвч өмчлөлийн төвлөрөл болон улс төрийн нөлөөлөл нь редакцийн хараат бус байдлыг алдагдуулж, олон байгууллага бизнес болон улс төрийн элитүүдийн хяналтад орсон байдаг (Soon and Patel, 2022). Зар сурталчилгааны хязгаарлагдмал боломж, жижиг зах зээл нь хэвлэл мэдээллийн байгууллагуудыг санхүүгийн хувьд тогтворгүй болгож, үзэл бодлоо илэрхийлэхээс эмээхэд хүргэсээр байна (Freedom House, 2024). Үндсэн хуульд хэвлэлийн эрх чөлөөг баталгаажуулсан хэдий ч АНУ-ын Төрийн Департамент (2024)-ын тайланд сэтгүүлчид цагдаагийн байгууллагаас байцаалтад дуудагдах, “худал мэдээлэл тараасан” гэх үндэслэлээр эрүүгийн хариуцлага хүлээлгэх зэргээр дарамт шахалтад өртөж буйг тэмдэглэжээ. Үүний үр дүнд хэвлэл мэдээлэлд, ялангуяа хэвлэмэл болон онлайн хэвлэлд итгэх иргэдийн итгэл сул, харин төрийн өмчит радио, телевизүүд харьцангуй өндөр нэр хүндтэй хэвээр байна (RSF, 2025).

Хэвлэлийн эрх чөлөөг дэмжих, хэвлэл мэдээллийн салбарыг бэхжүүлэх зорилгоор Хууль Зүй, Дотоод Хэргийн Яам 2024 онд 1998 оны Хэвлэл мэдээллийн эрх чөлөөний тухай хуулийг шинэчлэх төслийг боловсруулсан. Гэвч олон нийт уг хуулийн төслийг янз янзаар харж байв. Хил хязгааргүй сурвалжлагчид энэхүү санаачилгыг дэмжсэн ч хууль тогтоогчдод сэтгүүлзүйн тодорхойлолтыг нарийвчлан тодруулах, хэвлэлийн хараат бус байдлыг баталгаажуулах, эх сурвалжийг хамгаалалтыг бэхжүүлэх, өөрийн зохицуулалтын стандартуудыг (жишээлбэл, Сэтгүүл зүйн итгэлцлийн санаачилга) дэмжих, хэвлэл мэдээллийн өмчлөл болон санхүүжилтийн ил тод байдлыг нэмэгдүүлэх шаардлагатайг сануулсан⁴. Мөн ЮНЕСКО энэ хуулийн төслийг дэмжиж, 1998 оны Хэвлэл мэдээллийн эрх чөлөөний тухай хуультай харьцуулахад илүү дэвшилттэй гэж дүгнэсэн байдаг. Харин иргэний нийгмийн байгууллагууд уг төслийг улам сайжруулах орон зай байгааг онцолж байв.

Хууль, эрх зүйн орчныг шинэчлэх санаачилгуудаас гадна хараат бус иргэний нийгмийн байгууллагууд EX, USAID, DW Akademie, ЮНЕСКО зэрэг олон улсын хөгжлийн байгууллагуудын дэмжлэгтэйгээр Монголын хэвлэл мэдээллийн салбарын бүтцийн сорилтуудыг шийдвэрлэх чиглэлд тасралтгүй ажиллаж байна. Тэдгээр байгууллагуудаас дурдвал:

- **Глоб Интернэшнл Төв** нь олон нийтэд уламжлалт хэвлэл мэдээлэл, хэвлэлийн бүтээгдэхүүн, шинэ мэдээлэл, харилцаа холбооны технологи зэрэг бүхий л боломжит сувгийг ашиглан мэдээлэл олж авахад туслах, үзэл бодлоо илэрхийлэх эрх чөлөөний мониторинг хийх, сэтгүүлчдэд хуулийн туслалцаа үзүүлэх, хэвлэл мэдээллийн эрх зүйн орчныг шинжлэх, эерэг өөрчлөлтөд уриалах чиглэлд ажилладаг.
- **Хэвлэлийн хүрээлэн** нь Монгол Улсад хараат бус, олон ургалч хэвлэл мэдээлэл хөгжүүлэх, хэвлэл мэдээллийн салбарын ажилтнуудын ур чадварыг сайжруулах, хэвлэлийн хөгжилд дүн шинжилгээ хийх, чөлөөт хэвлэлийн ач холбогдлыг олон нийтэд сурталчлах чиглэлд хувь нэмэр оруулахыг зорьдог. Мөн Хэвлэлийн хүрээлэн нь сэтгүүлчдэд сургалт орж, хэвлэл мэдээллийн чиглэлээр судалгаа, мониторинг хийж, хэвлэлийн эрх чөлөө, чадавх бэхжүүлэх чиглэлээр сурталчилгаа, нөлөөллийн ажлууд гүйцэтгэдэг.

⁴ <https://rsf.org/en/mongolia-rsf-presents-its-recommendations-strengthen-ambitious-press-freedom-bill>

- **Хэвлэл мэдээллийн зөвлөл** нь хэвлэмэл, цахим, радио, телевизийн хараат бус өөрийн зохицуулалтын байгууллага. Зөвлөл нь хэвлэл мэдээллийн эрх чөлөөг дэмжих, сэтгүүлчид болон хэвлэл мэдээллийн байгууллагуудын хараат бус байх эрхийг хамгаалах, эгэх хариуцлагыг бэхжүүлэх, ёс зүй болон мэргэжлийн стандартыг хөгжүүлэх, мэргэжлийн болон ёс зүйн зөрчлүүдийг шийдвэрлэх зорилготой ажилладаг. Хэвлэл мэдээллийн чиглэлээрх хөгжлийн төслүүдээс гадна Зөвлөл нь Монголын хэвлэл мэдээллийн салбарт гомдол хянан шийдвэрлэх, ёс зүйн хяналт хэрэгжүүлэх, редакцийн хараат бус байдлыг дэмжих, өөрийн зохицуулалтын тогтолцоог төлөвшүүлэх үндсэн хараат бус байгууллага юм. Зөвлөл нь үндэсний ёс зүйн зарчмыг баталж, олон нийтээс гомдол хүлээн авах механизмыг бүрдүүлсэн бөгөөд 2022 оны байдлаар 500 гаруй гомдол хянан шийдвэрлэсэн байна (Mysorekar, 2022).
- **Сэтгүүл зүйн Инновац Хөгжлийн Үүр төв (NEST)** нь хэвлэл мэдээллийн байгууллагуудад тогтвортой бизнес моделиг таниулах, энэ чиглэлээр чадавхжуулах, ялангуяа тодорхой чиглэлтэй, олон нийтийн ашиг сонирхлын төлөө ажилладаг хэвлэл мэдээллийг хөгжүүлэх замаар хэвлэлийн эрх чөлөөг бэхжүүлэх чиглэлд төвлөрөн ажилладаг. NEST төв нь Монголын Баримт Шалгах Төв болон хуурамч мэдээллийн эсрэг явуулдаг кампанит ажлуудаараа Монгол Улсад хуурамч мэдээлэлтэй тэмцэх үйлсэд томоохон хувь нэмэр оруулж байна. Түүнчлэн тус төв нь хэвлэл мэдээллийн салбарт инновац нэвтрүүлэх, технологи болон хиймэл оюуны хэрэгслүүдийг ашиглах, эвсэл болон хамтын ажиллагааг өргөжүүлэх ажилд идэвхтэй оролцдог. Мөн NEST төв сонгуультай холбоотой худал мэдээлэлтэй тэмцэх зорилгоор “Баримт нэн тэргүүнд” сүлжээг үүсгэн байгуулсан ба 2024 оны 6 сарын байдлаар тус сүлжээнд 9 хэвлэл мэдээллийн байгууллага, 4 төрийн бус байгууллага, нэг хуулийн фирм, нэг баримт шалгах төв гишүүнчлэлтэй байна.

Эдгээр хараат бус ТББ-ууд нь хэвлэлийн эрх чөлөө, эрх зүйн орчныг сайжруулах, хэвлэл мэдээллийн байгууллагуудыг чадавхжуулах, сэтгүүлчдийг сургах, өөрийн зохицуулалт, ёс зүйн стандартыг бэхжүүлэх, гэрчилгээжүүлэх, контентыг шошгожуулах стандарт, практикийг сайжруулах, инновацийг дэмжих, олон нийтэд нөлөөлөх, боловсролыг дэмжих, эвсэл сүлжээ байгуулах замаар Монголын хараат бус хэвлэл мэдээллийг бэхжүүлэхэд хувь нэмэр оруулж байна. Монгол Улсад хараат бус, ёс зүйтэй, олон ургалч хэвлэл мэдээллийг төлөвшүүлэхэд эдгээр ажлууд нь зайлшгүй бөгөөд үр нөлөөтэй элемент юм. Гэсэн хэдий суурь бүтцийн шинжтэй бэрхшээлүүд байсаар байна. Өөрчлөгдөж буй хэвлэл мэдээллийн орчин, зах зээлийн нөхцөл байдлаас болж уламжлалт бизнесийн загварууд сорилттой тулгарч, тэдгээрийн тогтвортой, хараат бус байдал, чадавхид нь эрсдэл тулгарч байна. Улс төрийн болон бизнесийн өмчлөлтэй холбоотойгоор хэвлэл мэдээлэлд үзүүлэх нөлөөлөл их байгаа нь тэдгээрийг “хамтын ажиллагааны гэрээ” (өөрөөр хэлбэл “хаалтын гэрээ”) зэрэг дарамтын шинжтэй нөлөөллийн аргуудад өртөмтгий болгож байна. Технологийн хөгжлийн нөлөөгөөр “дигитал медиа” гэж нэрлэгдэх онлайн орчин үйл ажиллагаа явуулдаг харьцангуй жижиг мэдээллийн агентлагуудын тоо нэмэгдэж байна. Хэвлэлийн хүрээлэнгийн (2025) судалгаагаар ийм төрлийн 148 веб сайт үйл ажиллагаа явуулдаг ба тэдгээрийн 94% нь Facebook дээр төвлөрөн ажилладаг, мөн 94 хувь нь хувийн өмчийнх байна. Хэдий эдгээр хэвлэл мэдээллийн хэрэгслийн зарим нь сайн редакцтай, ёс зүйн стандарттай, чадавхтай боловч дийлэнх нь редакцийн бодлого, зарчимгүй, хэвлэлийн мэдээллийн ёс зүйн болон өөрийн зохицуулалтын тогтолцооноос ангид гэж шүүмжлэлд өртдөг.

3.4 Хүний эрхийг хамгаалах, хөгжүүлэх

Мэдээллийн ил тод байдал, мэдээллийн аюулгүй байдлын зохицуулалт

Мэдээлэл хомс байх буюу мэдээллийн хоосон орон зайг бий болгох нь хуурамч мэдээллийн тархалтыг түргэсгэдэг (Matasick et. al., 2020). Иймээс зарим судалгаанд оролцогчид ил тод байдлыг сайжруулж,

төрийн байгууллагуудын харилцаа холбоог үр дүнтэй болгох нь хуурамч мэдээлэлтэй тэмцэх нэг арга гэж үзэж байв (Ярилцлага #13).

2021 онд УИХ төрийн ил тод байдалд шинэчлэл хийж, мэдээллийн ил тод байдал, өгөгдөл хамгаалалттай холбоотой хэд хэдэн хуулийг (Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хууль, Хүний хувийн мэдээлэл хамгаалах тухай хууль) баталсан. Эдгээр шинэ зохицуулалтууд нь мэдээллийн ил тод байдал, хүртээмжийг ерөнхийд нь сайжруулсан ч мэргэжилтнүүдийн үзэж буйгаар эрх зүйн орчинд тодорхой цоорхой, сул талууд хэвээр байна (Ярилцлага #13). Жишээлбэл, хуульд албаны нууцыг төрийн байгууллагын дарга нар тодорхойлохоор заасан нь мэдээллийг албаны нууц гэж хаяглан, олон нийтээс нуух боломжтой болгожээ.

3.5 Хуурамч мэдээллийг зохицуулах бусад оролдогууд


Маргаан дагуулсан олон нийтийн сүлжээтэй холбоотой хуулийн төсөл (2023). 2023 оны 1 сард УИХ-аас Олон нийтийн сүлжээнд хүний эрхийг хамгаалах тухай хуулийн төслийг баталсан. Энэхүү хуулийн төсөл нь төрийн байгууллагуудад үндэсний эв нэгдэл, төрийн нууц, төрийн бэлгэ тэмдгийг хамгаалах гэх мэт хэт өргөн хүрээтэй үндэслэлээр нийгмийн сүлжээн дэх контентыг устгах, хэрэглэгчийг хязгаарлах эрх мэдэл олгох зохицуулалттай байв. Түүнчлэн дотоод хэргийн сайдад интернэт үйлчилгээ зогсоох эрх олгож, төрийн албан тушаалтантай холбоотой контент мэдээллийг зөвшөөрөл авч нийтлэхийг шаардсан байв. NEST төв зэрэг иргэний нийгмийн байгууллагууд уг хуулийг яаравчлан, хэлэлцүүлэггүйгээр баталсан гэж шүүмжилж, засгийн газарт дур мэдэн шийдвэр гаргах эрх мэдэл бий болгох эрсдэлтэйг анхааруулсан. Харин Ерөнхийлөгч У.Хүрэлсүх хуульд бүхэлд нь хориг тавьсан ба RSF, IFEX зэрэг олон улсын байгууллагууд УИХ-ын гишүүдэд тус хоригийг дэмжиж, хүний эрхэд нийцсэн шинэ зохицуулалт боловсруулахыг уриалж байв.

Ерөнхийд нь авч үзвэл хуурамч мэдээллийг эрүүгийн хэрэгт тооцох болон сонгуулийн хуулинд тусгасан хуурамч мэдээллийн эсрэг зохицуулалтаас өөрөөр хуурамч мэдээллийн эсрэг тусгайлсан бодлого, эрх зүйн санаачилга байхгүй байна. Ярилцлагад хамрагдсан иргэний нийгмийн болон хэвлэл мэдээллийн салбарын төлөөлүүд хуурамч мэдээллийн эсрэг төрийн зүгээс хэрэгжүүлэх арга хэмжээнүүдэд болгоомжтой хандаж буйгаа илэрхийлсэн (Ярилцлага #4, 6). Олон нийтийн сүлжээнд хүний эрхийг хамгаалах тухай хууль, Холбоо, сангийн эрх зүйн байдлын тухай хуулийн төсөл, төрийн баримт шалгах төв байгуулах Цахим хөгжил, инновац, харилцаа холбооны яам (ЦХИХХЯ)-ны санал зэрэг төрийн зүгээс гаргасан маргаан дагуулсан санаачлагууд нь иргэний нийгэм, хэвлэл мэдээлэл, хүний эрхийн мэргэжилтнүүдийн болгоомжлолыг нэмэгдүүлсэн. Тэдний үзэж буйгаар хууль дээдлэх ёс бэхжээгүй одоогийн нөхцөлд улс төрчид хуурамч мэдээллийг шалтаг болгон үзэл бодлоо илэрхийлэх эрх, хэвлэлийн эрх чөлөөг хязгаарлах сонирхолтой байж болзошгүй. Мөн муу боловсруулсан, хэрэгжилт султай эрх зүйн зохицуулалтууд нь суурь эрхийг зөрчиж, хэвлэлийн эрх чөлөөг боомилох эрсдэлтэй юм.

4. Тулгамдсан асуудлууд

Энэхүү зураглалын судалгааны үр дүнд хуурамч мэдээллийн тархалт болон нөлөөллийг нэмэгдүүлж буй чиг хандлага, бүтцийн асуудлууд, нийгмийн суурь сул талууд, үндэсний түвшний хариу арга хэмжээний гол дутагдлуудыг тодорхойллоо. Эдгээр бүх хүчин зүйлс нь нийлээд Монгол Улсын хуурамч мэдээлэлтэй тогтвортой, үр дүнтэй тэмцэх хүчин чармайлтад сөргөөр нөлөөлж байна.

Дүрс 20. Монгол дахь Хуурамч мэдээллийн нөхцөл байдлын зураглал



Ярилцлага болон бусад эх сурвалжын мэдээллээс харахад хуурамч мэдээллийн өсөлт болон нийгэмд үзүүлж буй нөлөөлөл нь хэд хэдэн **суурь чиг хандлагаас** үүдэлтэй байна. Эдгээрээс хамгийн гол чиг хандлага нь технологийн хөгжил болон дижитал шилжилт юм. Мэдээлэл, харилцаа холбооны технологийн хөгжил болон түүний нэвтрэлт урьд өмнө байгаагүйгээр хурдацтай өсч байна. YCX-ны “Өрхийн болон хүн амын MXXT-ийн хэрэглээ” судалгаагаар (2022) Монгол Улсын хүн амын 84.3% нь өдөр тутамдаа интернет ашигладаг бөгөөд энэ үзүүлэлт хотод 88.6%, хөдөө орон нутагт 72.6%-тай байна. Мөн иргэдийн интернет ашиглах гол зорилго нь мэдээлэл олж авах (95%) байгаа ба энэ үзүүлэлт бүх байршилд 90-ээс дээш хувьтай байна. Өөр нэгэн судалгаанд (MMCG, 2021) дурдсанаар интернет хэрэглэгчид өдөрт дунджаар 7 цаг 13 минутыг интернетэд өнгөрөөдөг байна. Энэ нь интернетийн хэрэглээ тогтмол төдийгүй асар өндөр байгааг харуулж байна. Энэхүү хурдацтай өсөх асар нягт хүмүүсийн харилцаа холбоо нь мэдээллийг олон тооны иргэдэд түгээх, хүргэх үйл явцыг илүү хялбар, хямд төсөр болгож байна. Технологийн дэвшил нь хуурамч мэдээллийн контентыг илүү амар хялбар аргаар, хурдан, хямд өртөгтэйгээр үйлдвэрлэх боломжийг бүрдүүлж байна. Мөн ярилцлагад оролцогчид хиймэл оюун (GenAI), дийпфейк (deepfake) зэрэг шинэ технологиудын цаашид хуурамч мэдээллийн чиг хандлагад үзүүлэх эрсдэлийг онцлон дурдсан.

Хоёрдугаарт, хүмүүсийн мэдээлэл хүлээн авах, хэрэглэх дадал хурдацтай өөрчлөгдөж байна. Интернетийн хэрэглээ огцом өсөж, нийгмийн сүлжээний платформууд илүү түгээмэл болсон нь Монголчуудын хэвлэл мэдээлэл, мэдээлэл ашиглах дадлыг эрс өөрчилсөн. Монгол Улсад нийт 2.5 сая нийгмийн сүлжээний хэрэглэгч бүртгэлтэй байгаа нь нийт хүн амын 72 хувьтай тэнцэж байна (Datareportal, 2024). Нийгмийн сүлжээ хэрэглэгчдийн тоо өсөөд зогсохгүй, тэдгээр платформд зарцуулж буй хугацаа ч мөн нэмэгдсээр байна. MMCG-ийн (2024) судалгаагаар Монгол хүмүүс өдөрт


дунджаар 197 минутыг нийгмийн сүлжээнд зарцуулдаг бөгөөд энэ үзүүлэлт нь телевиз үзэхэд зарцуулдаг хугацаанаас 73 минутаар илүү байна. Үүнээс 143 минутыг нь зөвхөн Facebook-т өнгөрөөдөг байна. Иргэдийн улс төрийн мэдээлэл хүлээн авдаг анхдагч эх сурвалж нь телевиз (73.6%) байсан бол интернетийн (63.7%) эзлэх хувь хурдацтай нэмэгдэж хоёр дахь гол эх сурвалж болсон байна (IRIM, 2023). Өөр нэгэн судалгаагаар улс төрийн мэдээ, мэдээллийн анхдагч эх сурвалжаар 50% нь телевизийг, 41% нь нийгмийн сүлжээг, 7% нь интернет мэдээний сайтуудыг нэрлэжээ (БНОУХ, 2022). Харин бүх хариултыг нэгтгэн харвал судалгаанд оролцогчдын бараг 100% нь нийгмийн сүлжээг, 74% нь телевизийг, ердөө 14% нь мэдээний сайтуудыг мэдээллийн эх сурвалжаараа ашигладаг байна (БНОУХ, 2022).

Дижитал шилжилт эрчимжиж, нийгмийн сүлжээний хэрэглээ нэмэгдсэнээр хэвлэл мэдээллийн зах зээл өөрчлөгдөж, уламжлалт хэвлэл мэдээллийн байгууллагуудын бизнесийн загварт хүндрэл, сорилт учирч байна. Аль хэдийн хэврэг байдалтай байсан Монголын хэвлэл мэдээллийн зах зээл дижитал шилжилтийн нөлөөгөөр улам бүр тогтворгүй болж байна. Хэвлэлийн хүрээлэнгийн 2025 оны “Монголын хэвлэл мэдээлэл-Өнөөдөр” тайланд Монгол Улсын жижиг зах зээлд 389 орчим хэвлэл мэдээллийн байгууллага өрсөлдөж буйг дурджээ. Эдгээрийн олонх нь улс төрийн болон бизнесийн ашиг сонирхол бүхий этгээдүүдийн мэдэлд байх ба редакцийн байгууллага гэхээсээ илүү маркетингийн хэрэгсэл маягаар ажилладаг нь сэтгүүлзүйн чанар болон дижитал орчинд өссөн хэрэглэгчдийн итгэлцлийг бууруулах шалтгаан болж байна (Soon and Patel, 2022). NEST төвийн тайланд (Soon and Patel, 2022) өсөн нэмэгдэж буй нийгмийн сүлжээний хэрэглээ, платформын оролцооны алгоритмууд нь уламжлалт хэвлэл мэдээллийн агуулгыг шахаж, чанар багатай ч богино хугацаанд өргөн хүрээтэй тархдаг контентын өрсөлдөөнийг нэмэгдүүлж буй талаар онцолсон байна. Ийм өрсөлдөөнтэй боловч нөөц багатай орчинд сенсаци болон кликбейт цэцэглэн хөгжиж, мэргэжлийн сэтгүүлзүй суларснаар, тэрхүү орон зайг хуурамч мэдээлэл амархан нөхөх боломж бүрдэж байна.

Улс төрийн өнцгөөс авч үзвэл улс төрийн туйлшрал, институцэд итгэх олон нийтийн итгэл буурах үзэгдэл нь хуурамч мэдээлэлтэй нягт уялдаатай. Олон ардчилсан улсад улс төрийн туйлшрал гүнзгийрч, улмаар “авторитарчлал” нэмэгдэх үйл явцтай нягт холбоотой байна. V-Dem (2024; 2025) тайланд дурдсанаар 2010-аад оноос хойш ардчиллын доройтолд орж буй улс орны тоо т өсөж, 2024–2025 онд түүхэн өндөр түвшинд хүрээд байна. Нөгөө талаар, олон улс оронд төрд итгэх иргэдийн итгэл бага байна. ЭЗХАХБ-ын 2023 оны олон улсын судалгаагаар ЭЗХАХБ-ын 30 орны иргэдийн ердөө **39%** нь төр засагтаа өндөр эсвэл дунд зэрэг итгэдэг гэсэн бол 44% нь бага эсвэл огт итгэдэггүй гэж хариулжээ (OECD 2024; 2025). Зөвхөн төрд итгэх итгэл ч бус хэвлэл мэдээлэл, иргэний нийгэм зэрэг институцүүдэд итгэх итгэл ч сул байна (Edelman, 2024). 2024 оны сонгуулийн “супер циклийн” үеэр улс төрийн туйлшрал нэмэгдэж, иргэдийн итгэл суларч буй хандлага улам тод харагдав. Pew Research Center-ийн мэдээлснээр бүс нутгуудад сонгуулийн өрсөлдөөн туйлширч, эрх баригч хүчнүүдэд итгэх итгэл буурсаар байгаа нь ажиглагдсан байна (Pew Research Center, 2024). Ийм тогтворгүй улс төрийн орчин нь хуурамч мэдээлэл тархахад ээлтэй нөхцөл болж, мэдээллийн манипуляцийг үзэл суртал, улс төрийн өрсөлдөөнд өргөн ашиглагдах хэрэгсэл болгодог.

Эдгээр суурь чиг хандлагууд нь хуурамч мэдээллийн өгүүлэмжүүдийг богино хугацаанд, өргөн хүрээнд үйлдвэрлэж, түгээх боломжийг нэмэгдүүлж байгаа бол Монгол Улсын **бүтцийн асуудлууд** хуурамч мэдээлэлтэй үр дүнтэй, үр ашигтай байдлаар тэмцэх боломжуудыг хязгаарлаж байна. Энэ хүрээнд хамгийн тулгамдаж буй асуудлууд нь засаглалын сул байдал болон эрх чөлөө хумигдаж буй явдал юм.


Дүрс 21. Хуулийн засаглалын индекс, Монгол Улс



Эх сурвалж: Дэлхийн засаглалын үзүүлэлтүүд, Дэлхийн Банк

Төрийн хариуцлага, ил тод байдал, хуулийн засаглал сул байх нь Монгол Улсын хувьд бүтцийн асуудлуудын нэг хэвээр байна. Тухайлбал Монгол Улсын хуулийн засаглалын индекс тогтмол доогуур үзүүлэлттэй байсаар ирсэн ба ардчилсан хувьсгал болсон 1990 оны түвшинд хүрч уруудсан байдалтай байна (V-Dem, 2025). Дуу хоолой ба хариуцлагын индексийн үзүүлэлт 30 жилийн өмнөхөөс дордсон байгаа нь Засгийн газрын хариуцлагын түвшин сайжрахгүй байгааг харуулж байна. Сүүлийн арван жилийн хугацаанд авлигын төсөөллийн индекс тасралтгүй буурч, хариуцлага, хуулийн засаглал сул байгаа нь Засгийн газар хуурамч мэдээлэлтэй үр дүнтэй тэмцэхэд бүтцийн томоохон асуудал болж байна. Энэ нь олон талын сөрөг нөлөөтэй. Нэгдүгээрт, төрийн хариуцлага, ил тод байдал, авлигын хяналт сул байх нь иргэний дуу хоолой, оролцоог хязгаарлаж, улмаар төрийн институцүүдэд итгэх олон нийтийн итгэлийг улам бүр доройтуулдаг.

Дүрс 22. Дуу хоолой ба хариуцлагын индекс, Монгол Улс




Эх сурвалж: Дэлхийн засаглалын үзүүлэлтүүд, Дэлхийн Банк

Хоёрдугаарт, төрийн шударга байдал, хариуцлагын түвшин, хуулийн засаглал сул байх нь хуурамч мэдээлэлтэй тэмцэх бодлого, зохицуулалтыг үр дүнтэй боловсруулж хэрэгжүүлэх төрийн чадамжийг хязгаарлаж байна. Өмнөх бүлэгт дурдсанчлан тодорхой зохицуулалт, бодлогууд байгаа боловч тэдгээрийн уялдаа холбоо сул, хязгаарлагдмал байна. Ярилцлагууд болон үр дүн баталгаажуулах хэлэлцүүлгийн үеэр энэ төрлийн зохицуулалт, механизмууд тэгш хүртээмжтэй, шударга, тогтвортой

байдлаар хэрэгжихгүй байгааг дурдсан. Тухайлбал, хэлэлцүүлгийн оролцогчид ХХЗХ Facebook-тэй хамтран байгуулсан “ногоон суваг”-ийг хуурамч мэдээлэлтэй тэмцэхээс илүүтэйгээр эсэргүүцэл, шүүмжлэлийг хязгаарлахад ашиглаж буй эсэхэд санаа зовниж байв. Эрүүгийн хуулийн 13.14-р зүйлээр сэтгүүлчдэд ял оноох явдал нь хуулийн засаглалын сул байдал хэрхэн хуурамч мэдээллийн эсрэг бодлого, зохицуулалтын үр нөлөөг сулруулж болзошгүйг харуулсан өөр нэг жишээ юм.

Түүнчлэн судалгааны үр дүнгээс харахад (хоёрдугаар бүлгийг харна уу) засгийн газар, түүний агентлаг, албан тушаалтнууд хуурамч мэдээллийн сүлжээнд гол талуудын нэг байна. Энэ нь сайн засаглалын зарчим хэрэгжихгүй байх нь хуурамч мэдээллийг улам өөгшүүлдэг болохыг харж болно.

Дүрс 23. Хэвлэлийн эрх чөлөөний индекс, Монгол Улс



Эх сурвалж: Хэвлэлийн эрх чөлөөний индекс, Хил хязгааргүй сурвалжлагчид

Монгол Улсад хэвлэлийн эрх чөлөө, иргэний орон зай хумигдаж буй явдал нь өөр нэг ноцтой сорилт болж байна. Монголын хэвлэлийн эрх чөлөөний индекс сүүлийн арван жил бараг тасралтгүй уруудсаар иржээ. Энэ нь зөвхөн хэвлэл мэдээллийн өмчлөлийн бүтэц асуудал, байгууллагын чадавх, салбарын өөрийн зохицуулалтын сул байдал зэргээс гадна, гүтгэлэг, “хуурамч мэдээлэл” гэх нэрийн дор үзэл бодлоо илэрхийлэх эрхийг өргөн хүрээнд хязгаарлах зохицуулалтуудтай холбоотой. Ийм эрх зүйн орчин нь сэтгүүлчдийг шүүхэд өгөх, яллах эрсдэлд оруулж, хэвлэлийн эрх чөлөөг ноцтойгоор боомилон, сэтгүүлчид өөрсдийгөө хязгаарлах, улс төржих, нэг талд ажиллах хандлагыг эрчимжүүлж байна. Хэвлэлийн эрх чөлөө хумигдаж буйн зэрэгцээ иргэний орон зай хумигдаж, хүний үндсэн эрх, эрх чөлөө хязгаарлагдаж байна. “CIVICUS Monitor”-ын үнэлгээгээр Монгол Улсын иргэний орон зай “саадтай” ангилалд орж, 60 оноо авчээ. Иргэний орон зай доголдох үзэгдэл нь хэвлэлийн эрх чөлөөний доройтолтой адил олон талт шалтгаантай бөгөөд салбарын болон институцийн чадавх сул байх, нөөцийн хомсдол, иргэний оролцоо багасах зэрэг хүчин зүйлсээс үүддэг. Гэвч хамгийн ноцтой нь үндсэн эрх, эрх чөлөөг хязгаарласан аливаа үйл ажиллагаа болон хүний эрхийн зөрчлүүд юм. Жишээлбэл, Зөрчлийн хуулийн 5.13 дугаар зүйл (“Гамшгаас хамгаалах тухай хууль зөрчих”)–ийг ашиглаж, үзэл бодлоо илэрхийлэх эрхийг хязгаарласан тохиолдлууд гарсан нь үүний тод жишээ болж байна (GIC, 2021). ХЭҮК (2021) “Монгол Улс дахь хүний эрх, эрх чөлөөний байдлын талаарх 20 дахь илтгэл”-дээ иргэд өөрийн нийгмийн сүлжээний хаягаар үзэл бодлоо илэрхийлсний төлөө Зөрчлийн хуулиар шийтгэгдсэн тохиолдлууд бүртгэгдсэн талаар дурдсан байдаг. Эвлэлдэн нэгдэх, тайван жагсах, цугларах эрхүүд ч мөн зохисгүй хууль эрх зүйн хязгаарлалт болон ойлгомжгүй зохицуулалтуудаас болж сорилт бэрхшээлүүдтэй тулгарч байна. Тухайлбал, Глоб Интернэшнл төвийн 2021 оны судалгаагаар 51 удаагийн жагсаал, цуглааны үеэр эрх баригчид торгууль оноох, албадан тараах, баривчлах, дарамт шахалт үзүүлэх зэрэг арга хэмжээг авсан байна. Монгол Улс дахь хүний эрх, эрх чөлөөний байдлын талаарх 20 дахь илтгэлд (ХЭҮК, 2021) зарим жагсаалыг хүч хэрэглэн тараагаагүй ч тэдгээрийн зохион байгуулагч, санаачлагчдад торгууль оногдуулсан тохиолдлууд байсан талаар дурджээ. Мөн Холбоо, сангийн эрх зүйн байдлын тухай хуулийн төсөл, хориг тавигдсан Олон нийтийн сүлжээнд хүний эрхийг хамгаалах тухай хууль зэрэг иргэний нийгмийн орон зай, хүний үндсэн эрх, эрх чөлөөг улам эрсдэлд оруулахуйц хэд хэдэн хуулийн төслийг батлуулах оролдлогууд байв. Хэвлэлийн эрх чөлөө болон иргэний нийгмийн орон зайг хязгаарлах энэ мэт үйлдлүүд, салбарын бусад

сорилтуудтай хавсарч хэвлэл мэдээлэл болон иргэний нийгмийг хуурамч мэдээлэлтэй тэмцэхэд шаардлагатай бие даасан, үр нөлөөтэй оролцогч байх боломжийг эрс бууруулж байна.

Энэ сорилтыг улам хүндрүүлж, хуурамч мэдээллийн нөлөөллийг улам нэмэгдүүлж, нийгмийн дархлааг сулруулж хүчин зүйл нь **нийгмийн суурь сул талууд** байна. Технологийн хөгжлийн хоцрогдол, геополитикийн нөлөө, нийгэм-улс төрийн шилжилтийн үр дагавар зэрэг олон асуудлыг үүнд оруулж болно. Ярилцлагад оролцсон олон хүн иргэдийн дижитал, мэдээллийн боловсрол дутмаг байгааг онцолж байв. ҮСХ-ны тайланд (2022) Монгол Улсын хэмжээнд дижитал ур чадвар 43.8 хувьтай байна гэжээ. Зөвхөн дижитал болон хэвлэл мэдээллийн боловсрол ч бус мэдээллийн боловсрол ч сул хэвээр байна. Түүнчлэн иргэний боловсролын түвшин ч доогуур хэвээр байгаа нь нөхцөл байдлыг улам хүндрүүлж байна. Эдгээр хүчин зүйл нийлээд иргэдийг нийгмийн амьдралд утга учиртайгаар оролцох, дуу хоолойгоо бодитой хүргэх боломжийг хязгаарлаж, хуурамч мэдээлэлд өртөмтгий болгодог. Харамсалтай нь энэ асуудлыг илүү гүнзгий ойлгож, бодитой шинжлэхэд шаардлагатай сүүлийн үеийн судалгааны баримт хомс хэвээр байна.

Эцэст нь дүгнэхэд Монгол Улсын хувьд хуурамч мэдээлэлтэй тэмцэх нэн чухал шаардлагатай байгаа хэдий ч үүнд тодорхой **бэрхшээл, сорилтууд** саад болж байна. Өмнөх хэсэгт хууль, дүрмийг тэгш, нэг ижил зарчмаар хэрэгжүүлэхтэй холбоотой хүндрэл бэрхшээлүүд, хуурамч мэдээлэлтэй тэмцэх үйл ажиллагааны уялдаа холбоо сул, салангид байдал, зарим санаачилгуудын цар хүрээ болон тогтвортой байдал хангалтгүй байх, мөн үзэл бодлоо илэрхийлэх эрх чөлөөнд үзүүлэх сөрөг үр нөлөө зэрэг асуудлуудыг хөндсөн. Гэвч Монголын хуурамч мэдээлэлтэй тэмцэх хүчин чармайлтын хамгийн гол дутагдал нь хуурамч мэдээллийг цогцоор нь авч үзээгүйд оршино. Тухайлбал хуурамч мэдээллийн олон түвшний нарийн бүтэц, сүлжээ, оролцогчдын ялгаатай байдал, зохион байгуулалт, санхүүжилт зэрэг нарийн төвөгтэй байдлыг нь орхигдуулж байна. Одоогийн зохицуулалтууд ихэвчлэн хуурамч мэдээллийн контенттэй тэмцэх, хувь хүмүүс, сэтгүүлчдэд хариуцлага тооцоход төвлөрч, “хуурамч мэдээллийн сүлжээ”-ний дээд түвшинд байрлах гол оролцогчдод хариуцлага тооцож чадахгүй байна.

Энэ нөхцөлд хуурамч мэдээлэлтэй үр дүнтэй тэмцэхийн тулд цогц, салбар хоорондын уялдааг хангасан, нийгмийн бүх талуудыг хамруулсан хандлагаар ажиллах нь нэн чухал. Хуурамч мэдээлэлтэй тэмцэх стратеги нь урт хугацаандаа үр дүнтэй, тэсвэртэй байлгахын тулд суурь чиг хандлага, бүтцийн болон нийгмийн суурь асуудлуудыг шийдвэрлэж, тогтмол, зохион байгуулалттай түгээдэг, хамгийн хор хөнөөлтэй хуурамч мэдээлэл болон оролцогч талууд руу чиглэх хэрэгтэй.

Дүгнэлт

Хуурамч мэдээлэл нь Монгол Улсад ердийн нэг үзэгдэл бус, нийгмийн ноцтой асуудлын түвшинд хүрчээ. Олон нийтийн дунд эрүүл, үндэслэлтэй хэлэлцүүлэг өрнөх боломжийг хумьж, нийгмийн итгэлцлийг сулруулан, нийгмийн олон салбарт бодитой сөрөг үр дагавар учруулж буйд иргэдийн ойролцоогоор тавны дөрөв нь энэ асуудал улс орны хэмжээнд тулгамдсан сорилт болсон гэдэгтэй санал нийлж байна. Хуурамч мэдээлэл нь нийгмийн эрүүл мэнд, эдийн засгийн шийдвэр гаргалт, нийгмийн эв нэгдэл зэрэг олон салбарт нэгэн зэрэг нөлөөлөхийн зэрэгцээ иргэдийн мэдээлэлд суурилсан шийдвэр гаргах чадавхыг сулруулж, ардчилсан үйл явцад утга учиртайгаар оролцох боломжийг хязгаарлах замаар улс төр, ардчилсан засаглалын тогтвортой байдалд ч сөргөөр нөлөөлж байна.

Сүүлийн жилүүдэд эрчимтэй өрнөсөн дижитал шилжилт нь мэдээллийн манипуляцийн өртөг болон цар хүрээг үндсээр нь өөрчилсөн. Мэдээлэл, харилцаа холбооны технологийн хурдацтай хөгжил, интернетийн өргөн хүртээмж, тэр дундаа Монгол Улсад Facebook платформын давамгайл хэрэглээ нь хуурамч, төөрөгдүүлсэн агуулгыг маш бага зардлаар, богино хугацаанд, асар өргөн хүрээнд үйлдвэрлэж, түгээх нөхцөлийг бүрдүүлж байна. Хэрэглэгчийн оролцоог урамшуулдаг сошиал медиагийн алгоритмууд, төлбөртэй “boost”, хуурамч хаяг, бот зэрэг хэрэгслүүдтэй хослон сэтгэл хөдлөлд суурилсан худал мэдээлэл маш богино хугацаанд олон нийтийн анхааралд хүрэх боломжтой болжээ. Үүн дээр хиймэл оюунд суурилсан синтетик агуулгыг нэмэгдэж эхэлж байгаа хэдий ч одоогийн байдлаар Монгол Улсад тархаж буй хуурамч мэдээллийн дийлэнх нь бодит мэдээллийг гуйвуулан ашиглах, эсвэл үнэн мэдээллийг санаатайгаар хэсэгчлэн сонгож, тодорхой өнцгөөс тайлбарлан төөрөгдүүлэх зэрэг аргачлалд голлон тулгуурлаж байна.

Үүний зэрэгцээ нийгэм, улс төрийн эмзэг байдал нь хуурамч мэдээллийн тархалт, нөлөөллийг улам нэмэгдүүлэх таатай хөрс болж байна. Нийгэм, улс төрийн туйлшрал өндөр байх, хэвлэл мэдээллийн салбарын эдийн засгийн бие даасан байдал, редакцын бодлого, мэргэжлийн чадавх сул байх, олон нийтийн мэдээллийн боловсролын хөгжил хангалтгүй байх, төрийн байгууллага болон мэдээллийн эх сурвалжуудад итгэх иргэдийн итгэл аль хэдийн доройтсон зэрэг бүтцийн асуудлууд нь дижитал орчны хүчин зүйлстэй огтлолцон хуурамч мэдээлэл илүү амархан тархах, иргэдийн түүнд итгэх магадлалыг нэмэгдүүлэх нөхцөлийг бүрдүүлж байна. Мөн албан ёсны, найдвартай эх сурвалжууд худал өгүүлэмжийг залруулсан ч үр дүн нь хязгаарлагдмал хэвээр байх, олон нийтийн итгэлийг дахин сэргээхэд хүндрэлтэй байх давхар сорилтууд үүссээр байна.

Энэ орчинд талд хуурамч мэдээллийн зохион байгуулалт өргөжиж мэргэжлийн түвшинд хүрч байна. Энэхүү судалгаагаар Монгол Улсад бүрэлдэж буй “хуурамч мэдээллийн эдийн засаг”-ийн хүрээг тодорхойлохыг зорьсон. Энэ хүрээнд улс төрийн ивээн тэтгэгчид, санхүүжүүлэгчид, PR болон коммуникацийн багууд, хэвлэл мэдээллийн байгууллагууд, инфлюенсерүүд, троллын сүлжээ зэрэг олон тал өөр өөрийн үүргийг гүйцэтгэн, уялдаа холбоо бүхий сүлжээг бүрдүүлж буй нь ажиглагдлаа. Судалгааны үр дүнгээс үзэхэд Монгол Улсад урт хугацаанд, өргөн хүрээтэй нөлөө үзүүлдэг хуурамч мэдээлэл нь нэг этгээдийн санаачилга бус, харин дээрх өөрчдийн чиг үүрэг бүхий олон талын хамтын үйл ажиллагааны үндсэн дээр бий болж байна. Үүнд өгүүлэмж, агуулгыг боловсруулах PR болон медиа багууд, тэдгээрийг түгээх хэвлэл мэдээллийн хэрэгсэл, инфлюенсерүүд, улмаар троллын сүлжээ болон жирийн хэрэглэгчид мэдээллийг өргөн хүрээнд түгээх зэрэг олон шат дамжлагатай оролцогчид багтаж байна. Эдгээр сүлжээ нь улс төр, геополитикийн ач холбогдол өндөр асуудлуудын үед идэвхжиж, мэдээллийн орон зай, олон нийтийн санаа бодолд нөлөөлөх “үйлчилгээ” үзүүлдэг, зах зээлийн шинжтэй орчинд ажиллаж буй мэт харагдаж байна. Улс төрийн оролцогчид нь дотоодын хуурамч мэдээллийн орон зайд голлох үүрэгтэй хэдий улс төрийн оролцогчид өөрсдөө хуурамч мэдээллийн хамгийн гол бай болж байна. Судалгаанд оролцогчид улс төрчид% улс төрийн хүчнүүдийг хуурамч

мэдээллийн эх сурвалж, гол санхүүжүүлэгч гэж тууштайгаар тодорхойлж байв. Ялангуяа сонгууль болон бусад улс төрийн үйл явдлын үед төдний оролцоо өндөр байна.

Гэсэн хэдий ч өнөөгийн хариу арга хэмжээнүүд нь хязгаарлагдмал, ихэвчлэн реактив шинжтэй, уялдаа холбоо сул хэвээр байна. Хууль эрх зүйн болон зохицуулалтын хэрэгслүүд нь ихэвчлэн шийтгэлд төвлөрсөн эсвэл тодорхой бус томъёололтой байгаа нь хуурамч мэдээллийн суурь, бүтцийн шалтгаануудыг шийдвэрлэхээс илүүтэйгээр үг хэлэх эрх чөлөө, хараат бус сэтгүүл зүйд эрсдэл учруулах магадлалтай байна. Цаашид бодлогын шинэ хариу арга хэмжээнүүдийг буруу ашиглах, хэт хязгаарлах шинжтэй болгох, улмаар ардчилал болон хүний эрхэд сөргөөр нөлөөлөх эрсдэл бий гэсэн болгоомжлол ч нэмэгдэж байна. Иргэний нийгэм, хэвлэл мэдээллийн байгууллагууд, олон улсын түншүүдийн хэрэгжүүлж буй баримт шалгалт, мэдээллийн боловсрол, чанартай хариуцлагатай сэтгүүл зүйг дэмжих санаачилгууд нь чухал ач холбогдолтой боловч нөөц, чадавхын хувьд дутмаг, нөлөөллийн цар хүрээ хязгаарлагдмал хэвээр байна.

Эдгээрийн үр дүнд Монголын нийгэм, институцүүд болон иргэд хуурамч мэдээлэлд өртөх эрсдэл өндөр хэвээр үлдэж байна. Тогтвортой, зохион байгуулалттай хуурамч мэдээлэл нь хэвлэл мэдээлэл болон улс төрийн институцүүдэд итгэх итгэлийг сулруулж, ардчилсан үйл явцад итгэх итгэлийг доройтуулан, иргэдийн дунд түгшүүр, бухимдал, туйлшралыг нэмэгдүүлж байна. Үүн дээр хэвлэл мэдээллийн хараат бус байдлын эмзэг байдал, дижитал болон мэдээллийн боловсролын жигд бус түвшин, нийгэм-эдийн засгийн тэгш бус байдал, засаглалын дутагдал зэрэг бүтцийн хүчин зүйлс мэдээллийн сөрөн тэсвэрлэх чадавхыг улам хязгаарлаж, тодорхой бүлгүүдийг илүү эмзэг байдалд оруулж байна. Иймд Монгол Улсад хуурамч мэдээлэлтэй тэмцэх нь зөвхөн хэсэгчилсэн, богино хугацааны арга хэмжээгээр хязгаарлагдах бус, институцүүдийг бэхжүүлэх, хараат бус хэвлэл мэдээллийг дэмжих, иргэдийн шүүмжлэлт сэтгэлгээ, чадавхыг нэмэгдүүлэх, мөн хуурамч мэдээллийн “эдийн засаг”-ийг тэтгэж буй улс төр, эдийн засгийн урамшууллын бүтцийг зэрэгцүүлэн шийдвэрлэх цогц, хүний эрхэд суурилсан, урт хугацааны бодлого зайлшгүй шаардаж байна.

Зөвлөмж

Хуурамч мэдээлэл болон түүнд авч буй хариу арга хэмжээнүүдийн талаар системтэй судалгаанд хөрөнгө оруулах: Судалгааны үр дүнгээс харахад Монгол Улсад хуурамч мэдээлэлд өртөх системийн эмзэг байдал өндөр байгаа бөгөөд бодлогын хариу арга хэмжээнүүдэд зайлшгүй анхаарал хандуулахуйц хийдэл, сул талууд ажиглагдаж байна. Эдгээр нь хуурамч мэдээллийн тодорхой элементүүд, салбар, хэлбэрүүдэд чиглэсэн илүү гүнзгийрүүлсэн, системтэй судалгаа хийх зайлшгүй шаардлагатайг харуулж байна. Иймд хуурамч мэдээллийн төрөл, гол оролцогчид, эмзэг бүлгүүдийг нарийвчлан тодорхойлох, мөн одоогийн хууль эрх зүйн, зохицуулалтын, боловсролын болон платформд суурилсан арга хэмжээнүүдийн үр нөлөө, түүнчлэн урьдчилан тооцоолоогүй сөрөг үр дагаврыг тодруулах зорилгоор тодорхой цаг хугацааны давтамжтай (longitudinal) судалгаануудыг гүйцэтгэх нь зүйтэй.

Агуулгатай “тэмцэх”-ээс илүүтэйгээр мэдээллийн сөрөн тэсвэрлэх чадавх, институцийн чадамжийг тэргүүлэх чиглэл болгох: Худал, манипуляцийн шинжтэй өгүүлэмж, агуулгыг их хэмжээгээр, богино хугацаанд үйлдвэрлэх өртөг улам буурч, тархах хурд нь нэмэгдэж буйтай холбоотой хуурамч мэдээлэл цаашид цахим орчинд улам өсөн нэмэгдэх болно. Ийм нөхцөлд хязгаарлагдмал нөөц бололцоогоо хуурамч агуулгатай тэмцэхэд төвлөрүүлэх нь үр ашиг багатай, тогтвортой бус шийдэл юм. Харин бодлого, санхүүжилтийн анхаарлыг ардчиллын сөрөн тэсвэрлэх чадавхыг бэхжүүлэхэд—хараат бус хэвлэл мэдээлэл, хариуцлагатай засаглал, иргэдийн шүүмжлэлт сэтгэлгээ, мэдээллийн боловсролыг нэмэгдүүлэхэд—чиглүүлэхийн зэрэгцээ хуурамч мэдээллийг тэтгэж буй бүтцийн шалтгаануудыг шийдвэрлэх нь илүү үр дүнтэй юм. Үүнийг хэрэгжүүлэхдээ голчлон эрүүгийн хариуцлага, шийтгэл эсвэл хуурамч агуулгыг олж хэсэгчлэн хаах аргуудаас илүүтэй урт хугацааны, системийн хандлагыг баримтлах нь тохиромжтой.

Улс төрийн намууд болон төрийн байгууллагын шударга байдал, хариуцлагыг бэхжүүлэх: Судалгааны үр дүнгээс харахад төрийн байгууллагууд, олон нийтийн институцүүд, ялангуяа улс төрийн оролцогчид хуурамч мэдээллийн гол эх үүсвэр, санхүүжүүлэгчээр тодорхойлогдохын зэрэгцээ, өөрсдөө ч хуурамч мэдээллийн хамгийн түгээмэл бай болдог байна. Иймээс улс төрийн институцүүд өөрсдийн үйл ажиллагаа болон гишүүдийнхээ харилцаанд ил тод байдал, шударга ёс, хариуцлагыг шаардах нь онцгой ач холбогдолтой. Тухайлбал, улс төрийн харилцаанд баримтлах ёс зүйн тодорхой стандартуудыг баталж мөрдүүлэх, улс төрийн сурталчилгаа, PR үйл ажиллагааны ил тод байдлыг хангах, олон нийтийн итгэлийг алдагдуулдаг зохион байгуулалттай мэдээллийн манипуляцид хяналт тавих, хариуцлага тооцох механизмыг бэхжүүлэх шаардлагатай.

Хуурамч мэдээлэлтэй тэмцэх бүх арга хэмжээг ил тод, нотолгоонд суурилсан болгох: Шинэ бодлого, зохицуулалтын арга хэмжээ санал болгохоос өмнө одоогоор хэрэгжиж буй арга хэмжээнүүдийн үр нөлөө, сул тал, хэрэгжилтийн түвшнийг бодитоор үнэлж, тэдгээрийг сайжруулан хэрэгжүүлэх нь чухал. Төрийн хариуцлага, ил тод байдал сул, хууль дээдлэх ёс хангалтгүй нөхцөлд оролцогч талууд бодлого боловсруулах, хэрэгжүүлэх, хянах үйл явцад хангалттай мэдээлэлгүй, оролцоогүй үлдэх нь түгээмэл байдаг. Энэ нь хуурамч мэдээлэлтэй тэмцэх арга хэмжээнүүдийн шударга байдал, бодит хэрэгжилтэд эргэлзээ төрүүлэх үндэслэл болдог. Иймээс одоо хэрэгжиж буй хэрэгслүүдийг (тухайлбал, Эрүүгийн хуулийн холбогдох заалтууд, ХХЗХ–Facebook-ийн “ногоон суваг”, e-Mongolia платформын гомдол хүлээн авах функцүүд гэх мэт) системтэйгээр хянах, олон нийтэд нээлттэй тайлагнах, хараат бусаар үнэлэх нь зайлшгүй шаардлагатай. Улмаар энэхүү нотолгоонд суурилан, хэвлэл мэдээлэл болон иргэний нийгмийн байгууллагуудын оролцоотойгоор арга хэмжээнүүдийг сайжруулах, нарийсгах, эсвэл дахин загварчлах нь зүйтэй.

Зөвхөн хууль эрх зүйн зохицуулалтад бус, бодлогын олон талт арга хэмжээг хослуулахад анхаарах: Олон улсын байгууллагууд, шинжээчид хуурамч мэдээлэлтэй тэмцэхэд нийгмийг бүхэлд нь

хамарсан, цогц хандлага (whole-of-society approach)-ыг баримтлахыг зөвлөж, хэт хязгаарлагдмал хууль эрх зүйн зохицуулалт, шийтгэлд тулгуурлах бодлогоос зайлсхийхийг зөвлөж байна. Иймд шийдвэр гаргагчид, төрийн байгууллагууд хуурамч мэдээлэлтэй тэмцэхдээ зөвхөн эрүүжүүлэх, хэсэгчилсэн зохицуулалтад төвлөрөхөөс татгалзаж, олон талт оролцогчдыг хамарсан бодлогын өргөн хүрээтэй хэрэгслийг ашиглах нь тохиромжтой. Үүнд олон нийттэй харилцах стратеги, хараат бус хэвлэл мэдээллийг дэмжих, боловсрол болон мэдээллийн боловсролыг сайжруулах, институт хоорондын хамтын ажиллагааг бэхжүүлэх, технологи ба инновацийг ашиглах, платформын ил тод байдлыг нэмэгдүүлэх зэрэг арга хэмжээнүүдийг сайтар боловсруулсан хууль эрх зүйн зохицуулалттай хослуулан хэрэгжүүлэх нь чухал юм.

Хараат бус, хариуцлагатай, тогтвортой хэвлэл мэдээллийг бэхжүүлэх: Хуурамч мэдээлэл, мэдээллийн манипуляцитай тэмцэхэд мэдээллийн орчныг хамгаалах гол тал нь хэвлэл мэдээллийн салбар юм. Иймд Монгол Улсад хариуцлагатай хэвлэл мэдээллийг бэхжүүлэх нь суурь, зайлшгүй арга хэмжээ гэж үзэх хэрэгтэй. Үүнд хэвлэлийн эрх чөлөөг дэмжих, өөрийн зохицуулалтын тогтолцоо, ёс зүйн стандартыг хөгжүүлэх, эрэн сурвалжлах сэтгүүл зүйг урамшуулах зэрэг цогц, хамтын ажиллагаанд суурилсан арга хэмжээнүүд багтана. Үүний зэрэгцээ хэвлэл мэдээллийн салбарт улс төр, санхүүгийн хараат байдлыг (өмчлөлийн төвлөрөл, ил тод бус “хамтын ажиллагааны гэрээ”, “хаалтын гэрээ” гэх мэт) бууруулах, хэвлэл мэдээллийн байгууллагуудыг хуурамч мэдээлэлд өртөмтгий болгож буй бүтцийн асуудлууд уруу чиглэх хэрэгтэй.

Баримт шалгалт, инноваци болон иргэний нийгмийн өргөн хүрээний хариу арга хэмжээг дэмжих: Хуурамч мэдээлэлтэй тэмцэхэд оролцогч талууд хамтран хараат бус баримт шалгах төвүүд, сүлжээнүүдийг (тухайлбал MFCC, Fact Check Mongolia, “Facts First Mongolia” зэрэг) тогтвортой санхүүжилт, үйл ажиллагаа, дэмжих орчныг бүрдүүлэх нь чухал. Үүний зэрэгцээ хэвлэл мэдээлэл, хүний эрхийн чиглэлээр ажилладаг иргэний нийгмийн байгууллагуудын инноваци, эвсэл байгуулах, нөлөөллийн үйл ажиллагааг дэмжиж, хуурамч мэдээлэл болон мэдээллийн манипуляцийн эсрэг хамтын хүчин чармайлтыг өргөжүүлэх шаардлагатай.

Хэвлэл мэдээлэл, мэдээллийн боловсролыг (MIL) нийгмийн бүх бүлэгт чиглүүлэн өргөжүүлэх: Хуурамч мэдээлэлд өртөмтгий бүлэг рүү чиглэсэн мэдээллийн боловсролыг (MIL) дээшлүүлэхэд чиглэсэн чадавхжуулах үйл ажиллагаа нь чухал ач холбогдолтой. Одоогийн мэдээллийн боловсролын санаачилгуудын хамрах хүрээ хязгаарлагдмал боловч тэдгээр нь цаашид өргөжүүлэх боломжтой чухал бүтэц, суурь болж байна. Иймд одоо хэрэгжиж буй дижитал бичиг үсэг, мэдээллийн боловсролын санаачилгууд дээр тулгуурлан, мэдээллийн боловсролыг албан боловсролын тогтолцоонд системтэйгээр нэгтгэх, олон нийтэд суурилсан болон насан туршийн суралцах хэлбэрүүдийг өргөжүүлэх, мөн хэвлэл мэдээлэл, иргэний нийгмийн байгууллагуудыг идэвхтэй оролцуулах үндэсний хэмжээний уялдаа холбоотой хандлагыг хөгжүүлэх нь зүйтэй. Үүний тулд албан болон албан бус боловсрол, төрийн дижитал боловсролын хөтөлбөрүүд, иргэний нийгмийн санаачилгуудын хүрээнд олгогдож буй мэдээллийн боловсролын ур чадвар, мэдлэгийн хамрах хүрээг нарийвчлан зураглаж, үнэлэх шаардлагатай. Мөн оролцогч талууд мэдээллийн боловсролын агуулгыг хамтран боловсруулах, хуваалцах замаар уялдаа холбоотой, нэгдсэн мэдээллийн боловсролын хүрээг бий болгоход хамтран ажиллах нь чухал юм.

Төрийн харилцаа холбоо, ил тод байдал болон мэдээлэл авах эрхийн хэрэгжилтийг сайжруулах: Төрийн байгууллагууд хуурамч мэдээллийг цаг тухайд нь няцаахын тулд шуурхай, үр нөлөөтэй олон нийтийн харилцаа холбоог хэрэгжүүлэхийн зэрэгцээ иргэдийн мэдээлэл авах эрхийг хангахуйц идэвхтэй, утга учиртай ил тод байдлын бодлого, практикийг тогтвортой хэрэгжүүлэх шаардлагатай. Олон нийтэд мэдээллийг урьдчилан, үнэн зөв, ойлгомжтой хүргэх нь хуурамч мэдээлэл үүсч, тархах боломжийг багасгах чухал нөхцөл юм. Үүний тулд төрийн байгууллагуудын хэвлэл мэдээлэл, олон нийттэй харилцах нэгжүүд мэргэжлийн чадавхтай багтай байх, хариуцлагатай, ёс

зүйтэй харилцаа холбоог хангах тодорхой заавар, бодлоготой байх шаардлагатай. Ил тод, баримтад суурилсан нээлттэй харилцаа нь мэдээллийн хоосон орон зайг багасгаж, хуурамч мэдээлэл түүнийг ашиглах боломжийг хязгаарлана. Мөн ил тод байдал, хувийн мэдээлэл хамгаалахтай холбоотой шинэчлэлийг бүрэн хэрэгжүүлэхийн зэрэгцээ төрийн байгууллагууд мэдээллийг өөрийн үзэмжээр ангилах боломж олгодог “албаны нууц”-ын зохицуулалт зэрэг цоорхойг шийдвэрлэх шаардлагатай.

Дижитал платформ, технологийн компаниудтай тогтолцоонд суурилсан, хариуцлагатай хамтын ажиллагааг гүнзгийрүүлэх: Хуурамч мэдээлэл тархахад сошиал медиа платформуудын үүрэг давамгайл байгааг харгалзан Монгол Улс платформуудтай хэрэгжүүлж буй хамтын ажиллагааны механизмуудыг (тухайлбал “ногоон суваг”, e-Mongolia-аар дамжуулан гомдол мэдээлэх систем) хадгалах, сайжруулах нь зүйтэй. Энэхүү хамтын ажиллагаа нь тодорхой эрх, үүрэг, тодорхой процедур зарчмыг хангасан, ил тод байдлаар (хэчнээн гомдол хүлээн авсан, ямар үр дүн гарсан зэрэг) хэрэгжих шаардлагатай. Мөн контент устгах асуудлаас гадна бодит бус хаяг, зохион байгуулалттай сүлжээ, уялдаа холбоотой манипуляцийн үйл ажиллагааг илрүүлэх, таслан зогсооход чиглэсэн арга хэмжээнд түлхүү анхаарах нь чухал юм.

Ашигласан материалын жагсаалт

- Alfred, N., & Parruca, E. (2022). Impact of social media disinformation and fake news overexposure on actual capacities and psychological well-being during the COVID-19 pandemic.
- Andrzej, J., Łukasz, K., & Stanisław, M. (2023). *Biological mis(dis)-information on the internet as a possible Kremlin warfare*. Zenodo. <https://doi.org/10.5281/zenodo.8081493>
- Bateman, J., & Jackson, D. (2024). *Countering disinformation effectively: An evidence-based policy guide*. Carnegie Endowment for International Peace. https://carnegie-production-assets.s3.amazonaws.com/static/files/Carnegie_Countering_Disinformation_Effectively.pdf
- Baasanjav, U., Nielsen, P., & Myagmar, M. (2024). Patronage media in post-communist Mongolia. *Central European Journal of Communication*, 17(2(36)), 247–267. [https://doi.org/10.51480/1899-5101.17.2\(36\).573](https://doi.org/10.51480/1899-5101.17.2(36).573)
- Bandy, J., & Diakopoulos, N. (2023). Facebook's News Feed algorithm and the 2020 U.S. election. *Social Media + Society*, 9(3). <https://doi.org/10.1177/20563051231196898>
- Bayar, C. (2024). Concerns related to new information tools: Synthetic media and deepfake content. *Mongolian Journal of Humanities and Social Sciences*, 9(18), 31–42. <https://doi.org/10.69542/mjhss.v9i18.3697>
- Bennett, W. L., & Livingston, S. (2018). The disinformation order: Disruptive communication and the decline of democratic institutions. *European Journal of Communication*, 33(2), 122–139. <https://doi.org/10.1177/0267323118760317>
- Bhattacharya, S. (2025). *Unravelling the infodemic: A systematic review of misinformation dynamics during the COVID-19 pandemic*.
- Bradshaw, S., Bailey, H., & Howard, P. N. (2021). *Industrialized disinformation: 2020 global inventory of organized social media manipulation*. Oxford Internet Institute, Computational Propaganda Project.
- Broda, E., & Strömbäck, J. (2024). Misinformation, disinformation, and fake news: Lessons from an interdisciplinary systematic literature review. *Annals of the International Communication Association*, 48(2), 139–166. <https://doi.org/10.1080/23808985.2024.2323736>
- Byambasuren, Ya. (2024). *IRIM's journey towards understanding social wellbeing in Mongolia*. PPT
- Ceylan, G., Anderson, I., & Wood, W. (2023). Sharing of misinformation is habitual, not just lazy or biased. *Proceedings of the National Academy of Sciences*, 120(4). <https://doi.org/10.1073/pnas.2216614120>
- Claudia, M. E. (2022). *Psychological effects of fake news: A literature review*.
- Colomina, C., Sánchez Margalef, H., & Youngs, R. (2021). *The impact of disinformation on democratic processes and human rights worldwide*. European Parliament. [https://www.europarl.europa.eu/RegData/etudes/STUD/2021/653635/EXPO_STU\(2021\)653635_EN.pdf](https://www.europarl.europa.eu/RegData/etudes/STUD/2021/653635/EXPO_STU(2021)653635_EN.pdf)
- DataReportal. (2024). *Digital 2024: Mongolia*. <https://www.datareportal.com>
- DataReportal. (2025). *Digital 2025: Mongolia*. <https://www.datareportal.com/reports/digital-2025-mongolia>
- Denniss, E. (2025). *Social media and the spread of misinformation: Infectious and a threat to public health*. Oxford Academic.
- Deutsche Welle Akademie. (2023, June 14). *Media and information literacy in Mongolia: The global digital schoolroom*. <https://akademie.dw.com/en/mil-in-mongolia-the-global-digital-schoolroom/a-68854279>
- Edelman. (2024). *2024 Edelman Trust Barometer: Global report*. Edelman. <https://edl.mn/3vg7ZBP>
- Edson, C. T., & Kim, H. K. (2022). Avoiding real news, believing in fake news? Investigating pathways from information overload to misbelief.
- Elsner, M., Atkinson, G., & Zahidi, S. (2024). *World risk report*. World Economic Forum
- Eric, K. C., Schrieck, M., & Waran, R. V. (2025). *Managing disinformation on social media platforms*.
- Eryn, J. N., & Scoboria, A.-T. (2022). *Misinformation and the sins of memory: False-belief formation and limits on belief revision*.
- François, C. (2020). *Actors, behaviors, content: A disinformation ABC*. Algorithms.

- Freedom House. (2024). *Freedom in the World 2024: Mongolia*.
<https://freedomhouse.org/country/mongolia/freedom-world/2024>
- Galeotti, A. E. (2020). *Political disinformation and voting behavior: Fake news and motivated reasoning*.
- GGGI, & IRIM. (2023). *Climate change awareness and media consumption survey in Mongolia*.
<https://gggi.org/report/climate-change-awareness-and-media-consumption-survey-in-mongolia/>
- Globe International Center. (2021). Media Freedom Report 2020.
https://www.gic.mn/public/docs/freedom_report/media_freedom_report_2020_mn.pdf
- Hameleers, M. (2023, January 30). Disinformation as a context-bound phenomenon: Toward a conceptual clarification integrating actors, intentions and techniques of creation and dissemination. *Communication Theory*, 33(1), 1–10. <https://doi.org/10.1093/ct/qtac021>
- Humprecht, E., Esser, F., Van Aelst, P., Staender, A., & Sophie. (2021). *The sharing of disinformation in cross-national contexts*.
- Humprecht, E., Esser, F., & Van Aelst, P. (2020). *Resilience to online disinformation: A framework*.
- International Republican Institute. (2024). *National poll*. Ulaanbaatar, Mongolia.
- International Republican Institute. (2024). *Public opinion survey*.
- James, L., Renwick, A., & Russell, M. (2023, January 19). *Checks and balances: What are they, and why do they matter?* <https://constitution-unit.com/2023/01/19/checks-and-balances-what-are-they-and-why-do-they-matter/>
- Kapantai, E., Christopoulou, A., Berberidis, C., & Peristeras, V. (2021, May). A systematic literature review on disinformation: Toward a unified taxonomical framework. *New Media & Society*, 23(5), 1301–1326.
<https://doi.org/10.1177/1461444820959296>
- Kleinschmidt, J., Miniailo, A., Gabdulhakov, R., & Nguyen, C. (2023, November 30). *Perceptions of Russia's war in the Global South*. ETH Zurich. <https://doi.org/10.3929/ETHZ-B-000644957>
- Konopliov, A. (2024). *Key statistics on fake news and misinformation in media in 2024*.
- Lukavská, K., Gabrhelík, R., Miovský, M., Hynek, N., Gavurová, B., Šťastná, L., Barták, M., Petruželka, B., & Moravec, V. (2025). *Exploring disinformation: The interplay of exposure, trust, and sharing*.
- Matasick, C., C. Alfonsi and A. Bellantoni (2020), "Governance responses to disinformation: How open government principles can inform policy options", *OECD Working Papers on Public Governance*, No. 39, OECD Publishing, Paris, <https://doi.org/10.1787/d6237c85-en>.
- Marma, K. J. (2025). *The science of disinformation: Cognitive vulnerabilities and digital manipulation*.
- Marwick, A. (2018). Why do people share fake news? A sociotechnical model of media effects. *Georgetown Law Technology Review*, 2(2), 474–512.
- Meedan & Nest Center. (2025, March 5). *Meedan and Nest Center launch Mongolia's first fact-checking tipline*. Meedan. <https://meedan.com/post/meedan-and-nest-center-launch-mongolias-first-fact-checking-tipline> meedan.com
- Ministry of Education and Science. (2014). Primary education core programme.
https://api.mn.gov.mn/uploads/BAGA_BOLOVSROL_2014_67964e1b7d.pdf
- MMCG. (2021). Baseline survey of citizen' internet consumption. <https://crc.gov.mn/caxim-orcny-zoxicuulalt/caxim-orcny-sudalgaa-sinzlgee/irgediin-internetiin-xeregleenii-talaarx-suur-sudalgaany-tailan>
- MMCG. (2024). National media and lifestyle report.
- Mishra, S. (2025). *Misinformation and disinformation in the digital age: A rising risk for business and investors*.
- Mohammed Hafiz, N., & Thompson, M. (2025). *The impact of disinformation on national security policymaking: Review*.
- MUoJ. (2025–2026). *Call to journalists*.
- Mysorekar, S. (2022, April 3). *Self-regulating Mongolian media industry*. DW Akademie/D+C – Development and Cooperation. <https://www.dandc.eu/en/article/2015-media-council-mongolia-has-handled-500-ethics-complaints> [dandc.eu](https://www.dandc.eu)
- Namsrai, G. (2024). *Identifying disinformation and misinformation on election*.
- NEST. (2025). *Understanding pro-Russian disinformation narratives in Mongolia: A social listening report*. Nest Center for Journalism Innovation and Development.
- NHRCM. (2021). 20th Annual Report on the State of Human Rights and Freedoms.
[349b6c8a2917777a1ac71ea5f9a2477a.pdf](https://nhrcm.gov.mn/349b6c8a2917777a1ac71ea5f9a2477a.pdf)

- NISS. (2019, November 4). *Analysis*. National Institute for Security Studies. <https://niss.gov.mn/>
- Nord, M., Altman, D., Angiolillo, F., Fernandes, T., God, A., & Lindberg, S. (2025). *Democracy report 2025: 25 years of autocratization*. V-Dem Institute, University of Gothenburg. https://www.v-dem.net/documents/54/v-dem_dr_2025_lowres_v1.pdf
- OECD. (2024, July 10). *OECD Survey on Drivers of Trust in Public Institutions: 2024 results*. https://www.oecd.org/en/publications/oecd-survey-on-drivers-of-trust-in-public-institutions-2024-results_9a20554b-en.html
- OECD. (2025). *Drivers of trust in public institutions* (in *Government at a Glance 2025*). https://www.oecd.org/en/publications/2025/06/government-at-a-glance-2025_70e14c6c/full-report/drivers-of-trust-in-public-institutions_fe2b7742.html
- Open Society Forum. (2022). Adjudication practice of “distributing false information” crime. https://forum.mn/uploads/users/3093/files/Sud_Toim%2026%20Khudal%20medeeler%20taraakh.pdf
- Osman, M. (2024). *Disinformation is often blamed for swaying elections – the research says something else*.
- Palacios López, M., Bonete Vizcaíno, F., & Gelado Marcos, R. (2023, December 12). Nuevos agentes de desinformación masiva. *Estudios sobre el Mensaje Periodístico*, 29(4), 919–932. <https://doi.org/10.5209/esmp.88576>
- Paul, C., & Matthews, M. (2016). *The Russian “firehose of falsehood” propaganda model: Why it might work and options to counter it*. RAND Corporation. <https://www.jstor.org/stable/resrep02439>
- Petropoulos, G. (2022). *The dark side of artificial intelligence: Manipulation of human behaviour*.
- Pew Research Center. (2024, December 11). *Global elections in 2024: What we learned in a year of political disruption*. <https://www.pewresearch.org/global/2024/12/11/global-elections-in-2024-what-we-learned-in-a-year-of-political-disruption/>
- Press Councils in the Digital Age. (2024). *Mongolian Media Ethics Principles*. AIPCE. https://www.presscouncils.eu/codes/38_mn_presscouncils.eu
- Press Institute of Mongolia. (2025). *Mongolia Media Today*. Press Institute of Mongolia.
- Qing, H., & Lei, S. (2022). *Perceived information overload and unverified information sharing on WeChat amid the COVID-19 pandemic*.
- Reporters Without Borders (RSF). (2025). *Mongolia: Media landscape and press freedom ranking*. <https://rsf.org/en/country/mongolia>
- Robbins, J., Conley, H., Person, R., Golby, J., Barndollar, G., & McGlynn, J. (2020). *Countering Russian disinformation*. Center for Strategic and International Studies. <https://www.jstor.org/stable/resrep26533.8>
- RSF. (2025). *Global press freedom index*.
- Sadiq Muhammed, T., & Mathew, S. K. (2022). *The disaster of misinformation: A review of research in social media*.
- Sadler, N. (2025, July 9). Suspicious stories: Taking narrative seriously in disinformation research. *Communication Theory*. <https://doi.org/10.1093/ct/qtaf013>
- Samardzhiev, V. (2024). *Disinformation and misinformation: Threats to national security and democracy*. <https://blogs.flinders.edu.au/jeff-bleich-centre/2024/06/06/pp13-disinformation/>
- Schünemann, W. (2022). A threat to democracies? In M. Cavelti & A. Wenger (Eds.), *Cyber security politics* (pp. 32–47). Routledge. <https://doi.org/10.4324/9781003110224-4>
- Sezer Kisa, & Kisa, A. (2024). *A comprehensive analysis of COVID-19 misinformation, public health impacts, and communication strategies: Scoping review*.
- Soon, A., & Patel, R. (2022). *Mongolia: Codifying and funding the media ecosystem*. Nest Center for Journalism Innovation and Development. Retrieved November 18, 2025, from <https://www.nestmongolia.org/mongolia-codifying-and-funding-the-media-ecosystem>
- UN Development Coordination Office (UN DCO). (2025, January 14). *Bridging the digital divide in Mongolia*. UN Stories. https://un-dco.org/stories/bridging-digital-divide-mongolia_un-dco.org
- UN Mongolia. (2024, December 12). UN supports Mongolia’s effort to enhance digital literacy nationwide. UN Mongolia. <https://mongolia.un.org/en/285715-un-supports-mongolia%E2%80%99s-effort-enhance-digital-literacy-nationwide>

- UNESCO. (2021, May 27). Lutaas's journey for media and information literacy in Mongolia. <https://www.unesco.org/en/articles/lutaas-journey-media-and-information-literacy-mongolia>
- UNESCO. (2024, April 5). *Advancing media and information literacy and digital skills in Mongolia: 5th National MIL Stakeholder Forum*. UNESCO. <https://www.unesco.org>
- UNESCO. (2025, January 22). Advancing media and information literacy in Mongolia: UNESCO-supported workshops for curriculum integration. <https://www.unesco.org/en/articles/advancing-media-and-information-literacy-mongolia-unesco-supported-workshops-curriculum-integration#:~:text=With%20the%20support%20of%20the,levels%20of%20the%20education%20system>
- United Nations Development Programme. (2025, April). Annual progress report 2024: Joint programme in the seed funding track — Mongolia Digital Transformation. https://mptf.undp.org/sites/default/files/documents/2025-04/mongolia_digital_transformation.pdf#:~:text=KhurDan%20Mobile%20Unit%3A%20Expanding%20digital,service%20access%20to%20rural%20communities
- United States Department of State. (2024). *2024 Country Reports on Human Rights Practices: Mongolia*. <https://www.state.gov/reports/2024-country-reports-on-human-rights-practices/mongolia/>
- University of Baltimore, & CHEQ. (2019). *The economic cost of bad actors on the Internet*.
- Vasist, P. N., Chatterjee, D., & Krishnan, S. (2023). The polarizing impact of political disinformation and hate speech: A cross-country configural narrative. *Information Systems Frontiers*, 1–26. <https://doi.org/10.1007/s10796-023-10390-w>
- V-Dem Institute. (2016–2024). *Freedom of expression index*.
- V-Dem Institute. (2024). *Democracy Report 2024: Democracy winning and losing at the ballot*. https://www.v-dem.net/documents/43/v-dem_dr2024_lowres.pdf
- V-Dem Institute. (2025). *Democracy Report 2025: 25 Years of Autocratization*. https://www.v-dem.net/documents/60/V-dem-dr_2025_lowres.pdf
- Warin, T. (2024). *Disinformation in the digital age: Impacts on democracy and strategies for mitigation*.
- World Economic Forum. (2024). *Global risks report 2024: Insight report* (19th ed.).
- Zhao, Z., & Zhang, J. (2017). *Fake news propagate differently from real news even at early stages of spreading*.
- Zimmer, F., Scheibe, K., Stock, M., & Stock, W. (2019, June 30). Fake news in social media: Bad algorithms or biased users? *Journal of Information Science Theory and Practice*, 7(2), 40–53. <https://doi.org/10.1633/JISTAP.2019.7.2.4>

Монгол хэл дээрх эх сурвалжууд

- Б.Тэргэл. (2021). *Цар тахлын үед олон нийтийн сүлжээ сайтуудын нийгэмд үзүүлсэн нөлөө ба инфодемик: Монгол Улс Фэйсбүүкийн жишээн дээр*.
- Б.Эрдэнэбаатар. (2023). Иргэдийн цахим ур чадвар, түүнд нөлөөлөх хүчин зүйл. *Монголын залуу эрдэмтдийн холбоо, Нийгмийн шинжлэх ухааны залуу эрдэмтдийн холбоо*, 145–158.
- Г.Ганбат. (2024). Жижиг орнууд уруу чиглэсэн хуурамч мэдээлэл (SpaceTalk ярилцлага).
- Г.Туяагэрэл, & Э. Эрдэнэцэцэг. (2024). Төрөөс хэвлэл мэдээллийн байгууллагад олгодог санхүүжилтэд хийсэн шинжилгээ. *Политологи*, 22, 154–163.
- Д.Идэржаргал. (2017). Фэйсбүүкийн алгоритм хуурамч мэдээлэл түгээхэд нөлөөлөх нь. *Сэтгүүл зүй*, 479(18). <https://journal.num.edu.mn/journalism/article/download/7109/6281/13417>
- Д.Идэржаргал. (2018). Хуурамч мэдээний үр нөлөөг сэтгэл зүйтэй холбон тайлбарлах нь. *Ikon.mn*.
- Д.Идэржаргал, & Б. Маралмаа. (2023). Улс төрийн мэдээлэл, харилцаанд Инстаграмыг ашиглаж буй туршлага, шаардлага. *Сэтгүүл зүй*, 24, 54–61. <https://journal.num.edu.mn/journalism/article/view/6844>
- Д. Жаргалсайхан. (2019). *Индэр*. Ikon.mn. <https://ikon.mn/opinion/1oi6>
- Eguur.mn. (2022). “Эгүүр”-ийн сэдэв: Монголын мэдээллийн сайтууд яагаад гажуудав. Бид хаашаа явах ёстой вэ? <https://eguur.mn/320287/>
- Eguur.mn. (2025, 5 дугаар сарын 3). “Эгүүр”-ийн сэдэв: Төрийн хэвлэлийн алба үүргийн дагуу ажиллаж байна уу? Тэдний хөгжлийн чиг хандлага юу вэ? <https://eguur.mn/588768/>
- Fact Check Mongolia. (2021). *Баримт нягталж шалгах гарын авлага*. Улаанбаатар: Fact Check Mongolia. <https://factcheck.mn/fact-checking-guide>
- IRIM. (2018; 2022). *Монголчуудын нийгмийн сайн сайхан байдлын судалгаа*.
- MCIR. (2021). *2021 оны Монгол Улсын Ерөнхийлөгчийн сонгуулийн сурталчилгааны үеийн фэйсбүүк дэх хүний эрх, хэвлэлийн эрх чөлөөний хэрэгжилт: Мониторингийн тайлан*. Улаанбаатар: Эрэн сурвалжлах сэтгүүлчдийн төлөө төв.
- MFCC. (2023, 12 дугаар сарын 25). Монгол Улсын нийт гадаад өр 33.7 тэрбум ам.доллар байхад “гадаад өрийн дарамтнаас бүрэн саллаа” гэж төөрөгдүүлж байна. <https://mfcc.mn/factcheck-796/>
- MMCG. (2021). *Монголчуудын интернэт хэрэглээний талаарх суурь судалгааны тайлан*.
- News.mn. (2025, 9 дүгээр сарын 26). Улаанбурхан өвчнөөр 10–14 насныхан хамгийн их өвдсөн байна. <https://news.mn/r/2825133/>
- OptimalNMax. (2024). *Цахим орчин дахь хуурамч мэдээллийн тархалт болон нөлөөлөгч хүчин зүйлсийн судалгаа*. Улаанбаатар.
- Posetti, J. (2021). *Disinfodemic* буюу хуурамч мэдээллийн цар тахал: COVID-19-тэй холбоотой хуурамч мэдээллийг ухаж ойлгох нь.
- Хэвлэлийн хүрээлэн. (2016). *Хэвлэл мэдээллийг хэн эзэмшдэг вэ?* Улаанбаатар: Хэвлэлийн хүрээлэн.
- Хэвлэлийн хүрээлэн. (2021). *Хэвлэл мэдээллийн мониторингийн тайлан*. Улаанбаатар.
- Хэвлэлийн хүрээлэн. (2025). *Монголын хэвлэл мэдээлэл – Өнөөдөр*. Улаанбаатар
- ХЗҮХ. (2022). *Цахим орчин дахь хүний эрхийг хамгаалах асуудал*.
- ХЭҮК. (2024). *Хүний эрхийн багц хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай санал*.
- ҮСХ. (2021). *Өрхийн болон хувь хүний мэдээлэл, харилцаа холбоо, технологийн хэрэглээний түүвэр судалгаа*.
- Я.Борчулуун, & Д.Идэржаргал. (2019). Фэйсбүүк сүлжээнд Монгол хэл дээр тархсан хуурамч мэдээний судалгаа. *Сэтгүүл зүй*, 524(20), 225–239. <https://journal.num.edu.mn/journalism/article/view/7036>
- 185/2021/0460/Э, 2021/ШЦТ/583. (2021, 8 дугаар сарын 23). *Сүхбаатар дүүргийн Эрүүгийн хэргийн анхан шатны шүүхийн шийдвэр*. https://shuukh.mn/single_case/59694

